



БОЛОВСРОЛООС ХӨНДИЙРЧ БУЙ ХӨВГҮҮД



ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



БОЛОВСРОЛООС ХӨНДИЙРЧ БУЙ ХӨВГҮҮД

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2024 он

Судлаач Т.Эмүжин, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан
Хянасан Я.Мөнхчимэг, Д.Тунгалаг
Гэрэл зургийг Д.Давааням

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Боловсролын төлөө чанга дуугар!” төслийн санхүүжилтээр хийж гүйцэтгэв.

EDUCATIONOUTLOUD
advocacy & social accountability

GPE Transforming
Education

АГУУЛГА

Өмнөх үг	7
Судалгааны үндэслэл, зорилго.....	9
Судалгааны арга зүй.....	11
Судлагдсан байдлын тойм	12
Бүлэг 1: Хөвгүүдийн боловсролоос хөндийрөхөд нөлөөлж буй хүчин зүйлс..	15
Микросистемийн нөлөөлөл:	15
1. Хувь хүн.....	15
2. Гэр бүл	16
3. Үе тэнгийнхэн.....	19
Мезосистемийн нөлөөлөл:.....	21
1. Газар зүйн байршил	21
2. Сургуулийн нөлөөлөл	22
3. Үндэстний цөөнх	24
Макросистемийн нөлөөлөл:	25
1. Нийгэм, эдийн засаг	25
2. Уламжлалт соёл, байгалийн баялагтай бүс нутаг	26
3. Гэмт хэрэг	27
4. Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт	27
5. Сургалтын хөтөлбөр, үнэлгээ	28
6. Түвшин хоорондын шилжилт	28
7. Сургуулийн дэд бүтэц.....	28
8. Нийгмийн сөрөг хандлага	29

Бүлэг 2: Монгол улсын хөвгүүд боловсролоос хөндийрөхөд нөлөөлж буй хүчин зүйлс.....30

Монгол улсын сургуульд хамрагдалт 30

Монгол улсын pisa 2022 үнэлгээний үр дүн (хүйсээр) 31

Микросистемийн нөлөөлөл: 32

1. Хувь хүн..... 32

2. Гэр бүл 33

3. Үе тэнгийнхэн..... 37

Мезосистемийн нөлөөлөл:..... 39

1. Соёл, уламжлал, зан заншил..... 39

2. Сургууль 42

3. Медиа, хэвлэл мэдээллийн байгууллага..... 48

Макросистемийн нөлөөлөл: 52

1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 52

2. Нийгэм, эдийн засгийн ялгаатай байдал 55

3. Газар зүйн байршил 55

4. Жендэрийн бодлого 61

5. Эрэгтэй багшийн дутагдал..... 63

6. Хөвгүүдийн онцлогт тохироогүй сургалтын хаталберийн бодлого 63

Бүлэг 3: Хөвгүүдийн боловсролоос хөндийрч буй асуудалд хэрэгжүүлэх бодлогын сайн туршлага.....65

Микросистемийн түвшин 65

Мезосистемийн түвшин 67

Макросистемийн түвшин..... 68

Дүгнэлт72

Санал, зөвлөмж.....75

Ном зүй78

Хавсралт80

ӨМНӨХ ҮГ

Бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол, бага дунд боловсролыг хүртээмжтэй олгох бидний амлалт хаана явж байгааг иргэний нийгмийн байгууллагууд байнга хянаж үнэлж байдаг. Бид хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, жирэмсэн охид гээд бүлгүүдийн сурч боловсрох эрхээ эдэлж байгаа эсэхэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, бодлогын нөлөөллийг хийж ирсэн ч хөвгүүдийг орхигдуулсаар байсан юм. Гэхдээ бидний өмнө тодорхой бүлгийн хүүхдүүдийг тэгш хамруулан сургаж чадаж байгаа эсэх талаар хийсэн судалгаануудад хөвгүүдийн асуудал хөндөгдсөөр байсан бөгөөд боловсрол ба жендэрийн асуудлыг холбон судлахад хөвгүүд боловсролын шат түвшингээр дээш ахихгүй байгаа тухай тоо баримт гарч ирсээр байсан.

2023 онд танилцуулагдсан Сурлагын амжилтын олон улсын үнэлгээний (PISA) дүнг харахад шалгуулсан хичээлүүдээр хөвгүүд охидоос доогуур үнэлэгдсэн дүн гарсан нь бидний анхаарлыг татсан. Мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт, эрүүл мэндийн доройтол, архинд донтох, хүчирхийлэл үйлдэх, амиа хорлолт нэмэгдсэн зэрэг олон асуудлын хариулт тэдний хөвгүүн байх үетэй, тэдний боловсрол эзэмших байдалтай уялдаатай байж болох таамаглал дэвшүүлэн энэхүү судалгааг эхлүүлсэн билээ.

Монголчууд охидоо илүүд үздэгээс, охиддоо сурах боломж олгодгоос хөвгүүд боловсролын хувьд, хөгжлийн хувьд хоцрогддог гэсэн “модон”, уг шалтгааныг халхавчлах тайлбараас цааш ухаж, дэлхийн бусад орнуудтэй харьцуулж, Монголын нөхцөлийг тодруулж үзэн, хөвгүүдийг боловсролоос хөндийрөхөд хүргэж, хүчтэй нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойллоо.

Хүн амын олонхыг хамарсан ядуурал, өрхийн орлого амьжиргаанд нь хүрэхгүй байгаагийн илрэл хөвгүүд дээр тусаж буйг судалгаа харууллаа. Нийгэм-эдийн засгийн статус доогуур (ядуу, амьжиргааны түвшин доогуур) өрхийн хүүхдэд сурч боловсроход нь дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа халамж хамгааллын бодлогын цоорхойг илрүүллээ.

Мөн Монголд жендэрийн асуудал байхгүй, боловсролд бүүр байхгүй гэдэг

харалган бодлого шийдвэр гаргагчдын хандлага, үйлдлээс болж хөвгүүд олноор сургуулийн гадна үлдэж, сургууль завсардаж байгааг тодоор хэлсэн. Боловсролын салбар жендэрийн мэдрэмжтэй бодлого, төсөв боловсруулж, багш удирдах ажилтнуудын жендэрийн хэвшмэл ойлголт, сөрөг хэм хэмжээ, өрөөсгөл хандлага зэрэгт анхаарах, хөвгүүдэд чиглэсэн эерэг нөлөөллийн, нийгэм-сэтгэлзүй, нийгэмшлийн хөтөлбөрүүд хэрэгтэй болсныг сануулж байна.

Судалгааны мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан Завхан, Хөвсгөл аймаг, Налайх дүүргийн салбар зөвлөл болон Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбооны гишүүдэд талархал илэрхийлж байна. Судалгааны тайлангийн эхний үр дүнтэй танилцан санал, шүүмж өгсөн гишүүн байгууллагууддаа баярлалаа. Та бүхний шүүмжит санал, бүтээлч зөвлөмжгүйгээр энэ судалгаа эцэслэн гарах боломжгүй билээ. Эцэст нь залуу судлаач Т.Эмүжинд талархал илэрхийлье. Таны нягт нямбай ажиллагаа, хүний эрх, жендерийн мэдрэмж, иргэний нийгмийн байгууллагатай хүндэтгэлтэй ойлголцож ажилласан явдалд гүнээ талархаж байна.

Дондогдуламын Тунгалаг

*“Бүх нийт боловсролын төлөө!”
Иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч*



СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Монгол Улс 2022 онд хамрагдсан PISA олон улсын сурлагын амжилтын үнэлгээний үр дүнгээр хөвгүүд охидуудаас математик, унших, байгалийн ухааны гэсэн хичээл дээр доогуур амжилт үзүүлсэн байгаа бөгөөд унших чадвараар 1-ээс илүү жилийн хоцрогдолтой гэж дүгнэгдсэн. БШУЯ-ны 2022-2023 оны хичээлийн жилийн Ерөнхий боловсролын албан ёсны статистик мэдээний бага боловсролоос суурь боловсрол руу дэвшин суралцагчдын төгсөлтийн хувь, суурь боловсролоос бүрэн дунд боловсрол руу дэвшин суралцагчдын төгсөлтийн хувийг харахад суурь боловсрол төгсөгчдийн дунд охид, хөвгүүдийн харьцаа ерөнхийдөө адил байсан бол бүрэн дунд боловсрол төгсөх үед хөвгүүдийн эзлэх хувь охидоос 12,7 хувиар бага буюу хөвгүүдийн 50 хувь нь л бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын (“Алсын хараа-2050”) 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ” гэж зорьсон. Энэхүү бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.1.21-д “Суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг тогтмол хийж, үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт хийж хэвшинэ” гэсэн боловч одоог хүртэл энэ талаар дорвитой судалгаа хийгдээгүй байна.

Боловсролын хүрээлэнгээс 2020 онд “Боловсролын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн бодлогын судалгааг” хийж, суралцахуйн чанарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэсэн оролдлогуудыг тодорхойлсон ба холбогдох бодлогын 44 баримт бичигт шинжилгээ хийж үзээд, суралцахуйн чанарт тулгамдаж байгаа хөвгүүдийн боловсролтой холбоотой 2 үр дүн гарсан байна. Тухайлбал, сургалтад ялгаатай байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх тал дээр учир дутагдалтай (Асуудал 36) байгааг авч үзээд боловсрол дахь жендэрийн тэгш бус байдал, ялангуяа суурь боловсролын элсэлтээс бүрэн дунд боловсролыг төгсөж их дээд сургуульд элсэх хүртэлх үе шатанд хөвгүүдийн амжилтыг ахиулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн сургууль завсардалтад (ялангуяа



хөвгүүдийн) нөлөөлж буй хүчин зүйлийг багасгах арга хэмжээ авах 2 санал дэвшүүлсэн байна.

Иймд уг судалгаа нь Монгол Улсад хөвгүүд боловсролд хамрагдалт өндөр байгаа ч бүрэн дунд боловсролоос эхлэн хөвгүүд сургуулиас гарч, сурлагын амжилтаар охидоос хоцрогдож, боловсролын шат түвшнээр дээш ахихгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулж, жендэрийн мэдрэмжтэй боловсролын бодлого боловсруулахад зориулан зөвлөмж гаргах зорилготой.

СИНИН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд чанарын болон тоон судалгааны аргыг ашигласан. Үүнд баримт бичгийн судалгаа, ганцаарчилсан ярилцлага, ажиглалт, харьцуулалтын аргууд багтана. Судалгааны эхний үе шатанд өмнө нь хийгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл болон бодлогын судалгаанууд, боловсролын статистик мэдээлэлд нарийвчлан дүн шинжилгээ хийж, Перу, Арабын нэгдсэн эмират, Фижи, Кувейт, Лесото зэрэг улсын кейсийг харьцуулан судалсан. Улмаар Монгол Улсын нөхцөл байдлын чанарын мэдээллийг аймаг, дүүрэг, сумдын 10 жилээс дээш хугацаагаар ажилласан эрэгтэй, эмэгтэй нийт 10 багш, боловсрол, жендэр судлалын салбарын 4 эксперт, БШУЯ-ны мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлага хийж цуглуулсан.

Судалгааны үр дүнг боловсруулахдаа ЮНЕСКО-ийн “Хөвгүүд боловсролоос хөндийрөх нь: Дэлхий нийтийн тайлан”-д ашигласан Бронфенбрэннэрийн (Bronfenbrenner) экологийн системийн онолд тулгуурласан. Энэхүү экологийн систем нь хүүхдийн хөгжилд нийгмийн орчны үзүүлэх нөлөөг тайлбарлахад ашиглагддаг хүлээн зөвшөөрөгдсөн загвар юм. Хүүхдийн хөгжилд нөлөө үзүүлдэг олон талт харилцан нөлөөт хүчин зүйлүүдийг микросистем (хувь хүн, гэр бүл, үе тэнгийнхэн), мезосистем (боловсролын байгууллага, уламжлал) болон макросистем (боловсролын бодлого, төрийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн зах зээл, соёл)-ийн түвшинд ангилан авч үздэгээрээ онцлог.

Дэлхий даяар ерөнхийдөө хөвгүүд, эрэгтэйчүүд давуу эрх эдэлж, эдийн засгийн оролцоо, боломж, улс төрийн эрх мэдлэлд эмэгтэйчүүдийн хувьд жендэрийн ноцтой зааг үүссэн байгаа¹ ч орхигдож үлдээд байгаа хөвгүүд, залуу эрэгтэйчүүдийн боловсролын асуудалд анхаарах² нь чухал байгааг хэлэх нь зүйтэй. Жендэр нь ядуурал, оршин суугаа газар, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, шашин, хэл, шилжилт хөдөлгөөн, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэг шинжүүдтэй огтлолцох, давхцах байдлыг авч үзэх, энэ нь хэрхэн хөвгүүдийг боловсролоос хөндийрүүлж байгааг харах интерсекшнл дүн шинжилгээ ач холбогдолтой байлаа. Энэхүү судалгааны тайланд хөвгүүдийн боловсролоос хөндийрөх байдлыг шийдвэрлэж байгаа бусад улсын орны сайн туршлага, бодлого, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл багтаасан.

1 Дэлхийн эдийн засгийн чуулган, 2021

2 ЭЗХАХБ, 2021с

СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Энэхүү сэдвээр бусад улсуудад хийгдсэн судалгаа элбэг боловч Монгол Улсын хувьд салбарын суурь судалгаанаас өөрөөр асуудлыг дагнан судалсан бүтээл ховор байна. Монгол улсад хөвгүүдийн боловсролын асуудлаар тусгайлан 2 судалгаа хийгдсэн ч үр дүн нь хэвлэгдээгүй байна.

2010 онд “Хөвгүүдийн боловсролд нөлөөлж байгаа хүчин зүйлс” судалгааг³ хамран сургалт, ирц-оролцоо, сурлагын амжилт хүрээнд хийсэн ба хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, ялангуяа багш нарын зүгээс үзүүлдэг бие махбодын шийтгэл, сахилга батыг хүч хэрэглэн тогтоох байдал газар авсан нь хөвгүүд сургуульд явах дургүй болох нэг гол хүчин зүйл болохыг дурдсан байна. Хэрэв тухайн хүүхэд шилжиж ирсэн өрхийн эсвэл бага орлоготой өрхийн хүүхэд байвал сургуулиас гарах магадлал өндөр байгааг гаргаж иржээ. Хүүхэд төвтэй сургалтын арга зүй, хүүхдэд ээлтэй орчны тухай бодлогын баримт бичгийн хэрэгжилт сул, үе тэнгийн дээрэлхэлт, хууль бус төлбөр хураамж нөлөөтэй байгааг дурдаад олон ээлжтэй сургууль, даац хэтэрсэн анги дүүргэлтээс үүдэлтэй боловсролын чанар доогуур байгаа нь хөвгүүдийн боловсролын байдалд тулгамдаж байна гэж үзсэн. Хичээлээс гадуур ажил зохион байгуулах боломжгүй байгаа нь сургуулийн сэтгэл татах байдлыг дордуулж, монгол бичигт гэнэт шилжих, дотуур байрыг төлбөртэй болгох зэрэг бодлогын чанартай хүчин зүйлс нөлөөтэй байна гэж үзжээ. Албан бус боловсролын талаар статистик цуглуулах, сүм хийдийн дэргэдэх сургуульд тавих хяналтаа сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлэх, боловсролын бодлого, практикийг жендэрийн мэдрэмжтэй болгох, эр жендэрийн хэвшмэл ойлголтыг халах, жендэрийн эерэг шинж чанар, зан үйлийг дэмжин хөгжүүлэхэд анхаарах, сургууль дээрх хүүхэд хамгааллыг боловсронгуй болгох зөвлөмжийг өгсөн байна.

“Боловсролын салбарын жендэрийн дүн шинжилгээ: Хөвгүүдийн боловсролд анхаарах нь” судалгааг 2019 онд хийсэн ба сургалтын хөтөлбөрийн нийцгүй

3 Undarya, T., and Enkhjargal, D., 2011, 'Factors that Impact on Boys' Education (Enrollment, Attendance and Achievement): Qualitative Study commissioned by UNICEF Mongolia 2010'. Unpublished Manuscript.

байдал, багш нарын жендэрийн мэдрэмжгүй байдал, хөвгүүдийн зан байдлын талаарх хэвшмэл ойлголт, хөвгүүдийн онцлогт нийцээгүй багшлах арга зүй, эцэг эхийн боловсролд хандах хандлага, сургуулийн дотуур байранд хөвгүүд хараа хяналтгүй байгаа зэрэг хүчин зүйл нөлөөтэй болохыг илрүүлсэн байна. Хөвгүүдийн хичээл хоцролт таслалтыг хянах, чөлөөт цагаа өнгөрөөх байдлыг анхаарч чиглүүлэх, багш нар хөвгүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хичээл төлөвлөх, зохион байгуулах ур чадвараа сайжруулах, жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр, багшлах арга зүйг хэрэглэх, багш бэлтгэх хөтөлбөрт өөрчлөлт хийх зөвлөмж тусгажээ.


Сургууль завсардалт- ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгээс сургууль завсардсан хүүхдүүдийн статистик мэдээлэлд үндэслэн өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлагыг дэлхийн болон бүс нутгийн түвшинд гаргасан.⁴ Дэлхийн дунджаар бол охидын сургууль завсардалт хөвгүүдийнхээс илүү байгаа боловч бүс нутгийн түвшинд ялгаатай дүр зураг харагдаж байна. 2018 оны мэдээллээс (Зураг 1) харвал Латин Америк болон Карибын тэнгис, Европ, Хойд Америкийн бүс нутгуудад бага ангийн хөвгүүдийн сургууль завсардалтын хувь нь охидынхоос илүү байна. Харин Өмнөд Ази, Зүүн болон Зүүн өмнөд Ази, Латин Америк болон Карибын тэнгисийн орнуудад дунд ангийн хөвгүүдийн сургууль завсардалтын хувь нь охидынхоос илүү байна. Бусад бүс нутгуудад ерөнхийдөө охидын сургууль завсардалт хөвгүүдийнхээс илүү эсвэл хүйсийн тэгш байдал хангагдсан үзүүлэлттэй байгаа хэдий ч бүс нутгийн үзүүлэлт нь бага орлоготой орнууд дахь хөвгүүдэд тулгарч буй боломж бололцооны гачигдлыг харуулж чадахгүй. Мөн өндөр орлоготой Бельги, Финланд, Ирланд, Шинэ Зеланд, Швед зэрэг хэд хэдэн орны хувьд дунд ангийн түвшинд хөвгүүдийн оролцоо охидынхоос бага хэвээр байна.⁵



4 UNESCO, Fact Sheet no. 56. New Methodology Shows that 258 Million Children, Adolescents and Youth Are Out of School (2019), <https://uis.unesco.org/sites/default/files/documents/new-methodology-shows-258-million-children-adolescents-and-youth-are-out-school.pdf>, Last accessed 2024.09.6

5 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 31, https://www.unesco.org/fileadmin/user_upload/22_381105eng.pdf, Last accessed 2024.09.6

Зураг 1. Сургууль завсардалтын жендэрийн эрх тэгш байдлын индекс, 2018 болон түүнээс хойших жил



Анги улирах- Энэ нь сурлагын амжилт муу байгааг илэрхийлэхээс гадна сургууль завсардахад чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйл юм. ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгээс цуглуулсан мэдээллийг харахад дэлхийн хэмжээнд анги улирах түвшин буурч байгаа хэдий ч мэдээлэл өгөгдсөн улсуудын ихэнхид хөвгүүдийн анги улиралтын түвшин охидынхоос өндөр байна. Ялангуяа Алжир, Эсватини, Лесото, Марокко, Намиби, Өмнөд Африк зэрэг Өмнөд болон Хойд Африкийн бүс нутгийн орнуудад хөвгүүд, охидын дундах ялгаа хамгийн их байв. Мөн Европын холбооны судалгаанаас харахад хөвгүүд охидоос илүү улиран суралцдаг байна. Жишээлбэл, Словени улсад 2019/2020 оны хичээлийн жилд анги улирсан сурагчдын 62 хувь нь, Словакт 57 хувь нь хөвгүүд байжээ.⁶

PISA 2022 үнэлгээний үр дүн- ЭЗХАХБ-ын орнуудын PISA 2022 үнэлгээний дундаж онооны хувьд математикийн хичээлээр хөвгүүд охидоос есөн оноо, унших чадвараар охид хөвгүүдээс 24 оноогоор илүү байгаа ба байгалийн ухааны хичээлээр охид, хөвгүүдийн гүйцэтгэлийн ялгаа мэдэгдэхүйц биш байгааг тайлагнасан⁷ ч улс болгоны дүр зураг өөр харагдаж байна. Энэ талаар хавсралт 1-ээс үзнэ үү.

6 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 34

7 OECD (2023), PISA 2022 Results (Volume I): The State of Learning and Equity in Education, PISA, OECD Publishing, Paris, 27, <https://doi.org/10.1787/53f23881-en>. Last accessed 2024.09.6

БҮЛЭГ 1: ХӨВГҮҮДИЙН БОЛОВСРОЛООС ХӨНДИЙРӨХӨД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Энэ бүлэгт бусад улс оронд хөвгүүд боловсролоос хөндийрөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг микро, мезо, макросистемийн түвшинд ангилан авч үзсэн.

МИКРОСИСТЕМИЙН НӨЛӨӨЛӨЛ

Микросистемийн нөлөөлөлд хувь хүн, гэр бүл, үе тэнгийнхнээс шалтгаалсан хүчин зүйлс орно. Хувь хүнээс хамаарах нөлөөлөлд хөвгүүдийн сурах хүсэл эрмэлзэл, чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал, хобби зэрэг багтах бол гэр бүлийн нөлөөлөлд эцэг эхийн жендэрийн хэвшмэл ойлголт, гэр бүлийн тааламжгүй орчин, өрхийн тэргүүний боловсролын түвшин, эцэг эх боловсролд дэмжлэг үзүүлэхгүй байх, аавын нөлөөлөл зэрэг хамаарч байна. Харин үе тэнгийнхний нөлөөлөлд үе тэнгийнхний жендэрийн хэвшмэл ойлголт, боловсролд хандах хандлага, тэднийг даган дуурайхаас үүдэлтэй дарамт, муу үлгэр дуурайл зэрэг хүчин зүйлс хамаарч байна.

1. Хувь хүний түвшинд

Хүсэл эрмэлзэл Хөвгүүдийн боловсролд нөлөөлдөг хувийн шинж чанар нь сурах хүсэл эрмэлзэл багатай байх юм. Энэ талаар Кувейт улсад хийгдсэн судалгааны ярилцлагад оролцогч эмэгтэй багш “Бидэнд охид илүү боловсрол эзэмших зорилготой юм шиг санагддаг. Харин хөвгүүд ихэвчлэн тодорхой зорилгогүй, хүсэл эрмэлзэл багатай байдаг. Кувейт хөвгүүд сургуульдаа амжилттай сурахгүй бол цэрэг эсвэл цагдаа болно гэдэг” гэж хариулжээ. Түүнчлэн ярилцлагад оролцогч нэгэн охин “Бид хөвгүүдээс илүү хүсэл эрмэлзэлтэй. Учир нь хөвгүүд ямар нэгэн ажлыг хийж чадна. Харин бид чадахгүй” гэсэн байна. Үүнээс харахад хөвгүүд боловсрол эзэмших хүсэл эрмэлзэл багатай байх нь тэдний сурлагын амжилтанд нөлөөлөхөөр байна. Мөн хөвгүүд хүсэл эрмэлзэл

бага байгаа нь тэдний дундах жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой байх магадлалтай.

Чөлөөт цаг Индонез улсад хийгдсэн судалгааны үр дүнд охид чөлөөт цагаараа гэртээ байдаг бол хөвгүүд дугуй унах, хөлбөмбөг тоглох, онлайн тоглоом тоглоход чөлөөт цагаа зарцуулдаг болохыг тогтоожээ.⁸ Үүний үр дүнд хөвгүүдийн хичээл давтах, гэрийн даалгавар хийх цаг багасч, сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

2. Гэр бүл

Эцэг эхийн жендэрийн хэвшмэл ойлголт Эцэг эхчүүдийн зүгээс гэрийн ажил үүргийг хуваарилах, хүүхэд хүмүүжүүлэх болон хүүхдээсээ хүлээх хүлээлт нь охид хөвгүүдэд ялгаатай байдаг. Хөвгүүдэд гэрийн гаднах ажил ногдуулдаг бол гэр доторх ажлыг охидод хуваарилдаг.⁹

Жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн хэм хэмжээ нь эцэг эхчүүдийн хүүхдэдээ ялгаатай эрх чөлөөг олгож байгаагаар илэрнэ. Хөвгүүд гадаа илүү их цагийг өнгөрөөх, охидод гэрт илүү их цагийг өнгөрөөх нөхцөл бүрдүүлдэг. Энэ хандлага нь хөвгүүдийн сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлдөг. Үүнийг Кувейт, Пакистан¹⁰ улсуудад хийсэн судалгаа нотолсон. Гэр бүлүүдийн хүүхэд хүмүүжүүлэх арга ухаан нь охидыг сэтгэл хөдлөлөө бүрэн илэрхийлж байхаар өсгөдөг бол хөвгүүдийг аль болох сэтгэл хөдлөлийг нь дарж хүмүүжүүлдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдсан.¹¹ Түүнчлэн эцэг эхчүүд боловсролын шат түвшин ахих үйл явцад хүүхдээсээ хүлээх хүлээлт нь охид хөвгүүдэд ялгаатай байна. Кувейт улсын нэгэн эцэг эх “охид ирээдүй, эрх чөлөөгөө баталгаажуулах, санхүүгийн хувьд хараат бус байх, гэрээсээ гадуур найз нөхөдтэй байхын тулд ихэвчлэн боловсролоо үргэлжлүүлэх хүсэлтэй байдаг” гэж хэлжээ.¹²

Үүнээс дүгнэхэд эцэг эхчүүдийн ажил үүргийн хуваарилалтын талаарх жендэрийн хэвшмэл хандлага, хөвгүүдэд хэтэрхий их хайр энхрийлэл, эрх чөлөө олгох зэрэг нь хөвгүүдийн хичээл давтах цагийг багасгах, хариуцлагатай байдлыг сулруулах зэргээр сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлдөг. Мөн хүүхдээ хүмүүжүүлэхдээ хөвгүүдийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх байдлыг дарж, боловсрол эзэмших явдалд хөвгүүдээс хүлээх хүлээлт нь охидоос бага байгаа нь тэдний зан чанар, сэтгэл зүйн асуудал, сурах хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлж, сурлагын амжилт муудах, сургууль завсардахад түлхэц болдог байна.

8 USAID, Boys' underachievement in education: a review of the literature with a focus on reading in the early years (2016), 17, https://ierc-publicfiles.s3.amazonaws.com/public/resources/BoysUnderachievementLitReview_14Sep2016_Final.pdf, Last accessed 2024.09.6

9 UNGEI, Changing Patterns in Boys' Education Discussion Summary (2016), 16-17, <https://www.ungei.org/sites/default/files/Boys-Education-Discussion-Summary-2016-eng.pdf>, Last accessed 2024.09.6

10 Ullah, Raza, and Hazir Ullah. 2021. "Teachers' Perspectives on Boys' Underperformance in Education in Khyber Pakhtunkhwa, Pakistan". Journal of Elementary Education 14 (1), 115-16, <https://doi.org/10.18690/rei.14.1.113-123.2021>, Last accessed 2024.09.6

11 Ibid, 16-17

12 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 49

Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсролд хангалттай дэмжлэг үзүүлэхгүй байх нь сурлагын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйл болдог. Эцэг эхийн жендэрийн хэвшмэл хандлага, эцгийн эрхт ёсны соёл уламжлал нь хөвгүүдийг амжилттай суралцахад дэмжихгүй байсан ч биеийн хүчний ажил хийж амьжиргаагаа аваад явах боломжтой гэх хандлагаас үүдэлтэй. Боловсролын салбарынхан үзэхдээ, “Эцэг эхчүүд сурагчдад гэрийн даалгавраа хийхэд нь сайн тусалдаггүй, тиймээс тэд шаргуу хичээллэж, гүйцэтгэлээ сайжруулах урам зориггүй болдог”¹³, “Эцэг эхчүүд хөвгүүдээс илүү охидыг боловсрол эзэмших боломжоор хангадаг. Зарим сургуулийн эцэг эхчүүд эхлээд охидод, дараа нь хөвгүүдэд ном худалдаж авдаг” гэж мэдээлсэн.¹⁴ Үүнээс дүгнэхэд хөвгүүд боловсрол эзэмшихэд эцэг эхийн оролцоо, материаллаг дэмжлэг, анхаарал хангалтгүй байгаагаас үүдээд хөвгүүдийн сурах хүсэл эрмэлзэл буурах, сурлагын амжилт муудах сөрөг үр дагаварт хүрдэг байна.

Гэр бүлийн тааламжгүй орчин нь сурагчдын сурлагын амжилтад гол үүрэг гүйцэтгэдэг хүчин зүйл. Хүүхдүүдэд аюулгүй, эмх цэгцтэй, тоглох, суралцах боломжтой, хайр, халамжийг мэдрүүлсэн орчин хамгийн тааламжтай байдаг. Фижи улсад хийгдсэн судалгаагаар сурагчдын урам зоригийг нэмэгдүүлэхийн тулд гэрийн тохижилт, тавилга, хичээл хийх орон зай, сургалтын хэрэглэгдэхүүн зэргээр гэрийн суралцах орчныг сайжруулах ёстой гэж хэмээн боловсролын салбарын оролцогч талууд үзсэн байна.¹⁵ Арабын нэгдсэн эмират¹⁶, Кувейт¹⁷ улсуудад хийгдсэн судалгаа гэр бүл салалт, эцэг эх нь хүүхдэдээ зориулж буй цаг, хүчирхийллийн аливаа хэлбэрт өртсөн эсэх, эрүүл мэндийн асуудал, гэр бүлийн гишүүн нас барах зэрэг нь хүүхдийн боловсрол, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлдөг гэж дүгнэжээ.

Гэр бүлийн тааламжгүй орчин, нөхцөл гэдэгт гэрийн биет орчин болох тав тухгүй, эмх цэгцгүй байдал орохоос гадна сэтгэл зүйн хувьд асуудал үүсгэх гэр бүл салалт, бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэл, гэр бүлийн хэн нэгэн нас барах, эцэг эхийн анхаарал, халамжгүй байдал зэрэг хамаарч байна. Эдгээр гэр бүлийн тааламжгүй орчин хөвгүүдэд илүүтэй сөргөөр нөлөөлдөг. Гэхдээ гэр бүлийн тааламжгүй орчинд хамаарах нөхцөл байдлууд дангаараа нөлөөлөгч хүчин зүйл болохгүй бөгөөд бусад микро, мезо, макросистемийн хүчин зүйлстэй

13 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Lesotho case study (2022), 40-41, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000381155/PDF/381155eng.pdf.multi>, Last accessed 2024.09.6

14 UNGEI, Changing Patterns in Boys' Education Discussion Summary (2016), 15

15 UNESCO, Leave No Child Behind: A Case Study of Fiji (2022), 40-41, https://unesdoc.unesco.org/in/documentViewer.xhtml?v=2.1.196&id=p::usmarcdef_0000382274&file=/in/rest/annotationSVC/Download-WatermarkedAttachment/attach_import_81eb1df7-6a3b-4c10-81a3-bc06d67df991%3F_%3D382274eng.pdf&updateUrl=updateUrl5751&ark=/ark:/48223/pf0000382274/PDF/382274eng.pdf.multi&fullScreen=true&locale=en#%5B%7B%22num%22%3A139%2C%22gen%22%3A0%7D%2C%7B%22name%22%3A%22XYZ%22%7D%2C%2C834%2C0%5D, Last accessed 2024.09.6

16 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022), 22, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000381149?posInSet=6&queryId=1139efd1-e6a2-429a-9960-65d8d12df813>, Last accessed 2024.09.6

17 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Kuwait case study (2022), 27-28, https://unesdoc.unesco.org/in/documentViewer.xhtml?v=2.1.196&id=p::usmarcdef_0000381174&file=/in/rest/annotationSVC/Download-WatermarkedAttachment/attach_import_6067e796-e5b6-4246-bec4-35fe7ab93592%3F_%3D381174eng.pdf&locale=en&multi=true&ark=/ark:/48223/pf0000381174/PDF/381174eng.pdf#%5B%7B%22num%22%3A136%2C%22gen%22%3A0%7D%2C%7B%22name%22%3A%22XYZ%22%7D%2C%2C841%2Cnull%5D, Last accessed 2024.09.6

нэгдсэнээр хөвгүүдийн сурлагын амжилт, сургууль завсардалтад нөлөөлнө хэмээн үзэж байна.

Өрхийн тэргүүний боловсролын түвшин Дэлхийн банкны тайланд дурдсанаар хөдөө орон нутагт өрхийн тэргүүлэгчдийн 81 хувь боловсролгүй байна.¹⁸ Мөн хөдөөгийн хөвгүүд боловсрол эзэмшихээс илүүтэй ажил, хөдөлмөр эрхлэх хувь өндөр. Тухайлбал, Перу улсад хийгдсэн судалгааны үр дүнгээр өрхийн тэргүүний боловсролын түвшин чухал үүрэг гүйцэтгэдэг ба хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй нөхцөл байдалтай холбоотой байсан. Өрхийн тэргүүний боловсрол доогуур байх тусам бага наснаасаа ажил эрхлэх хүүхдийн эзлэх хувь нэмэгддэг. Өрхийн тэргүүн нь бага сургуулийн боловсролтой хүүхдүүдийн ихэнх нь хөдөлмөр эрхэлдэг. Хэрэв тэдний сургалтын гүйцэтгэл муу байвал сургуулиа орхих магадлал өндөр болж, ядуурлын мөчлөг давтагддаг байна.¹⁹ Түүнчлэн боловсролыг бага үнэлдэг эцэг эх хөвгүүдэд холоос ус зөөх гэх мэт ачаалал ихтэй үүрэг даалгавар өгдөг нь хичээл таслах, хичээл хийх цаг хугацаа багасахад хүргэдэг.²⁰ Ингэснээр хөвгүүдийн сурлагын амжилтад сөргөөр нөлөөлдөг юм. Өрхийн тэргүүн нь эрэгтэй байх тохиолдолд хөвгүүдийн ирээдүйн мэргэжил сонголт, сурлагын амжилт, зан төлөвт аавын нөлөөлөл их бөгөөд аавын үлгэр жишээ чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Мөн аавын үзүүлэх нөлөө нь аавын боловсролоос гадна материаллаг дэмжлэг, оролцоотой холбоотой. Жишээлбэл, ЮНЕСКО-гийн тайланд аавууд хүүхдүүддээ ном уншиж өгөх, гэрийн даалгавар хийхэд туслах, багштай нь уулзах зэрэгт хангалтгүй оролцдог. Мөн эцэг, эхчүүд хүүхдэдээ боловсрол олгохын ач холбогдлыг мэддэг боловч тэднийг сурахад хэрхэн дэмжихээ мэддэггүй талаар дурдсан байв.²¹ Түүнчлэн аав эзгүй байх нь хөвгүүдийн сурлагын амжилтанд нөлөөлдөг. Пакистан улсад хийгдсэн судалгааны үр дүнд гадаадад эсвэл гэрээсээ хол амьдардаг аавтай байх нь хөвгүүдийн сурлагын амжилт доогуур байх гол хүчин зүйлүүдийн нэг гэж дүгнэсэн байна.²² Өөрөөр хэлбэл, хөвгүүдэд аавын хяналт, оролцоо байхгүй тохиолдолд муу хүмүүстэй нөхөрлөх, бусдад уруу татагдах зэрэг сөрөг үр дагавартай байдаг.²³ Түүнчлэн аав гэртээ байдаг ч хөвгүүдтэйгээ харилцаа холбоо тогтоох байдал сул бол хөвгүүдийн зан чанар, хүмүүжил, хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал, Карибын тэнгисийн олон улсад аавууд хөвгүүдтэйгээ бараг харьцдаггүй бөгөөд шийтгэх үед л харилцаа үүсгэдэг. Энэ нь хөвгүүдийг бусадтай ярилцдаггүй ууртай нэгэн болгож, тамхи, согтууруулах ундаа хэрэглэхэд нөлөөлдөг болох нь нэгэн судалгааны үр дүнгээс харагдана.²⁴ Мөн Их Британи улсад аавын үүрэг, оролцоо нь хөвгүүдийн сэтгэцийн эрүүл мэнд, зан байдал, харилцааны чанар, зан төлөв, шалгалтын дүн, ирц зэрэг хэмжүүрээр дамжин сурлагын амжилтад нөлөөлдөг

18 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study (2022), 41

19 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Kuwait case study, 19

20 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 56

21 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study, 21-22

22 Ullah, Raza, and Hazir Ullah, 116

23 Ibid 117

24 UNGEI, Changing Patterns in Boys' Education Discussion Summary, 16-17

гэсэн дүгнэлтийг хийжээ.²⁵ Иймд аавын боловсролын түвшин, мэргэжил, хөвгүүдийн боловсролд оролцох оролцоо, дэмжлэг, хөвгүүдтэй цагийг өнгөрөөж, эерэг харилцаа үүсгэж буй байдал зэрэг нь хөвгүүдийн зан байдал, сэтгэцийн эрүүл мэнд, төлөвшил, хичээлийн ирц, сурлагын амжилтанд нөлөөлж байна.

3. Үе тэнгийнхэн

Үе тэнгийн дээрлэлт. Эр жендэрийн (masculinity) хэм хэмжээнд нийцээгүй, түүнийг дагаж мөрддөггүй хөвгүүд сургууль, олон нийт, үе тэнгийг хийхнээ дунд ялгаварлан гадуурхалт, дээрлэлттэй тулгарснаар тэдний оролцоо, суралцах үйл явцад нөлөөлдөг.

Жендэрийн хэвшмэл хандлагаар боловсролд хандах Боловсролыг үнэлэх үнэлэмж, ирээдүйн ажил мэргэжил төлөвлөлт нь хөвгүүдэд нөлөө үзүүлдэг. Чилид хийсэн судалгаагаар ном уншихыг эрэгтэйчүүдэд тохиромжгүй, эмэгтэйлэг үйлдэл гэж үзэж, ном унших сонирхолтой хөвгүүдийг шоолдог бөгөөд энэ нь тэдний урам зоригийг мохоодог аж.²⁶ Мөн хөвгүүд боловсрол, ирээдүйн боломжийн хоорондын хамаарлын талаар мэдлэг дутмаг байсан бол охидууд боловсрол, сурлагын амжилт зэрэг нь ирээдүйн боломжид шууд нөлөөлнө гэж үзсэн байна. Тиймээс хөвгүүдийн боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн хоорондын хамаарлын талаарх хэвшмэл ойлголт үе тэнгийнхний дунд бий болсон нь хөвгүүдийн сурлагын амжилтыг сааруулдаг болохыг сурагчидтай хийсэн ярилцлагын үр дүнд дүгнэжээ.²⁷ Тухайлбал, Лесото улсад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад боловсролын ач холбогдолд эргэлздэг эсвэл аль хэдий нь сургуулиа орхисон үе тэнгийнхэн сурч буй хөвгүүдийн сургуулиа орхихыг дэмждэг байна. Тус улсын 17 настай нэгэн хүү “Сургууль завсардсан манай үе тэнгийнхэн бидэнд сургуулиа орхихыг зөвлөдөг бөгөөд гэртээ байх нь илүү сайхан гэж хэлдэг” гэжээ.²⁸ Мөн Арабын нэгдсэн эмират улсад үе тэнгийнхний боловсрол болон карьер төлөвлөлт, сонголт хөвгүүдийн сонголтод өндөр нөлөөлөл үзүүлдэг. Жишээлбэл, хөвгүүд өөрсдийн авъяас, сонирхолд нийцсэн хичээл сонгохыг бус үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах хөтөлбөр сонгохыг илүүд үздэг. Ингэснээр зарим хөвгүүд сонгосон хөтөлбөртөө чадвар муу, гүйцэтгэл багатай байх, сургуулиа орхих магадлал нэмэгддэг талаар ярилцлагад оролцогчид хэлсэн байна. Цаашлаад үе тэнгийнхний нөлөөллөөр хийсэн сонголтууд нь ирээдүйд хөвгүүдийн авъяас чадварт тохирсон ажлын байр олох боломжийг бууруулдаг.²⁹ Иймд үе тэнгийнхэн боловсролыг доогуур үнэлсэнээр хөвгүүдэд сургуулиа орхих сэдэл төрүүлэх магадлалтай юм. Мөн хөвгүүд ирээдүйн ажил мэргэжилтэй холбоотой ямар нэгэн сонголт хийхдээ үе тэнгийнхнийг даган дуурайснаар тухайн хичээлдээ гүйцэтгэл муутай, сонирхол

25 USAID, Boys' underachievement in education: a review of the literature with a focus on reading in the early years, 15

26 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 47

27 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 20

28 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study, 41


29 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study, 20-21

багатай болж сургуулиас хөндийрэх нэгэн шалтгаан болохоор байна.

Хөвгүүд үе тэнгийнхнийхээ “бүлгийн нэг хэсэг” байхын тулд тэдэнд хүлээн зөвшөөрөгдөх, тэдгээртэй таарч, тохирох шаардлага үүсдэг. Энэ нь хөвгүүдийн сурлагын амжилтад нөлөө үзүүлэгч нэгэн хүчин зүйл болдог. “Хөвгүүд хүлээн зөвшөөрөгдөх, бусдад тохирох дарамтыг мэдрэх нь тухгүй байдаг тул сургууль завсарддаг” гэжээ. Тиймээс үе тэнгийнхний дарамт, шахалтад хариу үйлдэл үзүүлэх үед эцэг эхийн зөвлөгөө, багшийн хяналт байснаар ухаалаг шийдвэр гаргахад тустай.³⁰ Хөвгүүдээс тэдний бүлэглэлийн манлайлагчийн шинжийг асуухад “эр зориг, хүч чадал” зэрэг эр жендэрийн шинж чанарууд багтсан боловч “хичээлдээ сайн байх” ороогүй. Тиймээс хөвгүүд найз нөхдөө дуурайж, нөхөрлөлийн бүлэгт байр сууриа хадгалахын тулд боловсролд бага анхаарал хандуулж, бүлэглэлийн чухалчилдаг дадал зуршил, шинж чанарт анхаарлаа хандуулж байна.³¹ Чухалд тооцогддог шинж чанарт сурлагын амжилт орохгүй байснаар хичээлээс хөндийрэх хүчин зүйл болж байна.

Мөн нөхөрлөдөг бүлгийнхэндээ таалагдах, хүлээн зөвшөөрөгдөхийн тулд өөрийгөө өөрчлөх, өөрийнхөө хүссэнээс өөр дадалтай болох зэрэг нь хөвгүүдэд дарамт үүсгэснээр сургуулиа орхих эрсдэл бий болох юм. Ийм нөхцөл байдалд эцэг эх, багш нарын оролцоо шаардлагатай болох нь харагдаж байна. Тиймээс энэхүү үе тэнгийнхнийг даган дуурайхаас үүссэн дарамт нь эцэг эхийн хайхрамжгүй байдал, багшийн хяналтгүй байдал зэрэгтэй давхцсанаар хөвгүүдийн сурлагын амжилт, сургууль завсардалтад нөлөөлөгч хүчин зүйл болж байна. Учир нь Лесото улсын судалгааны үр дүнд хөвгүүд сургуулийн болон өөр сургуулийн үе тэнгийнхний нөлөөллөөр цагдаа дээр очих магадлалтай үйлдэлд татагдан ордог ба тэдний архи, тамхины хэрэглээнд үе тэнгийнхэн нөлөөлдөг болох нь нотлогджээ.³²

Мөн Арабын нэгдсэн эмират улсад хийгдсэн судалгаанд оролцогч сургуулийн эмэгтэй захирлын мэдээлснээр “Анх сургуульд томилогдон ажиллах үед хөвгүүдэд үе тэнгийнхний дарамт, шахалтаас үүдэлтэй олон зан байдлын асуудал үүсч байсан. Бид бүхэн сургуулийн 3-4 сурагчаас шалтгаалж, тэдгээр асуудлууд үүсч байгааг олж мэдсэн. Үүний дараагаар тэдгээр сурагчдын хэрэгцээнд анхаарлаа хандуулснаар сургууль дахь сөрөг зан үйлийн зөрчил буурсан” гэв. Ийм зохисгүй зан үйлд бие махбодын хүчирхийлэл, дээрэлхэлт, хичээл таслах, тамхи татах зэрэг орно гэжээ.³³



30 UNESCO, Leave No Child Behind: A Case Study of Fiji (2022), 43

31 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Kuwait case study, 29

32 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study, 41

33 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study, 20-21

МЕЗОСИСТЕМИЙН НӨЛӨӨЛӨЛ

Мезосистемийн түвшинд газарзүйн байршил, сургуулийн онцлог, хэл, шашин, соёлоос хамаарсан нөлөөллүүд багтана. Сургуулийн нөлөөлөлд багш сурагчийн харилцаа, багш эцэг эхийн харилцаа холбоо, сургуулийн соёл, анги танхим дахь асуудал, сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг хамаарч байна.

1. Газарзүйн байршил

Сурагчдын оршин суугаа газар нь бага, бүрэн дунд сургуулиа дүүргэх магадлалд чухал нөлөө үзүүлдэг болох нь олон судалгаагаар нотлогдож байна. Тухайлбал Гамби, Нигери, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Сенегал, Сьерра-Леон зэрэг улсад хөдөө орон нутагт амьдардаг хөвгүүд улсын дундажтай харьцуулахад бага боловсролыг дүүргэх магадлал бага.³⁴ Латин Америк, Карибын тэнгисийн хэд хэдэн улсад бага дунд боловсролын түвшинд орон нутагт суралцаж буй хөвгүүдийн төгсөлтийн дундаж түвшин улсын дундаж түвшний хооронд ихээхэн зөрүүтэй байсан.³⁵ Үүнд гэрээс сургууль хүртэлх зай их, хөвгүүдэд нийцтэй сургалтын хөтөлбөр дутмаг, бүрэн дундаас дээш боловсрол шаарддаг ажлын байр тухайн улс оронд нь ховор зэрэг сургууль завсардахад хүргэдэг олон хүчин зүйлс нөлөөлдөг аж.

Перу улсад хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 65 хувь нь алслагдсан хөдөө орон нутгийнх байна. Хүүхдүүд байршлаасаа шалтгаалаад гэрийн ажил, гар урлал, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, баялаг олборлолтын ажилд оролцдог. Хот сууринд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн өндөр хувийг 14-17 насныхан эзэлдэг бол хөдөө 5-9 насныхан байна.³⁶ Африкийн нөхцөлд хөдөөгийн хөвгүүд ном бага унших эрсдэлтэй. Арабын Нэгдсэн Эмират улсад чадвар муутай, мэргэжилдээ дур сонирхол багатай багш нар алслагдсан сургуульд ажилладгаас үүдээд алслагдсан газрын хөвгүүд боловсролд оролцохгүй байх эрсдэлтэй.³⁷ Гэрээс хол орших сургуульд хүүхдээ суралцуулах нь эцэг эхчүүдэд хүүхдээ бүрэн дунд боловсролтой болгохын тулд байрны түрээс төлөх дарамттай тулгардаг. Гэрээс сургууль хүртэлх зай хол байх, эсвэл хөвгүүдийг өөр орон нутагт сургуульд суралцуулах нь тухайн гэр бүлд эдийн засгийн хүндрэл үүсгэдэг асуудал давхцсанаар хөвгүүдийн сурлагын амжилт, сургууль завсардалтад сөргөөр нөлөөлдөг байна.³⁸

Үүнээс дүгнэхэд тухайн улсын нөхцөл байдлаас шалтгаалж, хөдөөгийн

34 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 60

35 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 58

36 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Peru case study (2022), 19, https://unesdoc.unesco.org/in/documentViewer.xhtml?v=2.1.196&id=p::usmarcdef_0000381395&file=/in/rest/annotationSVC/DownloadWatermarkedAttachment/attach_import_0a9f580b-9839-471c-8cf6-ce676013a88d%3F_%3D381395eng.pdf&updateUrl=updateUrl1202&ark=/ark:/48223/pf0000381395/PDF/381395eng.pdf.multi&fullScreen=true&locale=en#%5B%7B%22num%22%3A20%2C%22gen%22%3A0%7D%2C%7B%22name%22%3A%22XYZ%22%7D%2C68%2C524%2C0%5D, Last accessed, 2024.10.08

37 USAID, Boys' underachievement in education: a review of the literature with a focus on reading in the early years, 15

38 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study, 44-45

хөвгүүдэд гэрээс сургууль хүртэлх зай их байх, сургууль хол байх бэрхшээлийг даван туулахад эцэг эхчүүдэд эдийн засгийн хүндрэл үүсэх, тухайн бүс нутагт өндөр боловсрол шаарддаг ажлын байр ховор байх, багшийн болон сургалтын хөтөлбөрийн чанар муу байх, байршлаас шалтгаалсан хөвгүүдийн хөдөлмөр эрхлэлт их байх зэрэг хүчин зүйлсүүд хөвгүүдийн сурлагын амжилт, сургууль завсардалтад нөлөөлж байна.

2. Сургуулийн нөлөөлөл

Нэн тэргүүнд багш, сурагчийн харилцаа холбоо сул, таарамжгүй байх, багш сурагчдад ялгавартай хандах зэрэг нь хөвгүүдийн сурлагын амжилт, оролцоонд нөлөөлдөг. Фижи улсад хийгдсэн судалгаагаар багшийн сөрөг харилцаа сурагчдын хичээлийн оролцоонд нөлөөлдөг болохыг дүгнэжээ. Ярилцлагад оролцогч охидын нэг нь “Багш нар хөвгүүдтэй эелдэг харьцах хэрэгтэй. Зарим багш нар ангийнхны өмнө хөвгүүдтэй маш бүдүүлэг харьцаж, тэднийг доромжилдог. Энэ нь тэдэнд таагүй мэдрэмж төрүүлж, тэд хичээлээ таслахыг илүүд үздэг” гэсэн байна.³⁹

Лесото улсад хийгдсэн судалгааны нэг оролцогч “Сургууль дээр багш нар хөвгүүдийг угаасаа л муу зан үйл гаргадаг гэсэн тогтсон сэтгэлгээтэй байдаг тул ийм зан үйлийн учир шалтгааныг олохгүйгээр тэднийг үл тоомсорлож, сайн зан үйлийг нь дэмждэггүй” гэжээ.⁴⁰ Энэ талаар Шотланд улсад хийгдсэн судалгааны үр дүнд асуудал бүх хөвгүүдэд биш тодорхой бүлэг хөвгүүдэд үүсдэг боловч багш нар сурагчдын зан үйлийг хүйсээр нь нэгтгэн дүгнэдэг гэж үзжээ.⁴¹ Тиймээс багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт нь хөвгүүдэд ялгаатай хандах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Мөн Арабын нэгдсэн эмират улсад хийгдсэн хөвгүүд багш нарыг нээлттэй байх нь чухал гэж үзсэн хэдий ч эрэгтэй багш хангалтай нээлттэй биш байдаг талаар дурджээ. Хөвгүүдийн хувьд багш нарыг өөрсдөд нь санаа тавьдаггүй, харилцаа холбоо муутай байдаг гэж үзсэн байна.⁴² Үүнээс харахад багш нар хөвгүүдийн талаарх жендэрийн сөрөг, хэвшмэл ойлголттой байснаар тэднийг үл тоомсорлож, тэдэнтэй бүдүүлэг, тааламжгүй байдлаар харьцаж байна. Ийм хандлага нь хөвгүүдэд охидоос ялгавартайгаар хандаж буй мэдрэмж төрүүлж, багш хөвгүүдийн хоорондын харилцаа холбоо хөндийрэх нөхцөлийг бүрдүүлдэг. Үүний улмаас хөвгүүдийн хичээлд оролцох оролцоо муудах, сурах хүсэл эрмэлзэл буурах, хичээлдээ явах дургүй болох зэрэг үр дагаварт хүрэх юм.

Анги танхимын зохион байгуулалт, түүн дотор суудал хуваарилалт хэрхэн хийгдэх, арын суудалд ихэвчлэн хөвгүүд суух зэрэг нь тэдний сурлагын гүйцэтгэлд нөлөөлдөг байна. Ботсвана улсад хийгдсэн судалгааны үр дүнд “ихэвчлэн ангийн салаа болгоны ар талын гурван эгнээнд хөвгүүд суудаг бөгөөд

39 UNESCO, Leave No Child Behind: A Case Study of Fiji (2022), 46

40 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study (2022), 48

41 Judith Mungoo, Gender and achievement in Botswana's basic education: Exploring boys' underachievement, African Educational Research Journal Vol. 5(2), pp. 99-108, April 2017, 106, <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1214157.pdf>, Last accessed 2024.09.6

42 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022), 25

тэдгээр хөвгүүд хичээлээ анхаарахгүй байх, бие биетэйгээ чатлах, үймүүлэх, юу ч хийхгүй суух зэрэг үйлдлүүд ажиглагддаг” гэдгийг илрүүлжээ.⁴³ Иймд анги дүүргэлт ихтэй тохиолдолд арын суудалд сууж буй хөвгүүдэд багшийн зааж буй агуулгын хүрэлцээ муу байснаар сурлагын хоцрогдолд орох шалтгаан болдог. Мөн багш нарын хөвгүүдийн талаарх сөрөг хэвшмэл ойлголттой суудал хуваарилалтын асуудал нэгдсэнээр тэдний хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж, хөвгүүдийн хичээлийн идэвх оролцоо муудах эрсдэлтэй.

Эцэг эх, багшийн харилцаа холбоо сайн байх шаардлага Эцэг эх болон багшийн харилцаа холбоо сайн байснаар хөвгүүдийн талаар багш илүү их мэдээлэлтэй болох, хөвгүүдэд тулгамдаж байгаа асуудал, гаргаж буй зан төлөвийг ойлгох, тэдний хэрэгцээг таньж нийцүүлэх зэрэг эерэг үр дагаврыг авчирна. Энэ талаар Фижи улсад хийгдсэн судалгааны хүрээнд эцэг эх, багш болон сурагчдын хоорондын идэвхтэй харилцаа нь хөвгүүд сургуулиас хөндийрөх асуудлыг шийдвэрлэхэд тустай гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын нэг нь “Багш нар сурагчдад маш их цаг зарцуулдаг. Тийм ч учраас тэднийг заримдаа сурагчдын хоёр дахь асран хамгаалагч гэж нэрлэдэг. Сурагчид сайн гүйцэтгэлтэй байхын тулд багш нар сурагчдын талаар хангалттай мэдээлэлтэй байх шаардлагатай. Энэ нь багш, эцэг эхийн хооронд сайн харилцаа тогтоохыг шаарддаг” гэсэн байна.⁴⁴ Тиймээс эцэг, эх багшийн харилцаа холбоо хангалттай биш байснаар хөвгүүдийн сурлагын амжилтад сөргөөр нөлөөлөх үр дагавартай болох юм.

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл Хөвгүүдийн хувьд үе тэнгийнхэн болон багшийн зүгээс ихэвчлэн бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд⁴⁵ өртдөг ба энэ нь тэднийг боловсролоос хөндийрөхөд нөлөөлдөг. Энэ талаар бага, дунд орлоготой зургаан орны PISA үнэлгээнээс үзэхэд хүүхдүүдийн сургуулиас гарах болсон шалтгаанд хөвгүүдийн хувьд хүчирхийллээс айх айдас байдаг талаар мэдээлсэн (OECD, 2020a). Арабын нэгдсэн эмират улсын сургууль завсардсан зарим сурагчид “сургууль дээр аюулгүй байдлыг мэдэрдэггүй”, “хэн нэгэн гэмтээнэ гэж заналхийлсэн” гэж мэдэгджээ. Эдгээр хүчин зүйлсүүд нь сургуулиа орхих магадлалыг хоёр дахин нэмэгдүүлдэг аж. Багшийн зүгээс эрэгтэй сурагч руу чиглэсэн сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл хөвгүүдийн сургууль завсардалтад нөлөөлж байна. Жишээлбэл, сургууль завсардсан эрэгтэй сурагч “хичээлийн өдрүүдэд багш нар бид нарыг цохихоос өөр юу ч хийдэггүй. Бид нэгдүгээр ангиасаа л үүнд дассан” гэсэн байв. Мөн нэг сурагч “Би цохиулж байснаа одоо ч санадаг. 5-р ангидаа намайг яагаад ч юм үзэн ядаж, хичээл үзэх дургүй болгосон багштай байсан. Үүний үр дүнд би зөрүүд болж, сурахаас татгалзсан. Багш нэг удаа цахилгааны кабель авчирч, хоёр хүүгээр намайг бариулж, хөлийг минь цохиж байсныг би одоо ч санаж байна” гэж мэдээлжээ.⁴⁶ Лесото улсын судалгаанд оролцогч “Бие

43 Judith Mungoo, 105

44 UNESCO, Leave No Child Behind: A Case Study of Fiji (2022), 47

45 UNGEI, 2022

46 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022), 26

махбодын шийтгэл хөвгүүдийг хичээлдээ явах сонирхолгүй болгодог” гэсэн.⁴⁷

Мөн Кувейт улсын судалгаанд оролцогч “Сургууль дээр хүүхдүүдээс хүчирхийллийн талаар өдөр бүр гомдол ирдэг. Үүний шалтгаан нь сургуулийн менежмент муу байгаатай холбоотой гэж боддог. Өөр нэг шалтгаан нь хөвгүүдэд сэтгэлзүйн эмгэг үүсгэдэг гэр бүлийн маргаан юм. Тэр сэтгэлзүйн эмгэгийн тусгал нь хөвгүүдийн сургууль дээрх зан үйл, биеэ авч явах байдал, сурлагын амжилтанд нөлөөлдөг” гэж үзжээ.⁴⁸ Үүнээс дүгнэхэд сургуулийн орчин дахь үе тэнгийнхэн болон багшийн зүгээс үзүүлж буй бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд хөвгүүд илүү өртөж байна. Энэ нь үе тэнгийнхний гэр бүлийн орчин дахь суурь хүмүүжил, хөвгүүдийн талаарх багшийн сөрөг хэвшмэл ойлголт, тэдний хоорон дахь үл ойлголцол зэргээс улбаатай бөгөөд суурь шалтгаан нь жендэрийн ялгаварлан гадуурхалт, эцгийн эрхт ёсны соёл, уламжлалын гүн бат нөлөө байна.

3. Үндэстний цөөнх (хэл, шашин)

Үндэстний цөөнхийн асуудал хурцадмал биш тохиолдолд хөвгүүдийн сурлагын амжилтгүй байдал болон ялгаварлан гадуурхалтын хоорондын харилцаа хамааралыг судлах шаардлага үүснэ. Жишээлбэл, олон хэлтэй улсуудад (Малайз) сургалтын орчинд зарим хөвгүүдийн хувьд сул тал бий болдог байна.⁴⁹ Мөн Арабын нэгдсэн эмират улсын кейс судалгаанаас харахад тус улсад сургууль дээр англи хэлний хэрэглээ нэмэгдэж байгаа нь хөвгүүдэд бэрхшээл үүсгэж байна. Тодруулбал АНЭУ-ын улсын сургуулиудын бүх сурагчид араб хэлээр чөлөөтэй ярьдаг байх шаардлагатай ба багш нарын дотоод, мэргэжлийн харилцааны ихэнх хэсэг нь араб хэлээр байдаг. Гэсэн хэдий ч багш нар болон сурагчид зөвхөн англи хэл дээр заах, суралцах агуулгын хүрээнд эрэгтэй сурагчдад илүү бэрхшээл үүсдэг. Өөрөөр хэлбэл англи хэлний хангалттай түвшний мэдлэггүй сурагчид агуулгыг бүрэн ойлгож чадахгүй байснаар сургалтын агуулгаа ойлгох, хэлний бэрхшээлээ даван туулах сорилттой тулгардаг. Ярилцлагад оролцогчид энэхүү хэлний бэрхшээлийг гэр бүлийн байдал, тэдний нийгэм эдийн засгийн статус, эцэг эхийн боловсролын түвшинтэй холбоотой гэж тайлбарласан. Мөн сурагчидтай хийсэн ярилцлагын үеэр сурлагын амжилт муутай хөвгүүдэд орчуулагч ашиглах шаардлага гардаг байсан бол сурлагын амжилт сайтай охид, хөвгүүдэд орчуулагч шаардлагагүй байв.⁵⁰ Тиймээс үндэстний цөөнх байдаг улс болон эх хэлнээс бусад хэлний хэрэглээ өргөн тархсан улсад хэлний асуудал үүсдэг байна.

Хөвгүүдийн сурлагын амжилтад сүм хийдэд шавилан суух нь нөлөөлдөг байна.⁵¹ Жишээлбэл Лесото улсад хийгдсэн судалгааны үеэр 15 настай нэгэн хүү

47 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study (2022), 48

48 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Kuwait case study (2022), 31

49 USAID, Boys' underachievement in education: a review of the literature with a focus on reading in the early years (2016), 15

50 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022), 24

51 Commonwealth of Learning, Boys' Underperformance in Education: Revisiting the issue in the Commonwealth (2017), 22, <https://www.che.ac.ls/wp-content/uploads/2019/09/07-Boys-Underperformance-in-Education-Revisiting-the-Issue-in-the-Commonwealth.pdf> Last accessed 2024.09.6

“Бид адис хүртэх⁵² сургуульд явахгүй бол шүүмжлүүлдэг тосгонд амьдарч байна. Учир нь хөвгүүд үүнийг заавал хийх ёстой байдаг” гэжээ. Мөн өөр 17 настай нэгэн хүү “Хөвгүүд шүүмжлэлийг үзэн яддаг учраас сургуулиа орхиж, сүм хийдийн дэргэдэх сургуульд ихэвчлэн явдаг. Хөдөө орон нутагт хөвгүүд өөрсдийн соёлын нэг хэсэг болсон сүм хийдийн дэргэдэх сургуульд явах хандлагатай” гэв.⁵³ Иймд улс орны соёлын, шашны нөлөө нийгэм, үе тэнгийнхний нөлөөлөлтэй нэгдсэнээр эцэг эхийн хараа хяналт сул, боловсрол нимгэн, нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн хөвгүүдийн хувьд боловсролоос хөндийрэх нэг хүчин зүйл болж байна.

МАКРОСИСТЕМИЙН НӨЛӨӨЛӨЛ

Макросистемийн түвшинд нийгэм, эдийн засаг, соёл, байгалийн баялагтай бүс нутаг, гэмт хэргийн гаралт, хөдөлмөр эрхлэлт, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, анги хоорондын шилжилт, сургуулийн дэд бүтэц, нийгэмд тогтсон сөрөг хандлага, хөвгүүдэд чиглэсэн бодлогын асуудал зэрэг нөлөөллүүд хамаарч байна.

1. Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл

Энэ хэсэгт бусад улсуудад хийгдсэн судалгааны хүрээнд дүгнэгдсэн нийгэм, эдийн засгийн статус доогуур хүүхдүүд сургууль завсардах эрсдэл өндөр, сурлагын амжилт муутай байсан талаар авч үзнэ.

Нийгэм, эдийн засгийн статусын нөлөөлөл нь ядуу гэр бүл хүүхдийнхээ боловсролыг дэмжих материаллаг нөөц дутагдалтай байдагтай холбоотой. Сургуулийн зардал нь ядуу гэр бүлийн өрхийн зардлын харьцангуй өндөр хувийг бүрдүүлдэг. Мөн ядууралд амьдарч буй хүмүүсийн хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй байгаа нь хүүхдүүдийн сургуульд суралцах чадварт сөргөөр нөлөөлдөг. Тиймээс хөвгүүд хөдөлмөр эрхэлж, гэр бүлийн хүнс, эрүүл мэндийн наад захын хэрэгцээгээ хангахын тулд сургууль завсардахад хүрэх нь нийгэмд цөөнгүй тохиолддог байна.

НҮБХС-гийн судалгаанд дэлхийн 59 оронд хөвгүүд хүүхдийн хөдөлмөр эрхэлж байна.⁵⁴ Энэ талаар бусад улсуудад хийгдсэн кейс судалгааны үр дүнгийн хүрээнд авч үзвэл хамтын нөхөрлөлийн бараг бүх бүс нутагт хөвгүүдийн сурлагын амжилт муу байгаагийн нэг шалтгаан нь нийгэм, эдийн засгийн давхраажилт байсан. Тухайлбал Ботсвана, Гана улсад өрхийн орлого бага байх болон хөвгүүдийн сурлагын амжилтын гүйцэтгэл муу байх хоёрын хооронд шууд хамаарал байгааг нотолсон.

52 Басотогийн ёс заншлыг дагаж мөрдөх, ялангуяа адис хүртэх сургуульд явах нь хөвгүүдийг сургуулиас хөндийрөхөд чухал хүчин зүйл болдог. Rathebe (2018, pp. 1-2) Адис хүртэх сургуулиудыг “соёлын боловсролын институт” гэж тодорхойлсон бөгөөд адис хүртэгчид нийгмийн хэм хэмжээ, эрэгтэй хүний үнэт зүйл, уламжлалт итгэл үнэмшил, зан заншлын талаар заалгадаг. Адис хүртэх ёслол нь Басотогийн соёлын салшгүй хэсэг бөгөөд залуу эрэгтэй болоход бэлэн гэж үзсэн хөвгүүдэд зориулан гүйцэтгэдэг.

53 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study (2022), 41-42

54 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 52-53

Мөн Карибын тэнгисийн Антигуа зэрэг зарим улс оронд нийгмийн давхраажилт чухал хүчин зүйл бөгөөд улсын сургуульд суралцдаг хөвгүүдээс илүү хувийн сургуульд сурдаг хөвгүүд сургуулиа төгсөж, их дээд сургуульд элсэх шалгалтанд тэнцдэг.⁵⁵ Тиймээс нийгэм, эдийн засгийн статус нь хүүхдүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлж, улмаар сургуулийн ирц, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлдөг гэсэн дүгнэлтийг хийжээ.⁵⁶ Перу улсад хийгдсэн кейс судалгаанаас харахад, 13-19 насны хүүхдүүдийн сургууль завсардсан шалтгааны 43.5 хувь нь эдийн засгийн хүндрэл, 23.6 хувь нь сурах хүсэл эрмэлзэл дутмаг, 12.7 хувь нь гэр бүлийн асуудал, 12.4 хувь нь гэрийн ажил, 6 хувь нь бусад зүйлсээс шалтгаалсан байна. Мөн 5-17 настай өсвөр насныхны 26.1 орчим хувь нь долоо хоногт 14 цаг ажилладаг.⁵⁷

Үүнээс дүгнэхэд улсуудад нийгэм, эдийн засгийн статус доогуур гэр бүлийн хөвгүүд хөдөлмөр эрхлэх магадлал өндөр байсан бөгөөд хөдөлмөр эрхлэлтээс үүдэлтэй сурлагын амжилтгүй байдал, сургууль завсардалт нийтлэг тохиолдож байна.

2. Уламжлалт соёл, байгалийн баялагтай бүс нутгийн нөлөөлөл

Мал аж ахуй, ан агнуур, газар тариалан зэрэг уламжлалт ажил, хөдөлмөр зонхилдог улс орнуудад хөвгүүдийн сургууль завсардалт их байна.⁵⁸ Тухайлбал, Лесото улсын бэлчээрийн мал аж ахуй нь жендэрийн хэвшмэл ойлголттой нэгдсэнээр хөвгүүдийн боловсрол дахь оролцоог сулруулдаг. Хөвгүүд тариа тарих, мал маллах, ажил хайхаар сургуулиасаа гарах хүсэлтийг байнга тавьж байгаа нь хөвгүүд гэр бүлийн эдийн засагт оролцох үүрэгтэй гэсэн улс орны жендэрийн тогтсон хандлагатай хөдөлмөрийн зах зээлийн тусгал юм. Мөн судалгаагаар сургуулиа орхиж, малчин болсон хөвгүүдийн ихэнх эцэг эх нь ажилгүй, эсвэл мал аж ахуй эрхэлдэг болохыг тогтоожээ. Боловсролын оролцоо, ажил үүргийн талаар Лесото улсын мал аж ахуйн бүс нутгийн нэгэн хүү “Хөвгүүдийг мал хариулж чаддаг өрхийн тэргүүн болгож өсгөдөг. Аав, ээж сураггүй болсон малаа хай гэж хэлдэг, би заримдаа оройтож ирээд ном унших боломжгүй болдог” гэж хэлсэн байна. Мөн тус нутгийн сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн “Хонь хяргах цаг болвол хөвгүүд явдаг бөгөөд энэ үйл явц 5 хоног хүртэл үргэлжлэх магадлалтай байдаг. Тэгэхээр тэд 5 хоног хичээл тасална. Тэд буцаж ирэхдээ хичээлээс хоцорсон байдаг” гэв. Үүний үр дагавраар хөвгүүдийн суралцах хугацаа багасч сурах хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлдөг.⁵⁹ Өөр нэгэн жишээ бол Кени улс юм. Тус улсын эдийн засаг сүүлийн хорин жилийн хугацаанд уналттай байгаа бөгөөд боловсролтой залуучуудын ажилгүйдэл нэмэгдсэн. Ингэснээр байгалийн баялагтай (тухайлбал, кофе, цай тариалах, уул уурхайн салбар) бүс нутгуудад

55 Commonwealth of Learning, Boys' Underperformance in Education: Revisiting the issue in the Commonwealth (2017), 21

56 Commonwealth of Learning, Boys' Underperformance in Education: Revisiting the issue in the Commonwealth (2017), 20

57 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Peru case study (2022), 18

58 USAID, Boys' underachievement in education: a review of the literature with a focus on reading in the early years (2016), 13

59 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study (2022), 40

хөвгүүд сургуулиасаа гарч ажилд орох нь нэмэгдсэн.⁶⁰

Үүнээс дүгнэхэд улсуудын уламжлалт соёл болох бэлчээрийн мал аж ахуй, байгалийн баялагтай бүс нутгийн нөлөөлөл хөвгүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж байна. Үүний улмаас хөвгүүд хичээл сурлагын хоцрогдолд орж, сурлагын амжилт буурч улмаар сургууль завсардах үр дагаварт хүрч байна. Гэхдээ уламжлалт соёл, байгалийн баялагтай бүс нутаг нь дангаараа нөлөөлөгч хүчин зүйлс биш бөгөөд тухайн улс орны нийгэм дэх жендэрийн хэм хэмжээ, үүргийн талаарх хэвшмэл ойлголттой нэгдсэнээр хөвгүүдийн боловсролын оролцоог сулруулдаг.

Нөгөө талаар, хөвгүүдэд чиглэсэн улс орны хэмжээний бодлого дутмаг. Өөрөөр хэлбэл, хөвгүүд боловсролоос эрт хөндийрч байгаа ч тэдэнд чиглэсэн улс орны хэмжээний хөтөлбөр, бодлого, санаачлага одоогоор байхгүй.⁶¹ Иймд жендэрийн эрх тэгш байдлын үүднээс охид, хөвгүүдийн ялгаатай байдалд тохирсон бодлогыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх шаардлагатай боловч хөвгүүдэд чиглэсэн бодлого дутмаг тохиолдолд тэд боловсролоос хөндийрч байх магадлалтай юм.

3. Гэмт хэрэг

Эрх мэдлийн тэгш бус харилцаатай холбоотой жендерийн хэвшмэл ойлголт болон эрэгтэйлэг байдлын талаарх сөрөг ойлголт нь хөвгүүдийг сургуулиас хөндийрэх, эрсдэлтэй зан үйл, гэмт хэрэг, хүчирхийлэлд хүргэх магадлалтай байна. Жишээлбэл Перу улсын засан хүмүүжүүлэх төвд бараг л бүхэлд нь эрэгтэйчүүд байдаг. Тус төвд байгаа хүмүүсийн талаас илүү хувь нь дунд сургуулиа төгсөөгүй байна. Төвүүдэд байгаа хүмүүсийн ердөө 1.12% нь дээд боловсролын зарим түвшинг эзэмшсэн байна.⁶² Хувь хүмүүс гэмт хэрэг үйлдэхээс өмнө сургуулиа орхих, эсвэл тэнд саатуулагдсаны улмаас сургуулиа орхиж болно. Тэдгээр хүмүүсийн 26.56 хувь нь “сурах дургүй” гэсэн шалтгаанаар, 22.95 хувь нь тус төвд хамрагдсаны улмаас, 16.28 хувь нь “санхүүгийн асуудлаас” болж сургуулиа орхисон байна.⁶³ Иймд боловсролын түвшин доогуур хүмүүс гэмт хэрэгт холбогдох эсвэл гэмт хэрэг үйлдэж ял эдэлсний улмаас боловсролоос хөндийрэх магадлал өндөр байна.

4. Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт

Хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийг албан бус салбар дэмждэг. Жишээлбэл, Перу улсад албан бус хөдөлмөр эрхлэлт нь 72,5 хувийг эзэлдэг бөгөөд гэрээ байгуулах, ажилтаны бүртгэл зэрэг хуулийн шаардлагыг хангадаггүй. Цалин хөлстэй ажилд насанд хүрсэн байх, мэргэжлийн гэрчилгээтэй байх зэрэг шаардлагагүй тул хүүхдүүд ажил хийж, орлого олоход хүндрэлтэй биш байдаг.⁶⁴

60 UNGEI, 16

61 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022), 27

62 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Peru case study (2022), 23

63 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Peru case study (2022), 24

64 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Peru case study (2022), 20

Иймд улсын хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалтыг боловсролтой уялдуулахгүй байснаар хөвгүүдийн боловсролоос хөндийрэх нэгэн хүчин зүйл хөдөлмөр эрхлэлт болдог байна.

5. Сургалтын хөтөлбөр, үнэлгээ

Улсын хэмжээнд хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр, үнэлгээний бодлого хөвгүүдийн сурлагын амжилт, сурах хүсэл эрмэлзэлд нөлөө үзүүлдэг. Тухайлбал Арабын нэгдсэн эмират улсад хичээлийн хөтөлбөр нь шахуу, сургууль дээр хичээлээс гадуурх үйл ажиллагаа эсвэл сонгон судлах хичээлд зарцуулах цаг бага. Сурагчдын эрэлт хэрэгцээ, багшийн заах ур чадварт тохирсон хөтөлбөрөөс илүүтэй яамнаас боловсруулсан, албан үнэлгээнд суурилсан хөтөлбөрийг шүүмжилж байв. Мөн сурагч, багш, удирдлагууд сургалтын хөтөлбөрийг хоцрогдсон, уялдаа холбоогүй, сонирхолгүй, сурах хүсэл эрмэлзэл төрүүлдэггүй гэж үзсэн байна.⁶⁵ Хөвгүүдийн хувьд туршилт, үйл ажиллагаанд суурилсан идэвх оролцоо шаардсан суралцахуй тохиромжтой байдаг.⁶⁶ Тиймээс хөвгүүдийн хэрэгцээ, шаардлагад тохирохгүй заах арга зүй, үнэлгээ нь тэдний сурах хүсэл эрмэлзэл, оролцоонд нөлөөлдөг.

6. Түвшин хоорондын шилжилт

Боловсролын түвшин хоорондын шилжилт буюу бага ангиас дунд анги руу, дунд ангиас ахлах анги руу шилжих шилжилт нь хөвгүүдийн сурлагын амжилтанд нөлөөлдөг байна. Жишээлбэл, Арабын нэгдсэн эмират улсын чанарын судалгааны үр дүнгээр 6, 9-р анги руу шилжих үед сурагчдад илүү их ачаалал үүсч, чөлөөт цаг багасдаг учраас шилжилтийн үед болон шилжилтийн дараа хөвгүүдийн зан чанарт нь өөрчлөлт гардаг⁶⁷ гэсэн байна. Энэ нь шилжилтийн үед сурагчдын үзэх хичээлийн төрөл ихээр нэмэгдэхтэй холбоотой байж болох юм. Учир нь хөвгүүд ихэвчлэн цөөн тооны хичээлд сонирхолтой, амжилттай байдаг бол охид бүх хичээлдээ жигд сайн байдаг. Тиймээс хичээлийн төрөл гэнэт ихээр нэмэгдсэнээр хөвгүүдийн суралцахуйд тохирохгүй байх, ачаалал үүсч зан чанарт өөрчлөлт гарах магадлалтай юм.

7. Сургуулийн дэд бүтэц

Сургуулийн орчны тав тухгүй байдал хөвгүүдийн сурлагын амжилтанд нөлөөлдөг. Жишээлбэл Арабын нэгдсэн эмират улсад сурагчидтай хийсэн ярилцлагын үеэр бүх сурагчид сургуулийн дэд бүтэц, тохижилт муу, хүрэлцээ муутай, үдийн хоол чанаргүй, сургууль ихэвчлэн жижиг цонх, тортой байдаг нь тэдний байж, суралцахыг хүсдэг газраас илүү шорон шиг санагддаг гэх мэтээр шүүмжлэлтэй хандаж байсан.

65 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022), 23

66 Ibid, 29

67 Ibid, 24

Мөн сургууль номын сантай хэдий ч номын хүртээмж, ашиглах эх сурвалж хязгаарлагдмал. Сургуулийн хоолны чанар хангалтгүйгээс хөвгүүд нэмж хоол хүнсний зүйл худалдан авахын тулд хичээл таслах шалтгаан болдог байна.⁶⁸ Иймд сургуулийн дэд бүтцийн асуудал хөвгүүдийн хувийн онцлог, хэрэгцээ шаардлагатай нэгдсэнээр хичээл таслалт, хичээлийн оролцоо, сурлагын амжилтанд нөлөөлдөг байна.

8. Нийгмийн сөрөг хандлага

Тухайн нийгэмд хэвшсэн хэм хэмжээ, тогтсон хандлага нь хөвгүүдийн ирээдүйн хүлээлт, хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөө үзүүлж байна. Арабын нэгдсэн эмират улсын хөвгүүдийн боловсролын мезосистемийн нэгэн нөлөөлөл бол сурагчдын дунд бий болсон *wasta* (Arabic: *واسطة*)-ын талаарх асуудал юм. Энэ нь таньдаг хүнээр дүрслэгддэг ойлголт юм. Тодруулбал, ямар нэгэн боломж хувь хүний ур чадвар дээр суурилагаас илүүтэй танил талаар дамжин бий болох тухай юм. Жишээлбэл, сурагчид энэ талаар “хэрвээ хоёр хүн нэг ажилд орохоор өрсөлдөж байх үед нэг хүн нь танил талтай бол нөгөөх нь бага зэрэг илүү байсан ч танилтай хүн ажилд орно” гэж тайлбарлажээ. *Wasta* нь зөвхөн танил талаас гадна гэр бүл болон өргөтгөсөн гэр бүлийн хүрээнд үүсдэг аж. Тиймээс Арабын нэгдсэн эмират улсын сурагчид үүнийг их сургуульд сурах, ажил эрхлэх боломжид нөлөөлнө гэж үзсэн байна.⁶⁹

Эцгийн эрхт нийгэмд хэвшсэн сөрөг хандлагын өөр нэгэн хувилбар нь “Хөвгүүд 18 нас хүрээд хүссэн зүйлээ хийж чаддаг. Охидын хувьд 21 нас хүрсэн ч аялах эсэхээ эцэг эхээсээ асуух шаардлагатай байдаг” гэж хэлсэн. Судалгаанд оролцогчид хөвгүүдийн эрх чөлөөний нийтлэг соёл, нийгмийн хэм хэмжээ, ойлголтоос үүдэлтэй бөгөөд “жинхэнэ эр хүн” болохын тулд илүү эрх чөлөө, бие даасан байдал хэрэгтэй ба боловсрол, академик амжилт хоёрдугаарт гэсэн итгэл үнэмшилтэй холбоотой. Суралцах үйл явц нь сахилга батыг шаарддаг бөгөөд чөлөөт хүсэл эрмэлзлэл, эрх чөлөө нь сахилга батыг үгүйсгэнэ. Нийгэмд энэхүү чөлөөт хүсэл, эрх чөлөө хэмээх ойлголт нь жендэрийн хэвшмэл ойлголт, уламжлалт хандлагатай зэрэг оршвол удаанаар, тогтвортойгоор хөвгүүдийг сургуулиас хөндийрүүлнэ. Нийгмийн ийм итгэл үнэмшил нь үе тэнгийнхэнтэй адил боломжтой биш нийгэм-эдийн засгийн статус доогуур хөвгүүдийг үл тоомсорлож, илүү сул талыг бий болгодог.⁷⁰ Иймд нийгэмд хэвшсэн сөрөг ойлголтууд нь хөвгүүдийн ирээдүйн төсөөлөл, сургуулийн идэвх, сурах хүсэл эрмэлзэлд нөлөөлөхөөр байна.

68 Ibid, 25

69 Ibid, 26

70 Ibid, 28

БҮЛЭГ 2: МОНГОЛ УЛСАД ХӨВГҮҮД БОЛОВСРОЛООС ХӨНДИЙРӨХӨД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

МОНГОЛ УЛСЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Бага, суурь боловсролын түвшин дэх сургууль завсардалт. Боловсролын яамнаас албан бичгээр ирүүлсэн мэдээнээс харахад 2023-2024 оны хичээлийн жилд 1-9-р ангийн сургуулиас гадна байгаа хүүхдийн нийт тоо нь 454 байна. Үүний 231 буюу 50.8 хувь нь малчдын хүүхэд байна. Мөн сургуулиас гадна байгаа хүүхдийн 62,3 хувь нь эрэгтэй хүүхэд юм. Малчин айлын хүүхэд болон хөвгүүд илүү сургуулийн гадна байна. Мөн бага боловсролоос суурь боловсрол руу дэвшин суралцагчдын төгсөлтийн хувь, суурь боловсролоос бүрэн дунд руу дэвшин суралцагчдын төгсөлтийн хувийг харахад суурь боловсрол төгсөгчдийн охид, хөвгүүдийн харьцаа ерөнхийдөө ижил байгаа бол бүрэн дунд боловсрол төгсөх үед хөвгүүд охидоос 12,7 хувиар бага буюу 50 хувь нь л бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна. Тиймээс хөвгүүдийн сургууль завсардалт охидоос илүү өндөр бөгөөд боловсролын шат ахин суралцах хувь хэмжээ охидоос доогуур байна.

Эх сурвалж: Боловсролын яамны статистик мэдээлэл



МОНГОЛ УЛСЫН PISA 2022 ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН (ХҮЙСЭЭР)

Монгол Улсын хөвгүүдийн сурлагын амжилт охидоос математик, унших, шинжлэх ухааны гэсэн бүх хичээлээр доогуур байгаа бөгөөд унших чадвараар 1-ээс илүү жилийн хоцрогдолтой байна.



PISA 2022 үнэлгээний үр дүнд Монгол Улсын боловсролд хүйсийн ялгаа их байгааг дүгнэсэн. Ялгаа нь боловсролд хамрагдалт, сурлагын гүйцэтгэл, боловсролыг дүүргэхтэй холбоотой. Хэдийгээр суурь боловсролын түвшинд хамран сурах хувь хэмжээнд охид, хөвгүүдийн хувьд төдийлөн ялгаагүй боловч шат ахих тусам ялгаа гарч эхэлж байна. Тухайлбал, охидын сурлагын амжилт, боловсролын шат ахин суралцах хувь хэмжээ хөвгүүдээс илт давуу байна. Тиймээс Монгол Улсын боловсролын системд бий болсон гол асуудал нь хөвгүүд ахисан түвшний боловсролд үргэлжлүүлэн суралцах чадамжгүй байгаа юм. Мөн хөвгүүдэд бий болсон хүйсийн ялгааны тусгалыг дараах хүрээнд дүгнэсэн байна.

- Хөвгүүдийн амжилт доогуур. Ялангуяа, шинжлэх ухааны хичээл болон унших чадварт их зөрүүтэй, математикийн хичээлд харьцангуй бага зөрүүтэй.
- Хөвгүүдийн анги улиралтын хувь хэмжээ өндөр.
- Хөвгүүдийн дээд боловсролд хамрагдах түвшин буурсан.
- Хөвгүүдийн сургуульд суралцах хүлээлт, дундаж хугацаа буурсан.

Монгол улсад хөвгүүд боловсролоос хөндийрөхөд нөлөөлж буй хүчин зүйлс

Энэ хэсэгт Монгол Улсын хөвгүүд боловсролоос хөндийрөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг микро, мезо, макросистемийн түвшинд ангилан авч үзлээ.

МИКРОСИСТЕМ

Микросистемийн түвшинд хувь хүн, эцэг эх, үе тэнгийнхнээс хамааралтай нөлөөлөл бий болж байна. Хувь хүнээс хамаарах хүчин зүйлд хөвгүүдийн утасны зохисгүй хэрэглээ, спортыг хичээлээс чухалчлах үзэгдэл хамаарч байгаа бол эцэг эхийн нөлөөлөлд эцэг эхийн жендэрийн хэвшмэл ойлголт, хөвгүүдийг үл хайхрах байдал, хүмүүжлийн эерэг арга барил мэдэхгүй байгаа нь, боловсролд эцэг эхийн оролцоо бага, Монгол аавуудын үүрэг оролцоо бага зэрэг асуудлууд багтаж байна. Харин үе тэнгийнхний хүрээнд жендэрийн хэвшмэл ойлголт, муу нөлөөлөл зэрэг хамаарна.

1. Хувь хүн

Хөвгүүдийн сурлагын амжилт охидоос доогуур байгаа явдалд микросистемийн түвшинд хувь хүнээс шалтгаалсан хүчин зүйлсүүд нөлөөлдөг. Энэхүү судалгааны хүрээнд хөвгүүдийн үр ашиггүй утасны хэрэглээ, спортоор хичээллэхийг боловсролоос чухалчлах хандлага гэсэн хоёр нөлөөллийг илрүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийгдсэн “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”-ны үр дүнгээс харахад Монгол Улсад өсвөр насныхны 99 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд интернэт орчинд холбогдсон нь бусад насны хүн амын бүлгээс хамгийн их цахим хэрэглээтэй гэж гарсан бөгөөд тэд өдөрт 7-9 цагийг нийгмийн сүлжээнд өнгөрөөж байна.⁷¹ Мөн хөвгүүдийн 64% нь интернэтээр тоглоом тоглох үйлдлийг хамгийн их хийж байхад охидын 63% нь хичээлээ хийх, 53% нь Google-ээс өөрт хэрэгцээтэй мэдээллийг хайх, 49% нь шинэ мэдээ, мэдээлэл авч байна.⁷² Тиймээс хөвгүүд утсыг тоглоом тоглоход илүүтэй ашигласнаар тэдний хичээл давтах цаг багасах, анхаарал төвлөрөх чадварыг сулруулах зэргээр сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлдөг байна. Мөн судалгааны ярилцлагад оролцогч багш бүр хөвгүүдийн утасны хэрэглээ, түүний сөрөг нөлөөллийн талаар дурдсан.

Утасны хэрэглээ нь хүүхдийн анхаарал төвлөрөх чадварыг бууруулж, зан аашд нь нөлөөлөх, эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаанд нөлөөлөх, үе тэнгийг хэнтэйгээ найзлахаа болих зэрэг маш их сөрөг нөлөөлөлтэй байна.

Багштай хийсэн ярилцлагын хэсгээс

71 Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгааны тайлан (2020), 9, <https://sudalгаа.gov.mn/pdf/магJKU> Сүүлд хандсан 2024.09.6

72 Мөн тэнд, 41

Чанарын судалгааны үр дүнд хөвгүүд охидоос илүү спортоор хичээллэдэг бөгөөд тухайн спортоор их цаг зарцуулах тусам хичээлээс хөндийрөх, сурлагын хоцрогдол үүсэх магадлал өндөртэй байна.

Хөвгүүд спортоор хичээллэх нь сурлагын амжилтад нөлөөлдөг. Бусдаас илүү их ачааллыг авч, хичээлээ хийхгүй л бол хоцрогдолтой болох тал байдаг. Гэхдээ зөвхөн сонирхлын түвшинд хичээллэх эсвэл мэргэжлийн түвшинд хичээллэх гэдгээс хэр их нөлөөлөл үзүүлэх нь шалтгаална.

Багштай хийсэн ярилцлагын хэсгээс

Хөвгүүдийн гар утас, тоглоомны зохисгүй хэрэглээ нь үл хайхралттай холбоотой байх магадлалтай. Хөвгүүдийг эрт бие даалгах, зөвлөн чиглүүлэхгүй байх нь тэднийг бусад сөрөг нөлөөнд автах явдлыг нэмэгдүүлж болно. Мөн спортыг эрэгтэйлэг байх, “жинхэнэ эр хүн” байх нэг хүчин зүйл хэмээн үзэх жендэрийн хэвшмэл хандлага нь хөвгүүдэд спорт бол хичээлээс илүү чухал гэх ойлголтыг төрүүлж байх магадлалтай. Иймд хувь хүний түвшинд хөвгүүдийн сурлагын амжилт, хичээлийн идэвх оролцоонд утасны буруу хэрэглээ, спортын сонирхлоос үүдэлтэй хичээлийн хоцрогдол зэрэг хамаарч байна.

2. Эцэг эх, асран хамгаалагчдын нөлөөлөл

Жендэрийн хэвшмэл ойлголт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 14.4-т “Эх, эцэг хүүхдэдээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүрэгтэй” гэж заасан байдаг. Түүнчлэн хүүхэд нийгэмшиж, төлөвших анхдагч орчин нь гэр бүлийн орчин байдаг учраас эцэг, эхийн жендэрийн мэдрэмж, хэвшмэл ойлголт нь хүүхдийн хүмүүжил төлөвлөөс гадна, ирээдүйн сонирхол, хүсэл эрмэлзэл, хандлагад чухал нөлөөлөл үзүүлдэг. Тиймээс энэ хэсэгт эцэг, эхийн жендэрийн талаарх ойлголт, хандлагыг охид, хөвгүүдийн боловсрол, үүргийн хуваарилалтад хэрхэн хандаж байгаа хүрээнд авч үзлээ.

Судалгаанд⁷³ оролцсон эцэг эхчүүдийн өгсөн мэдээллээс харахад 80 хувь нь жендэр гэдгийг нийгмийн амьдрал, шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоо гэж ойлгодог гэсэн бол 3.8 хувь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм соёлын ялгааг тусгаж байгаа ойлголт гэсэн зөв хариултыг сонгон хариулжээ. Жендэрийн талаарх эцэг эхчүүдийн ойлголтод боловсролын түвшин нөлөөтэй байгаа нь дээд боловсролтой эцэг эхчүүд зонхилж зөв хариултыг сонгосноор тайлбарлагдаж байсан.

73 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 98

Мөн өрх гэрт эдийн засгийн идэвхтэй дүр үүргийг эрэгтэй хүнд, нөхөн үйлдвэрлэлийн шинжтэй дүр үүргийг эмэгтэй хүнд илүүтэйгээр хамаатуулах уламжлалт хандлага гэр бүлүүдэд тодорхой хэмжээгээр илэрч байсан. Түүнчлэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн гэр бүлдээ ялгаатай үүрэг хүлээж буй талаарх эцэг эхчүүдийн үзэл хандлагыг тодруулбал эмэгтэйчүүд “Гэр орноо авч явах, тэжээх нь эрэгтэй хүний ажил байх ёстой”, “Хөдөөд малд явах гадуур ажлаа эрчүүд, хүүхдээ асрах, гэрийн ажлаа ээжүүд хийдэг”, эрэгтэйчүүд “Эрэгтэй хүн жудагтай байх ёстой. Гэр орноо авч явах ёстой, сайн аав байх ёстой”⁷⁴ гэх мэтээр хариулсан байна. Үүнээс харахад эцэг, эхчүүдийн дунд жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт хангалтгүй байна. Мөн эрэгтэй хүн ажил хийж, гэр бүлийн төсвийг бүрдүүлэх, гадаах ажлыг хийх үүрэгтэй гэсэн үүргийн хуваарилалтын хэвшмэл ойлголттой байна. Энэ нь хөвгүүд жендэрийн хэвшмэл ойлголтын үүднээс боловсролд хандах, боловсролын шат түвшин ахихад их хугацаа зарцуулснаас илүүтэй ажил хийж мөнгө олох ёстой гэсэн ойлголт бий болох эргээр хөвгүүдийн боловсролын оролцоонд сөргөөр нөлөөлж байх магадлалтай.

“Бага дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ” судалгаагаар гэр бүлүүд үр хүүхдийнхээ ирээдүйн боловсролын талаар анхаарал хандуулахдаа хүйсээр бус, хүү, охины хэн амжилттай суралцаж байгаагаас хамаарч үргэлжлүүлэн сургах сонголтыг хийж байгаа нь 44.8 хувьд илэрсэн хэдий ч эцэг эхчүүдийн охиноо үргэлжлүүлэн сургахыг дэмжсэн хариулт 3 дахин их байсан нь анхаарал татаж байна. Тодруулбал аав ээжүүдийн 11 хувь нь хүүгээ, 31 нь хувь нь охиноо үргэлжлүүлэн сургах хандлагатай байна. Энэ хариултын тухайд аавуудын охиноо үргэлжлүүлэн сургахыг дэмжсэн хариулт ээжүүдтэй харьцуулахад 3.5 пунктээр илүү байлаа. Чанарын баримтаар эцэг эхчүүд охиноо цааш нь үргэлжлүүлэн суралцуулна гэсэн хандлага нотлогдож байв. Эцэг эхчүүд хүүхдэдээ боловсрол эзэмшлүүлэхдээ хүйсээс илүү хүүхдийн сонирхол чухлыг онцолсон ч “охин хүүхэд хүний хүн болно”, “хүний дор орохооргүй өөрийгөө авч явах боловсролтой байх ёстой” хэмээн биеэ даасан, хэн нэгнээс хараат бус болгохыг эрхэмлэж байв. Энэ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өндөр хувьтай байдаг улс орны хувьд гайхах явдал биш юм. Харин эрэгтэй хүүхэд бол хар бор ажил хийгээд амьдарч чадна гэж хариулсан.⁷⁵ Мөн боловсрол эзэмшихэд нь гэр бүл нь хөвгүүдийг дэмжихгүй байх нь тэдний сурах хүсэл эрмэлзлийг унтраах эрсдэлтэй байна. Жендэрийн хэвшмэл ойлголтоос шалтгаалаад хөвгүүдэд боловсрол эзэмшихээс илүүтэй ажил хийх, орлого олох сэдэл төрж боловсролоос хөндийрөхөд нөлөөлж байна.

Нөгөө талаар, эцэг эхчүүд охидоо сургахдаа “ажлыг сайн гүйцэд хийж сур, юмаа сайхан угаагаад цэвэр цэмцгэр бай. Гэрийн ажлаа сайн хий гэдэг. Зүгээр залхуу шалхайгаад хэвтэж байдаг авгай болчихов гэж хэлнэ. Эмэгтэй хүүхэд айлд очих учир өөрийгөө аваад явчихдаг, хүнд муу хэлүүлэхгүй ажил төрөлтэй, хадамдаа гологдохгүй л байх ёстой” гэдэг бол хөвгүүддээ “ирээдүйд өрхийн тэргүүлэгч болох учраас аливааг алсаас харж бодлоготой ханд” гэж хүйсэд

74 Мөн тэнд, 99

75 Мөн тэнд, 100-101

суурилсан ялгаатай байдлаар захиж сургадаг⁷⁶ гэжээ. Үүнээс харахад эцэг эхчүүд охиддоо гэрийн ажилд туслах шаардлагыг тавьдаг ч хүүдээ нэгэн адил хандахгүй байснаар охид гэрийн ажлын хажуугаар хичээлээ хийх, өөрийгөө хөгжүүлэх гэх мэт олон төрлийн зүйлд анхаарлаа хандуулах чадвар суудаг бол хөвгүүдэд ийм чадвар бага байх магадлалтай байна.

Хөвгүүдийг үл хайхрах байдал ХЭҮК-ийн “Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал” тайлангаас харахад эцэг эхийн үр хүүхдээ асран хамгаалах үүргээ биелүүлээгүйтэй холбоотой гарч буй хамгийн тулгамдсан асуудал хүүхдээ үл хайхрах байдал байна. Үүний улмаас хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, хөдөлмөр эрхлэх, тавиул хүүхдийн асуудал үүсэх юм.⁷⁷ Мөн чанарын судалгааны үр дүнд дээрх асуудал хөвгүүдэд үүсч буй тулгамдсан асуудал болж байгаа нь харагдсан.

Эцэг, эхчүүд хөвгүүдийг гаргуунд нь гаргачихаад байдаг. Жишээлбэл орой үдшээр ч юм уу гадуур тоглож байхад нь хяналт тавьдаггүй, тоодоггүй. Эрэгтэй хүүхэд “зүгээр” гэсэн хандлагатай. Харин охидод илүү хяналт тавьж, цагдаж, хичээл номд нь анхаардаг.

Багштай хийсэн ярилцлага

Үүнээс дүгнэхэд эцэг эхчүүд хөвгүүдийг үл хайхрах, хяналт тавихгүй байх нь гадуур тоглох, муу зуршилд автах эрсдэлийг үүсгэдэг. Чиглүүлэг, хараа хяналтгүй насанд хүрээгүй хүүхэд цаг хугацааг үр бүтээлгүй өнгөрүүлж, хичээлийг чухалд үзэхгүйгээр хичээлд зарцуулах цаг багассанаар хөвгүүдийн сурлагын амжилтад сөргөөр нөлөөлөхөөр байна.

Эцэг эх хүүхдийн хүмүүжлийн эерэг арга барилд суралцаагүй. ХЭҮК-ын судалгаанд оролцогч эцэг эхчүүдийн 42.9 хувь хүүхдийг буруу зүйл хийвэл шийтгэх ёстой гэж, 53.1 хувь нь үгүй гэж үзсэн бол 70.8 хувь нь “Хүүхдэд хариуцлагатай байх чадварыг сургууль, багш нар олгох ёстой” гэж хариулсан байна. Энэ нь эцэг, эхийн эерэг хүмүүжлийн арга барилын талаар ойлголт хангалтгүйн сацуу сургууль, багш нарт даалгах хандлага давамгайлж байгааг харуулна.⁷⁸ Ялангуяа хөвгүүдийг хүмүүжүүлэх эерэг арга барил хангалтгүй байгаа нь ярилцлагын үр дүнгээр батлагдсан.

76 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 106

77 ХЭҮК, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал (2024), 30, <https://nhrc.lib4u.net/ebook/?id=264&lib=nhrc> Сүүлд хандсан 2024.09.6

78 ХЭҮК, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал (2024), 30-31

Эцэг эхчүүд эрэгтэй хүүхэдтэйгээ чин сэтгэлээсээ ярилцах нь бага. Бие махбодид нь ямар нэгэн хөхрөлт, бэртэл үүссэн байвал анхаарал тавихгүй. Эсвэл “зөрүүлээд зодолдохгүй яасан юм” гэх мэтээр хүчирхийллийг хүчирхийллийн аргаар шийдэхийг дэмжиж, зааварлах явдал хөвгүүд дээр илүү үүсдэг.

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

Дээрхээс дүгнэхэд хүүхэдтэйгээ ярилцах, ойлголцох, асуудлыг хамтдаа шийдвэрлэхээс илүүтэй шийтгэх, буруу үлгэр дуурайлал үзүүлэх, буруу зөвлөгөө өгөх нь хөвгүүдийн зан төлөв, хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг. Ингэснээр сургуулийн орчинд үе тэнгийнхэн, багш нартай сөрөг харилцаа үүсгэж сургуулиас хөндийрөх, дургүй байх шалтгаан болох эрсдэлтэй байна. Мөн хүүхдийн хүмүүжлийг багш нарт даатгаж, эцэг эх асран хамгаалагч нар өөрсдөөсөө шалтгаалж буй зан төлөвийн доголдолд зөвхөн багш нарыг буруутгаснаар багш, эцэг эхийн харилцаа ч муудаж, хүүхдийн сурлагын амжилтад дам байдлаар сөрөг нөлөө үзүүлж байх магадлалтай.

Боловсрол дахь эцэг эхийн утга учиртай оролцоо Сургуулийн удирдлага, багш нартай хийсэн ярилцлагын үеэр бага ангид суралцдаг хүүхэдтэй эцэг эхчүүд сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоотой байдаг бол анги ахих тусам эцэг эхчүүдийн оролцоо буурч ирдгийг тэмдэглэсэн.⁷⁹ Иймд бага ангиас дунд анги руу шилжих шилжилтийн үеэс эхлэн эцэг эхийн оролцоо, хараа хяналт муудсанаар хөвгүүдийн гүйцэтгэлийн хяналт алдагдах, сурлагын амжилт муудах зэрэгт түлхэц болж байна. **Хүүхэд хүмүүжүүлэхэд аавын үүрэг бага байгаа нь хөвгүүдэд сөргөөр нөлөөлдөг.** ХЭҮК-ын судалгаанд үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь эх хүний үүрэг хариуцлага гэж 25.8 хувь нь, эцэг хүний үүрэг гэж 16.5 хувь нь хариулсныг харьцуулахад 9.3 хувиар ээжүүдэд тус үүргийг илүү оногдуулж байна. Мөн Нийгмийн үзүүлэлтийн 2018 оны түүвэр судалгаанаас эхчүүдийн бага насны хүүхдэдээ аливааг танин мэдэхэд нь дэмжлэг үзүүлэх байдал нэмэгдсэн хэдий ч аавуудын оролцоо ээжүүдийнхээс 2 дахин бага байгаа талаар дүгнэлт хийжээ. Энэ нь хөвгүүдийн үлгэр жишээ авах хүн болох аавын үүрэг ээжийнхээс бага, хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь хөвгүүдийн хичээлийн оролцоо, сурлагын амжилтанд нөлөөлдөг болох нь чанарын судалгааны үр дүнгээр тодорхой болсон. Манай улсын хөдөлмөр эрхлэх салбар нь хүйсээр ялгарсантай холбоотой эрэгтэйчүүд аавууд гэрээсээ хол ажиллах, гадаад улс руу цагаачлан ажиллах явдал их байдагтай холбоотой гэр бүл дэх аавын оролцоо анхаарал татахуйц болсон.

79 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 109

Хөвгүүдэд аав нь маш их нөлөөлдөг. Манай ангийн нэг хүүгийн аав нь 2-3 жил хол байх үед түүний хичээл таслалт их байсан. Аав нь ирснээс хойш өмсөж зүүх, биеэ авч явахаас эхлүүлээд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн.

Багштай хийсэн ярилцлага

3. Үе тэнгийнхэн

Хөвгүүдэд үе тэнгийнхний үзүүлэх нөлөөлөлд сурагчдын дундах жендэрийн хэвшмэл ойлголт, муу зуршлын нөлөөлөл эерэг хамаарна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь хоол хийх, хувцас хунар угаах үүргийг охидынх, мод түлээ бэлтгэх, хагалах, гал түлэх, ус авах, мал хариулах, болон мал хариулах нь хөвгүүдийн үүрэг гэж хариулжээ. Өрх гэр бүлд охид, хөвгүүд ялгаатай үүрэг хүлээж буй шалтгааныг “би эмэгтэй, эсвэл би эрэгтэй учраас” гэх жендэрийн адилслын үүднээс үзэх хандлага нийтлэг харагдсан байна.⁸⁰ Мөн бага наснаас нь эхлэн гэр бүлийнхэн, ойрын хүмүүсийн жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын үзэл бодолд нөлөөлж ирсэн нь харагдаж байна.

Бага байхдаа би инженер болно гэж мөрөөддөг байсан. Чи эмэгтэй хүн учраас хэрэггүй гэдэг байсан. Наадмаар хөдөө морь унаж ирсэн хүүхдүүдийг ирэхээр нь цуг тоглох гээд очихоор “эмэгтэй хүүхдүүд байж явж аяга тавгаа угааж хоолоо хий” гээд загнаад байсан. Тэр үед надад их эвгүй санагдаж байсан. Бас “морины уяа руу эмэгтэй хүн байж битгий яв” гэдэг. Гэтэл би моринд дуртай, сонирхолтой байдаг.”

Сүхбаатар аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс

”Биеийн хүчний ажил бол эрэгтэй хүнийх гэж боддог. Эмэгтэй хүүхдүүд гэр орноо цэвэрлэх, хувцас угаах гэх мэт ажлыг хийдэг. Хөвгүүдийг хүүхэд байхаас л ээж аав чи эмэгтэй хүнийг хүндлэх хэрэгтэй, хүнд хүчир ажил хийлгэж болохгүй, эгч нарыгаа аль болох хүнд юм өргүүлэхгүй гэж сургадаг, заадаг.”

Улаанбаатар хот, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс⁸¹

80 Мөн тэнд, 110

81 Мөн тэнд, 110

Мөн чанарын судалгааны үеэр хөвгүүд үе тэнгийнхний муу нөлөөлөлд автах эрсдэл охидоос илүү өндөр болох нь харагдав. Энэ нь хөвгүүд охидоос илүү бүлгээрээ нөхөрлөдөг, бүлэглэлийн нэг хэсэг байх нь чухалд тооцогддог, бие биетэйгээ ижилхэн байхыг илүүд үздэг учир муу зуршилд өртөх хандлагатай холбоотой байж болох юм.

Хөвгүүдийн үе тэнгийнхний муу нөлөөлөлд автах байдал охидоос илүү байдаг. Учир нь охидууд хичээлээ тараад шууд гэртээ харих нь элбэг бол хөвгүүд найз нөхөдтэйгөө цагийг өнгөрөөх нь илүүтэй ажиглагддаг.

Экспертийн ярилцлага

Дээрх үр дүнгээс харахад үе тэнгийнхний дунд нийгмийн хэм хэмжээ болон тогтсон эрэгтэйлэг байдлын талаар жендэрийн хэвшмэл ойлголт нь хөвгүүдийн сэтгэл зүй, зан чанар, биеэ авч явах байдал, цаашид хийх сонголт, үйлдэлд нөлөөлдөг бөгөөд ихэвчлэн боловсролоос хөндийрөхөд түлхэц өгөх ойлголтууд байна. Мөн үе тэнгийнхний муу нөлөөлөлд автах эрсдэл охидоос илүү хөвгүүдэд бий болдог нь харагдлаа. Гэхдээ эдгээр үе тэнгийнхний дунд бий болсон хэвшмэл ойлголт, муу нөлөөлөл нь дангаараа хөвгүүдийн боловсролд шууд нөлөө үзүүлэхгүй бөгөөд боловсролыг чухалд авч үзэхгүй гэр бүлийн орчин, хүчирхийлэл, сөрөг зан үйлийг үл хайхарсан сургуулийн соёлтой нийлээд тэдний сурлагын амжилтад сөрөг нөлөө үзүүлж, сургууль завсардуудах эрсдэлтэй.



МЕЗОСИСТЕМ

Мезосистемийн түвшинд сүм хийдэд шавилан суух, хурдан морь унах зэрэг уламжлалт соёлтой холбоотой нөлөөллөөс гадна хэл, сургууль, хэвлэл мэдээллийн байгууллагаас хамааралтай хүчин зүйлсүүд нөлөөлж байна. Үүнээс сургуулийн нөлөөлөлд хамран сургах тойргийн бүртгэлийн асуудал, багшийн жендэрийн хэвшмэл ойлголт, багшийн сөрөг хандлага, сургуулийн удирдах ажилтнуудын жендэрийн хэвшмэл ойлголт, сургуулийн орчин дахь хүчирхийлэл зэрэг асуудлууд багтаж байна.

1. Соёл, уламжлал, зан заншил

Хөвгүүд сүм хийдэд шавилан суух үзэгдэл охидоос илүү их байдаг бөгөөд энэ нь тэднийг албан боловсролоос хөндийрүүлэх үр дагаварт хүрдэг. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Монгол Улсад сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг хийсэн байна. Судалгааны үр дүнгээс харвал улсын хэмжээнд Будда, Христ, Исламын шашны үйл ажиллагаанд 2837 хүүхэд хамрагдаж байгаагийн 84 хувь буюу 2341 хүүхэд Улаанбаатар хотод, 14 хувь буюу 476 хүүхэд орон нутагт хамрагдаж байна.⁸² Сүм хийдэд шавилан суусан таван хүүхэд тутмын дөрөв нь хөвгүүд байхад өдрөөр үйл ажиллагаанд нь хамрагддаг хүүхдүүдийн хувьд охид хөвгүүдээс 4 нэгж пунктээр илүү. Өөрөөр хэлбэл, эрэгтэй хүүхдийн сүм хийдэд шавилан суух магадлал эмэгтэй хүүхдээс 4 дахин их байна.⁸³ Тэдний хүүхдүүдийн тал хувь нь бүтэн эсвэл хагас өнчин хүүхэд байна.⁸⁴ Мөн шавилан суугч хүүхдүүдийн дийлэнх нь эмзэг бүлгийн, амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүд бөгөөд ихэвчлэн хувцас хунараар хангах, аливаа баярын үеэр тэдэнд бэлэг өгдөг нь хүүхдүүдэд таалагддаг байна.⁸⁵

“Манай аав хийдийн манаач хийдэг байсан болохоор тус хийдийн лам багш маань намайг хараад лам болохоор хүүхэд байна гээд лам болсон. Би өөрөө ч бас дуртай байсан. Овоо уулын тахилга, ном хурах үед өгсөн гарын мөнгийг цуглуулж байгаад буцаад шинэ дээл хувцас хийж өгөх, бөхийн барилдаанд сайн барилдах, мөн баярын үеэр бэлэг өгдөг нь таалагддаг”.

Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярицлагаас

82 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа (2019), 15

83 Мөн тэнд, 16

84 Мөн тэнд, 17

85 Мөн тэнд, 22-23

Сүмийн хийдийн үйл ажиллагаанд хамрагдаж буй хүүхдүүдийн ЕБС-ийн хамрагдалтын авч үзвэл чанарын судалгаанд хамрагдсан шавилан суудаг 70 хүүхдийн 25 нь сургууль завсардсан ба үүнээс 9 нь насан туршийн боловсролын төвийн дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдсан байна. Мөн албан бус сургалт нь төдийлөн үр дүнтэй биш байгаа нь доорх хэсэгт өгөгдсөн ярилцлагаас харагдаж байна.⁸⁶ Мөн шавилан суудаг хүүхдүүдийн 75 хувь нь ЕБС-ийн хичээл ороход мэргэжлийн багшаар бүрэн хангагдаагүй, 69 хувь нь ном сурах бичгээр бүрэн хангагдаагүй байна.⁸⁷

“ЕБС-ийн 5-р ангид суралцаж байгаад орон нутаг руу шилжихээр болоод сургуулиас гарсан, тэгээд шилжихээ болиод эндээ үлдсэн. Тэрнээс хойш сургуульд яваагүй” тоо, түвд үсэг, цээж бичиг, хуулан бичиг, зохион бичлэг хийдэг. Хааяа НТБТ-өөс багш ирж монгол хэл, математикийн хичээл заадаг.

Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлага

Дээрхээс дүгнэвэл сүм хийдэд ихэвчлэн хөвгүүд шавилан сууж байгаа бөгөөд тэдгээр хүүхдүүд өнчин эсвэл эмзэг бүлгийн хүүхдүүд байна. Тэдний хийдэд шавилан сууж буй шалтгаан нь шашны итгэл үнэмшлээс илүүтэй хийдээс өгч буй эд материалын хангамж, бэлэг сэлт байж болзошгүй гэдэг нь тоон мэдээлэл болон чанарын судалгааны үр дүнгээс харагдаж байна. Мөн тэдгээр хүүхдүүдийн сургууль завсардалт харьцангуй өндөр хувьтай. Хийдэд цаг зарцуулж, шашны номлол сонсохоос шалтгаалан ЕБС-ын агуулгыг хангалттай эзэмшихгүй гэдэг нь илэрхий. Тиймээс нэг талаас шашин шүтэх эрх чөлөө яригдах хэдий ч шашны итгэл үнэмшлээс бус хоол тэжээл, хувцас гэх мэт хэрэгцээнээс шалтгаалж шавилж байгаа бол сурч боловсрох эрхийн асуудал ноцтой хөндөгдөх юм.

Хурдан морины уралдаанд оролцохоос үүдэлтэй нөлөөлөл

Монгол Улсын хэмжээнд хурдан морь унаач 15,885 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 15,403 эрэгтэй, 482 эмэгтэй хүүхэд байна. Энэ нь нийт хурдан морь унаач хүүхдийн 96 хувь нь эрэгтэй, 4 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлж байна.⁸⁸ НҮБ-ийн Хүүхдийн сангаас хийгдсэн “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх судалгаа”-ны үр дүнд хаврын уралдааны үеэр хүүхдүүд 30 хүртэл хоногоор хичээлээс чөлөө авах, таслах байдал элбэг талаар дүгнэжээ. Хурдан морь унуулах шалтгаанаар хичээлээс чөлөө олгохыг хориглох талаар сургуулийн захиргаа, холбогдох албаны хүмүүсээс багш нарт даалгадаг хэдий ч хурдан морины эзэд тухайн аймаг сумынхаа нөлөө бүхий эрх мэдэлтэй хүмүүс байдаг тул хурдан

86 Мөн тэнд, 25

87 Мөн тэнд, 21

88 ХЭҮК, Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа (2022), 74

морийг нь унаж уралддаг хүүхдийг нь хичээлээс чөлөөлж явуулах даалгавар өгч (тухайлбал утсаар), тэр даалгаврыг нь үг дуугүй биелүүлэх тохиолдол гардаг байна.⁸⁹ Тухайлбал⁹⁰:

... Унаач хүүхдүүдийн тухайд аймаг орны иргэдийн хурлын дарга, аймгийн өндөрлөгүүдэд байдаг хүмүүс ерөнхийдөө хүүхдийг морь унуулж байгаа нь ажиглагддаг. Тэр даргын морь, тэрний унаач хүүхэд гэх мэтээр яригддаг. Тэгээд яаж хүүхдүүд хохирдог вэ? гэхээр хүүхдүүд маш олон хоног, сараар уралдаанд бэлдэхийн тулд сунгаа гэх мэтээр сургуулийн удирдлагад нь хэлж чөлөөлөгддөг, багш нарт чөлөө өгч болохгүй гэж сургуулийн удирдлага хэлдэг мөртлөө хэн нэгэн дарга утасдахад сургуулийн удирдлага менежерийг дуудаж тэр дарга яриад байна тэр хүүхдийг чөлөөлөөд явуул гэх жишээтэй.

Багштай хийсэн ярилцлага

Унаач хүүхдийн сурлагын амжилтын талаар судалгаанд оролцсон багш нарын 41.7 хувь нь хурдан морины уралдаанч хүүхэд хичээл үе үе тасалдаг, 35.8 хувь нь чөлөө авдаг, хүүхдүүдийн хичээлийн хоцрогдлын талаар багш нарын 43 хувь нь их, 46.2 хувь нь дунд, үлдсэн хувь нь бага хэмээн тус тус хариулсан байна.⁹¹

Хичээлийн хоцрогдлыг нөхөх тал дээр багш нарын болон анги танхимын хүрэлцээ муу, цаг хугацааны асуудал зэргээс болоод боломжгүй байдаг, мөн давтлага хичээл хийлгэсэн ч үр дүн бага гардаг байна.⁹² Мөн унаач хүүхдийн сургууль завсардалтын тухайд “хичээлээс хоцрогдсон хүүхдүүд сурах сонирхолгүй болж, морь унах нас нь өнгөрснөөс хойш уяач, эздийнхээ морь малны бусад ажлыг хийх, мал хариулах зэрэг ажлыг хийж амьдрахаас өөр замгүй болсноор сургуулиас завсардах нөхцлийг бүрдүүлдэг.

Зарим тохиолдолд алслагдсан аймаг сумдаас хурдан морь унуулах нэрийдлээр эцэг эхээс нь салган өөр аймаг, сумд авчрах тохиолдол цөөнгүй. Хүүхдийг нь шилжүүлж хурдан морь унах газрынх нь харьяа аймаг сумын сургуульд сургана гэж бүртгүүлдэг боловч сургадаггүй” болох нь судалгааны үр дүнгээр нотлогджээ.⁹³

Иймд хурдан морины уралдаанаас үүдэлтэй эрсдэл хөвгүүдэд бий болж байна. Уралдаанч хөвгүүдийн сурлага хоцрогдолтой байдгийг багш нараас асуусан тоон мэдээлэл нотолж байна. Түүнчлэн хичээлээс хоцрогдсон хөвгүүд сурах сонирхолгүй болж, сургууль завсардах, уяач болон морины эзэд өөр газар

89 НҮБ-ын Хүүхдийн сан, Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх, 11

90 Мөн тэнд, 24

91 Мөн тэнд, 25

92 Мөн тэнд, 25

93 Мөн тэнд, 25

луу шилжүүлэн авч явч сургуульд оруулахгүй, завсардуулах эрсдлүүд үүсч байна.

Монгол Улсын хувьд үндэсний цөөнх олноор амьдардаг орон нутаг бол Баян-Өлгий аймаг юм. Тиймээс тус аймгийн сургуулиудын хэлний асуудлын талаар авч үзлээ. Баян-өлгий аймгийн хос хэл дээр сургалт явуулдаг сургуулиудын хувьд казах, тува хэл дээрх сурах бичиг хангалтгүй, тухайн хэлний хичээл заадаг багш нарын мэргэжлийг дээшлүүлэх асуудал шийдэгдээгүй байна. Тухайлбал, Монгол хэл дээрх үндэсний сурах бичгүүдийн хүртээмж сайн хэдий ч тува хэлний казах хэл дээр орчуулагдсан 27 нэр төрлийн сурах бичгийн 18 сурах бичиг үг үсэг, найруулгын алдаатай, 1-5 дугаар ангийн Эх хэл, 2-5 дугаар ангийн “Монгол хэл” сурах бичгүүдийг 2010 оноос хойш шинэчлэгдээгүй байсныг 2019 онд сурах бичгийг шинэчилсэн байна. Хос хэлээр сургалт явуулдаг Тува сургуулийн Тува хэлний 1-5 ангийн бүх сурах бичиг, 2-5 дугаар ангийн Тува хэлний багшийн ном, сургалтын хөтөлбөр нь яамнаас батлагдаж гараагүй бөгөөд Боловсролын хүрээлэнгээс гаргасан гарын авлагыг сургалтад ашиглаж ирсэн байна.⁹⁴

Мөн PISA 2022- үнэлгээний үр дүнд гэртээ ярьдаг хэлээр суралцдаг сурагчаас бусад хэлээр суралцдаг сурагчийн гүйцэтгэл математик, унших чадвар, шинжлэх ухаан зэрэг бүх хичээлээр доогуур бөгөөд хоцрогдолтой байна.⁹⁵ Энэ нь сурагчдад хэлний ялгаатай байдал нөлөөлж байгааг харуулж байна. Гэхдээ хэлний ялгаа нь оксид, хөвгүүдэд ялгаатай байдлаар нөлөө үзүүлж буй эсэх талаар дүгнэлт хийх боломжгүй ч хөвгүүдийн сурлагын хоцрогдлыг улам хурцатгах эрсдэлтэй гэж дүгнэж байна.

2. Сургуулийн нөлөөлөл

Хамран сургах тойрог Сургуулиуд хамран сургах тойрогтоо амьдарч байгаа хүүхдүүдийн бүртгэлийг бүрэн хийдэггүйгээс хөвгүүд сургууль завсардах эрсдэлтэй байдаг. Ялангуяа орон нутгийн сургуулиудад хамран сургах тойргийн малчин өрхийн 6 настай хүүхдүүдийг сургуульд элсүүлэх тал дээр бэрхшээл үүсдэг. Малчин өрхийн хувьд 6 настай хүүхдээ баг, сумын төвийн сургуульд суралцуулахын тулд өөрсдөө нүүн шилжих эсвэл хүүхдийг дотуур байранд байх шаардлагатайгаас жил өнжөөж, 7 эсвэл 8 настай 1 дүгээр ангид оруулах тохиолдол гардаг байна. Сургуульд элсэн суралцаагүй 6 настай болон завсардсан хүүхдүүдийн талаар орон нутгийн сургуулиудад нэгдсэн бүртгэл мэдээлэл байдаггүй.⁹⁶

94 ЯАГ, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн (2021), 36, https://audit.mn/wp-content/uploads/2021/03/draft_sub-Report-EBS-Negdsen-20210227-Print.pdf Сүүлд хандсан 2024.09.6

95 OECD, PISA 2022 National Report Mongolia, 49

96 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 106, <https://nhrcm.gov.mn/assets/img/e8dfeeff16bd6fbb7e79f6f3029de7da.pdf> Сүүлд хандсан 2024.09.6

Сургуулиуд хамран сургах тойргийнхоо хүүхдийг бүрэн хамруулж буй эсэхээ нарийн сайн мэддэггүй. Юуны өмнө сургуулиудын бүлэг дүүргэлт маш өндөр, хүүхдийн тоо хэтэрсэн байдалтай байдаг учраас сургуульд сурахгүй байгаа хамран сургах тойргийнхоо хүүхдийг сургуульд хамруулах тал дээр дорвитой ажил хийдэггүй. Ер нь бол хамран сургах тойргийн сургуулийн гадна байгаа хүүхдийг сургуульд хамруулах нь өөрсдийн ажил гэж бодохоос илүү албан бусынхны хийх ажил гэж ойлгодог.

Насан туршийн боловсролын төвийн багштай хийсэн ярилцлага

Үүнээс дүгнэхэд сургуулиудад хамран сургах тойргийн хүүхдээ бүртгэх, сургуульд элсээгүй эсвэл завсардсан бол олж хамруулах практик байхгүй нь хөдөө орон нутагт малчин өрхийн хүүхдүүд жил алгасаж элсэх эрсдэлтэй байна. Ингэснээр ангид гадуурхагдах, дооглуулахад өртөх эрсдэл нэмэгддэг. Мөн өөр сургууль руу шилжихээр гарсан хүүхдүүд тухайн сургууль руугаа шилжиж очихгүй, сургууль завсардах эрсдэлтэй байна.

Багшийн жендэрийн хэвшмэл ойлголт Багш нарын хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр, сургалтын орчин, заах арга зүй, хүүхэдтэй ажиллах арга барил хийгээд өдөр тутмын анги танхимын практик үйл ажиллагаа нь суралцагчдын ялгаатай байдалд нийцсэн, түүнийг нь хүндэтгэсэн байх, нөгөө талаасаа суралцагчид амьдарч буй нийгмийнхээ ялгаатай байдлыг ойлгох, хамт суралцагчдынхаа өөрөөс нь өөр шинжийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэхэд суралцах агуулга, арга зүй нэвтэрсэн байх шаардлагатай. Тиймээс багш нар хичээл зааж буй ангийнхаа ялгаатай байдлыг олж харах, түүнд нь тохирсон ээлтэй, хүлээцтэй, хүндлэл бүхий орчин бүрдүүлэн ажиллахад удирдан чиглүүлэх үүрэгтэй.⁹⁷

Гэсэн хэдий ч багш нарын жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт хангалтгүй байна. Тодруулбал, судалгаанд оролцогч багш нараас жендэрийн талаарх ойлголтыг асуухад “Жендэр гэдгийг 68.5 хувь нь нийгмийн амьдрал дахь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоо, 12.8 хувь нь сургууль байгууллагад хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг хангах тухай, 11.6 хувь шийдвэр гаргах түвшинд эмэгтэй эрэгтэйчүүдийн тэгш оролцоо гэж гэж тус тус үзсэн. Харин багш нарын 0.8 хувь нь жендэр гэдэг нь эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тэмцэх үйл хэрэг, 3.9 хувь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгааг тусгах ойлголт гэж буюу ердөө 19 хүн л зөв хариултыг сонгосон байна.”⁹⁸

Мөн хөвгүүд математик, байгалийн ухааны хичээлд, охид нийгмийн ухааны

97 “БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, ЕБС-ийн 6-12-р ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичгийн агуулгад хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ (2023), 17, <https://nhrc.lib4u.net/ebook/?id=266&lib=nhrc> Сүүлд хандсан 2024.09.6

98 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 115

хичээлдээ илүү гэдэгтэй эрэгтэй, эмэгтэй багш нарын талаас дээш хувь нь санал тодорхой хэмжээгээр нийлж байна гэсэн хариулт өгсөн.⁹⁹ Багш нарын жендэрийн ойлголт хангалтгүй, хэвшмэл ойлголттой байгаа нь жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдлэг олгох сургалт хангалтгүйтэй холбоотой байж болох юм. Чанарын судалгааны үр дүнд жендэрийн талаар багш нарт ордог албан сургалт байхгүй болох нь харагдлаа.

Багш нарт жендэрийн эрх тэгш байдлын тухай сургалт хэрэгтэй гэж боддог. Гэвч энэхүү сургалт нь албан сургалтад багтдаггүй бөгөөд би зөвхөн өөрийн сонирхлоороо сургалтад хамрагдаж мэдээлэл авдаг.

Багштай хийсэн ярицлага

Жендэрийн талаар багш нарт ордог албан сургалт байхгүй. ОУБ-ын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сургалтын агуулгад л жендэр ордог.

Төрийн төлөөлөлтэй хийсэн ярицлага

Түүнчлэн багшийн заах арга зүй дэх жендэрийн эрх тэгш байдлын тухай авч үзвэл судалгаанд оролцсон багш нарын 51.8 хувь нь жендэр, жендэрийн тэгш байдал хэмээх нэр томъёог хэрэглэдэггүй ч гэсэн, багш нар сурагчдынхаа хэрэгцээ сонирхлыг харгалзан үзэж хөтөлбөрөө боловсруулдаг, тэр дагуу ажиллахаар үйл ажиллагаагаа төлөвлөдөг гэж хариулсан байна. Үүнээс бага ангийн багш нар сурагч бүрийн хэрэгцээ сонирхлыг тусгаж хөтөлбөрөө боловсруулдаг бол, дунд ахлах ангийн багш нар тухайн насны сурагчдын нийтлэг хэрэгцээ сонирхлыг тусгадаг гэсэн хариулт хамгийн олон давтагдсан байна.¹⁰⁰ Үүнээс харахад багш нарын жендэрийн мэдрэмжтэй заах арга зүй хангалтгүй гэж дүгнэж болохоор байна. Ялангуяа дунд ангийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгад хүйсийн ялгаатай байдлыг харгалзсан арга зүй, жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх зааварчилгаа шаардлагатай байна.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд багш нарын жендэрийн талаарх ойлголт, заах арга зүй нь жендэрийн эрх тэгш байдалд зорьсон байх явдал хангалтгүй байна. Ингэснээр сурагчдад жендэрийн хэвшмэл ойлголт төлөвших, хөвгүүд өөрсдийгөө үнэлэх үнэлэмж буурах, сурах хүсэл эрмэлзэлд нөлөөлөх зэрэг үр дагавартай юм. Мөн мэргэжлээ сонгох, боловсрол эзэмших үйлийг чиглүүлэгч нь охид, хөвгүүдийн байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлд сайн байдлыг хүйсийн хувьд ялгаатай авч үзэж байгаа нь тэдний цаашдын боловсрол, ажил

99 Мөн тэнд, 114

100 Мөн тэнд, 79

хөдөлмөр, мэргэжил сонголтод нөлөөлөх эрсдэлтэй.

Багш сурагчдад хэрхэн хандах, ялгавартайгаар хандаж буй эсэх, охид хөвгүүдээс ялгаатай хүлээлт үүсгэж буй эсэх зэргээс шалтгаалж, хөвгүүдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, ирээдүйн төсөөлөл, сурах хүсэл эрмэлзэлд нөлөө үзүүлдэг байна. Энэ талаар хийгдсэн судалгааны үр дүнг авч үзвэл багшийн зүгээс хүүхдийг чадвараар нь ялгаварлаж харьцах явдал бага зэрэг гэж 30.4 хувь, дунд зэрэг гэж 17.6 хувь нь, их гэж 5.5 хувь, маш их гэж 2.9 хувь нь үзсэн байна. Суралцагчдыг гэр бүлийн байдал, чадвараар нь ялгаварлаж харьцах, эцэг эхчүүдтэй ялгавартай харьцах, сурагч ба эцэг, эхийг доромжлох, нэр төрд нь халдах явдал түгээмэл биш ч тодорхой хэмжээнд байна.¹⁰¹

Эцэг эхчүүд фокус бүлгийн ярилцлагын үеэр “цөм хөтөлбөрийн шинэчлэлээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд анхаарах болсон атлаа багш нар олимпиад уралдаан тэмцээнд сайн цөөн тооны сурагчдад онцгойлон ханддагт ихээхэн шүүмжлэлттэй хандаад ийм ялгаварласан хандлага нь бусад хүүхдийн сурлагын амжилтад нөлөөлдөг” талаар дурдсан байна.¹⁰² Тиймээс багш сурагчдыг чадвар, нийгэм эдийн засгийн байдал, зэрэг хүчин зүйлээр ялгаварлаж буй хандлага нь жендэрийн хэвшмэл хандлагатай нэгдсэнээр сурагчдын гүйцэтгэлд нөлөө үзүүлдэг байна. Үүнээс гадна багш сурагчидтай зүй бусаар харьцсанаас үүдэлтэйгээр сурагчдын хичээлийн идэвх оролцоо муудах, сэтгэлзүйн асуудал үүсэх зэрэг сөрөг үр дагавартай юм. Багшийн зүй бус харилцаа практикт тохиолдсоор байгаа асуудал нь багшийн ёс зүйн зөрчил шийдвэрлэдэг үр дүнтэй механизмгүй, багш ёс зүйн зөрчилдөө тохирсон хариуцлага хүлээхгүйтэй холбоотой байж болох юм.

Хүүхэдтэй зүй бус харьцдаг, дарамталдаг, ёс зүйгүй багш нар байдаг. Тэр багшийг халсан ч дахиад өөр сургуульд очоод ажиллах эрх нь нээлттэй л байгаа. Дараагийн сургуульдаа очоод арай ч дахиад хүүхдийн эрхийг зөрчихгүй байх л гэж найддаг. Мэргэжлийн багш дутагдалтай үед багшийн хүүхдийн эрх зөрчиж байсан эсэхийг хянан шалгахгүйгээр шууд л авч байгаа.

Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлага¹⁰³

Багшийн хандлагатай холбоотой чухал хүчин зүйл нь боловсролд хөвгүүдээс илүү охидод хүлээлт үүсгэх, хөвгүүдийг доогуур үнэлэх явдал юм. Багш нартай хийсэн ярилцлагын үеэр ихэнх багш нар ирээдүйд охид хөвгүүдээс илүү боловсролтой болно гэсэн хүлээлттэй байгаа нь харагдсан. Энэ нь сурагчдад өөрсдийгөө үнэлэх үнэлэмж, ирээдүйн төсөөлөл суулгаж байдаг. Иймд багшийн

101 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 103-104

102 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 104

103 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 104

хэвшмэл хандлага, ирээдүйн хүлээлт, дэмжлэггүй байдал, ялгавартайгаар харьцах, зүй бус харьцах зэрэг нь хөвгүүдийн амжилтанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Сургуулийн удирдах ажилтнуудын жендэрийн хэвшмэл ойлголт Жендэрийн талаар ойлголтыг сургуулийн удирдах ажилтнуудын 63.2 хувь нь нийгмийн амьдралд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш оролцох тухай, 14.5 хувь нь сургуульд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах тухай, 14.5 хувь нь шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцооны тухай, 2.6 хувь нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай, 5.3 хувь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм соёлын ялгааг тусгаж байгаа ойлголт гэж зөв хариулсан байна. Мөн тэдний дунд мөнгө олж, гэр бүлийн гишүүдийг тэжээх болон орон сууц, машин гээд өмч хөрөнгөө эзэмших үүргийг эхнэрийн үүрэг гэж үзсэн оролцогч байхгүй, хоол хийх, гэр цэвэрлэх, гэр бүлийнхнийгээ асран халамжлах ажлыг нөхрийн үүрэг гэж үзсэн эмэгтэй оролцогч байгаагүй.¹⁰⁴ Түүнчлэн сургуульд багш нарын хүйсийн харьцаа тэнцвэргүй байгаа нь зайлшгүй бөгөөд багшийн ажил эмэгтэй хүнд илүү тохиромжтой гэсэн жендэрийн хэвшмэл үзэл бүхий байр суурийг илэрхийлсэн байна.

Эрэгтэй хүн ерөнхий рамаа хардаг, цаг хугацаанд ажлаа хийдэггүй, хичээлийн бэлтгэл хийдэггүй. Бага ангийн эрэгтэй багш шалчигнаад эмэгтэйгээсээ дор, олон эмэгтэйн халамжид орчих гээд. Багын багшийг эрэгтэй хүнээр төсөөлдөггүй.

ЕБС-ийн удирдах ажилтантай хийсэн ярилцлага¹⁰⁵

Үүнээс дүгнэхэд сургуулийн удирдах ажилтнуудын жендэрийн ойлголт хангалтгүй байгаа нь аймаг, дүүргийн боловсролын газраас жендэрийн талаар баримтлах бодлого, чиглэл өгдөггүй, сургуулийн албан тушаалтнуудад сургалт ордоггүйгээс шалтгаалж байж болох юм. Түүнчлэн удирдлагууд багшийн ажилд эмэгтэй хүн тохирно гэсэн үзэлтэй байгаа нь эрэгтэй багшийг дэмжихгүй байх, эмэгтэй багшийг эрэгтэйгээс илүү үнэлэх байдлаар эрэгтэй багшийн мэргэжлээрээ ажиллах хүсэл эрмэлзэлд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм.

Сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл БШУЯ-ны сайдын 2022 оны А/214 дүгээр тушаалаар ЕБС, дотуур байрны орчинд суралцагчийг үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажиллагаанд баримтлах чиглэлийг баталжээ. Тус

104 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 116-117

105 Мөн тэнд, 104

чиглэлд боловсролын байгууллага нь дотоод дүрэм, журамдаа уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга тусгах, хэрэгжүүлэх, багш, ажилтан, эцэг, эх асран хамгаалагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, нөхцөл байдлыг үнэлэх, тогтмол хяналт тавих, хараа хяналтыг нэмэгдүүлэх, гомдол, мэдээлэл хүлээж авах тогтолцоог бүрдүүлэх, хариу үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ эцэг, эхийн зөвлөлтэй хамтран хэрэгжилтийн тайланг хийж, жил бүрийн 06 сарын 10-ны өдрийн дотор Боловсролын ерөнхий газарт ирүүлэхээр тусгасан.¹⁰⁶

Энэ талаар сургуулиудын нөхцөл байдлыг авч үзвэл судалгаанд хамрагдсан сургуулиудын дотоод журам, ёс зүйн дүрэм, сурагчийн дүрэм зэрэгт жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийллийн эсрэг заалтуудыг тодорхой хэмжээнд тусгаж өгсөн байна. Гэвч сургуулийн орчинд хүйсээс хамааран ялгаварлан гадуурхалтад эсвэл бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хариу ямар арга хэмжээг авах талаар зарим сургуулийн эрх зүйн баримт бичигт тусгаагүй байв. Тодруулбал, нийт 68 удирдах ажилтны 58.8 хувь нь л хариу арга хэмжээ тусгагдсан гэсэн.¹⁰⁷ Мөн хүүхдүүдийн 14.3 хувь нь бусад хүүхдүүдийн зүгээс дээрэлхэх, нэр хоч өгөх, ялгаварлан гадуурхах явдалд өртөж байсан бөгөөд энэ үзүүлэлт нийслэлд 17 хувь, төрийн өмчийн сургуульд 15.1 хувь буюу хамгийн өндөр байна.

Ялгаварлан гадуурхалтад өртсөн хүүхдүүдийн 3 хувь нь олон удаа, 16 хувь нь ганц, хоёр удаа өртсөн гэжээ. Хүүхэд дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад олон удаа өртөж байгаа нь сургуулийн зүгээс ямарваа нэгэн арга хэмжээ авахгүй байгааг илтгэх үзүүлэлт бөгөөд ялгаварлан гадуурхалт, ялгаатай байдлын талаарх хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллах¹⁰⁸ үүргээ хангалтгүй биелүүлж байгааг илэрхийлж байна.¹⁰⁹ Түүнчлэн судалгаанд оролцсон багш нарын 14,3 хувь нь сургуулийн орчинд хөвгүүдийг бие махбодын хүчирхийлэлд өртдөг гэсэн бол 7.5 хувь нь охидууд бие махбодын хүчирхийлэлд өртдөг гэж хариулжээ.¹¹⁰ Үүнээс сургуулийн орчинд бие махбодын хүчирхийллийн хохирогч нь ихэвчлэн хөвгүүд байгааг харж болно. Энэ нь хүчирхийллийн эсрэг авах хариу арга хэмжээ хангалттай биш байгаагаас гадна сургуулийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байж болох юм. Энэ талаар чанарын судалгааны үр дүнгээс тодруулбал:

106 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 100

107 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 120-121

108 БШУС-ын сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн А/239 дугаар тушаал Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмын 3.1.4 дэх заалт, УБ, 2018 он.

109 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 101-102

110 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 121

Сургуулийн нийгмийн ажилтанд хүүхдийн нийгмийн хамгаалал гэх гол үүргээс илүүтэй өөр чиг үүргийг сургуулийн удирдлагуудаас даалгах явдал элбэг тохиолддог. Үүнээс шалтгаалаад сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэлд авах хариу арга хэмжээ хангалтгүй байна.

Иргэний нийгмийн төлөөлөл

Сургуулийн нийгмийн ажилтан хувь хүний мэдээллийг задруулахгүй байх нь чухал асуудал гэж харагдсан. Нийгмийн ажилтанд хандахад нийтэд задрахаар байдлаар асуудлыг шийдвэрлэж буй сургуулиудад хүүхдүүд нийгмийн ажилтанд хандах нь цөөн байсан.

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

Дээрхээс дүгнэхэд сургуулийн орчинд охидоос илүү хөвгүүд бие махбодын хүчирхийллийн хохирогч болж байна. Гэсэн хэдий ч сургуулийн дүрэм, журам хүчирхийллийн эсрэг авах арга хэмжээ зарим сургуулиудын хувьд тусгагдаагүй байна. Мөн хүүхдийн хамгаалал, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий нийгмийн ажилтан гол чиг үүргээ хэрэгжүүлэхээс илүүтэй удирдлагын өгсөн зааврын дагуу өөр ажлуудад төвлөрч буй нь асуудал болж байна. Түүнчлэн нийгмийн ажилтны ёс зүй хангалтгүй байгаагаас хүүхдүүд хамгаалал хүртэх эрхээ эдэлж чадахгүй байдалд хүрч байна. Энэ нь хүчирхийллийн хохирогч болж буй хөвгүүдэд илүү сөргөөр нөлөөлөх буюу сэтгэл зүйн асуудал үүсэх, бэртэж гэмтэх, хичээлдээ явах сонирхолгүй болох зэрэг үр дагавартай.

3. Хэвлэл мэдээллийн байгууллагын нөлөөлөл

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх жендерийн мэдрэмжгүй байдал нь сурагчдад болон олон нийтийн жендерийн эрх тэгш байдлын тухай ойлголтод нөлөө үзүүлж, хөвгүүдийн ирээдүйн хүлээлт, боловсролын оролцоо зэрэгт дам байдлаар нөлөөлдөг. Сүүлийн үеийн судлаачид хэвлэл мэдээллийг 2 хэсэгт ангилж, ялгавартайгаар авч үзэж байна. Энэ нь мэдээлэл хайх, хүлээн авах, цуглуулах, боловсруулах, нягтлах, нийтлэх, нэвтрүүлэх, түгээх чиг үүрэгтэй “сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл” (Journalism Media), хэвлэл мэдээллийн байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэрэгсэл ба олон нийт мэдээллээ солилцож, түгээдэг талбар болох нийгмийн хэвлэл мэдээлэл (Social Media- фэйсбүүк, твиттэр, инстаграм, ютүб зэрэг) гэсэн хэсгээс бүрдэж байна.¹¹¹ Иймд доорх хэсэгт

¹¹¹ Жендерийн үндэсний хороо, Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендерийн мэдрэмжид хийсэн үнэлгээ (2020), 6, <https://sudalgaa.gov.mn/pdf/setgl-zyn-ba-niygmiyn-khevlal-medeeiliyn-bodlogyn-zhenderiyn-medrem-nmf> Сүүлд хандсан 2024.09.6

сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл болон нийгмийн хэвлэл мэдээлэл дэх жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагын асуудлыг тусад нь авч үзэв.

Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжгүй агуулга тусгагдсан байдал

Жендэрийн үндэсний хорооноос хийгдсэн үнэлгээнээс¹¹² харахад улс төр, хууль тогтоох үйл явц, Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээний эх сурвалжийн 80 хувь нь эрэгтэйчүүд байна. Өдөр тутмын сонинд 10 эрэгтэй хүн тутмын 4 нь улс төрч, албан тушаалтнаар дүрслэгдэж байгаа бол эмэгтэйчүүдийг “иргэн”-ий хувьд харуулж байна. Телевиз болон радиод эрэгтэйчүүдийг албан хаагч, улс төрч дүрээр илүү дүрслэн харуулж байгаа бол мэдээллийн сайтад эрэгтэйчүүдийг дүрслэхдээ 2 эрэгтэй тутмын нэг нь улс төрч, албан тушаалтны дүрээр буулгасан байна. Өдөр тутмын сонин, телевиз, мэдээллийн сайт, радиогийн нэвтрүүлгийн эдийн засаг, бизнесийн сэдэвт агуулгад эрэгтэйчүүд илүү их дүрслэгдэж байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байгаа талаар дурджээ.

Сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжгүй байдал ЮНЕСКО-гоос Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагуудтай хамтран “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулсан. Жендэрийн үндэсний хороо энэхүү шалгуур үзүүлэлтээс зарим үзүүлэлтийг тусгайлан авч Монгол Улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг хийсэн байна. Энэ талаар доорх хэсэгт дэлгэрүүлэн авч үзлээ.

1. Хэвлэл мэдээллийн практик үйл ажиллагааны (эх сурвалж зэрэг) талаарх тусгай заалт бүхий жендэрийн (бичгээр үйлдсэн) бодлого хэрэгждэг эсэх.

2017 онд хийгдсэн “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулгаас харахад, редакцид “жендэрийн тэгш байдлыг нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, бичлэгт хангах, санамсаргүй алдаанаас сэргийлэхэд тус болох зорилго бүхий удирдамж, гарын авлага, санамж” тухайн байгууллагад байхгүй хэмээн 70% хариулжээ. Мөн 2020 оны үнэлгээний хүрээнд 30 редакцын ерөнхий редакторуудаас “Жендэрийн эрх тэгш байдал, ЖСХ-ийн талаар мэдрэмжтэй бөгөөд ёс зүйтэй бичих” тухай бодлогын баримт бичиг бий юу гэсэн асуултад 25 редакц буюу 83,3% нь үгүй/байхгүй хэмээн хариулжээ.¹¹³ Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэггүйг тодорхойлж байна.

112 Жендэрийн үндэсний хороо, Монголын хэвлэл мэдээллийн агуулга, үйл ажиллагаан дахь жендэрийн мэдрэмжтэй байдал, тэгш байдлын шалгуур: Гарааны нөхцөл байдлын үнэлгээ (2021), <https://www.ncge.gov.mn/wp-content/uploads/2023/12/7147a8e8749ffe244be796a7d16cfea8.pdf> Сүүлд хандсан 2024.09.6

2. Хүйсийн төлөөллийн талаарх заалт бүхий (бичгээр үйлдсэн) ёс зүйн код мөрддөг эсэх.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн ёс зүйн хариуцлагыг иргэний оролцоотой хэрэгжүүлдэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны эхээр байгуулагдсан.¹¹⁴ Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг баталсан. Энэхүү “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-д хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэг нь жендэрийн мэдрэмжтэй байх, хэвлэл мэдээлэлд эх сурвалжуудын дуу хоолойг илэрхийлэхдээ жендэрийн тэгш байдлыг хангах, жендэр болон ЖСХ-ийн талаар нийтэлж нэвтрүүлэхдээ тодорхой зарчмуудыг баримтлах тухай нарийвчилсан, тусгайлсан заалт байхгүй байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ХМЗ-өөс баталсан ёс зүйн зарчмыг мөрдлөг болгохоос гадна тухайн редакц нийтлэл, нэвтрүүлгийнхээ онцлогоос хамааран дотоод дүрэм журам, бодлоготой, мөн ёс зүйн нарийвчилсан удирдамжтай байх тохиолдол бий.¹¹⁵ Гэвч хэвлэл мэдээллийн байгууллагуудын редакцын бодлогод жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй байдал, ЖСХ-ийн талаар тусгайлан дурдаагүй, мөн ийм төрлийн дагнасан бодлогын баримт бичиг, гарын авлага, дүрэм, журам байхгүй байна.¹¹⁶ Үүнээс харахад хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэрийн мэдрэмжгүй, жендэрийн тэгш байдлыг хангалгүйгээр нийтэлж, нэвтрүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизм байхгүй байна.

3. Мэргэжлийн баг, тэр дундаа ерөнхий редактор жендэрийн ба олон талт бодлого, жендэрийн болон олон талт мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага, хөтчийн талаар ойлголттой бөгөөд тэдгээрийг хүлээн зөвшөөрдөг эсэх.

2017 онд хийгдсэн санал асуулгаас харахад, Жендэрийн тэгш байдал гэдэгт “эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүх зүйлд ижил тэгш байх” хэмээн 42%, “нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш оролцох боломжоор хангагдах” хэмээн 14% хариулжээ. Судалгаанд оролцогсдын 35% нь уг асуултад хариулахаас татгалзсан нь энэ талаар ойлголт мэдлэггүй байна гэж болно. Мөн 2020 онд энэхүү үнэлгээний хүрээнд 30 редактораас “жендэр, ЖСХ-ийн талаар таны болон танай редакцынхны ойлголт мэдлэг хэр хангалттай байна вэ? гэсэн асуултад 3 редактор маш сайн, хангалттай мэдээлэлтэй гэсэн бол 14 редактор хангалттай боловч сайжруулах шаардлагатай, 10 редактор дундаж мэдээлэлтэй, 4 редактор мэдлэг байхгүй хэмээн хариулжээ.¹¹⁷ Иймд Редакторуудын түвшинд жендэрийн ойлголт ба жендэрийн олон талт бодлогын талаарх ойлголт, төсөөлөл дутмаг гэж дүгнэхээр байна.

4. Жендэрийн бодлого, жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага,

114 Тус зөвлөл нь сонин/сэтгүүл, радио/телевиз, цахим сайт, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн гэсэн таван салбарыг төлөөлөх 45 гишүүнтэй (зургаан жилийн хугацаатай) бөгөөд тэдгээр нь Удирдах зөвлөл, Сонин, сэтгүүл, сайтыг ёс зүйн хороо, Радио, телевизийн ёс зүйн хороонд хуваагддаг.

115 Мөн тэнд, 9-10

116 Мөн тэнд, 13

117 Мөн тэнд, 16

хөтөч, сургалт семинар зэрэг арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, үр дүнг үнэлэх зорилгоор хэвлэл мэдээллийн агуулгад үе шаттай, тогтмол дотоод хяналт шинжилгээ хийдэг эсэх.

2017 оны судалгаагаар нийт редакцуудын 18% нь сэтгүүлчдийнхээ бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгийг жендерийн тэгш байдлын өнцгөөс тогтмол хянаж, мониторинг хийдэг гэсэн байна. Эдгээр нь УБ хотод үйл ажиллагаа явуулдаг 1 радио, 3 телевиз, 2 мэдээллийн сайт, 2 сонин багтаж байна.¹¹⁸ Тиймээс сэтгүүлчдийн бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгт агуулгын хяналт хийхдээ жендерийн тэгш байдлын үүднээс хянаж буй практик хангалтгүй байна. Мөн Монгол Улсад хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны тайлангаас үзэхэд мэдээллийн хоёр сайтын эх сурвалжуудын 77 хувь нь эрэгтэй, 23 хувь нь эмэгтэй, өдөр тутмын сонины эх сурвалжуудын 26 хувь, телевизүүдийн 29 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, зөвхөн МҮОНР болон Гэр бүлийн радиогийн агуулга дахь эх сурвалжуудын 48 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн эрэгтэйчүүдийг ихэвчлэн ажил хэрэгч, албан тушаалтан, улс төрч дүрээр, харин эмэгтэйчүүдийг албаны бус зургаар, энгийн иргэн, ээж, гэргий, эсвэл мэргэжилтнээр илүүтэй дүрсэлдгийг уг судалгаанд онцолсон байна (Хэвлэлийн хүрээлэн, 2017).¹¹⁹ Үүнээс дүгнэхэд хэвлэл мэдээллийн агуулгад эрэгтэй, эмэгтэй хүйсийн тэнцвэр хангагдаагүй байна. Мөн эрэгтэйчүүдийг албаны дүрслэлээр эмэгтэйчүүдийг албаны бус дүрслэлээр гаргаж байгаа нь жендерийн хэвшмэл ойлголтыг бий болгож байна.

Нийгмийн хэвлэл мэдээлэл дэх жендерийн мэдрэмжгүй байдал

Нийгмийн хэвлэл мэдээлэл нь сэтгүүлчдийн ажлаа хийх талбар болж байдаг тул сэтгүүлчдийн дагаж мөрддөг зохицуулалтууд сошиал орчинд нэгэн үйлчилдэг. Тиймээс дээрх хэсэгт авч үзсэн судалгааны үр дүн, дүгнэлтүүд энэ хэсэгт нэгэн адил хамаарна. Түүнээс гадна сэтгүүлчид нийгмийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж жендэр, ЖСХ-ийн тухай ойлголт, мэдлэгийг олон нийтэд хүргэх шаардлагатай боловч уншигчдын сэтгэгдлийг хайхралгүй орхиж болохгүй. Хэрэглэгчийн хариу үйлдэл, сэтгэгдэл, бусадтай хуваалцаж буй байдал зэрэг нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх хэлбэр боловч тэднийг зөв зохистой хэрэглээнд сургах нь хэвлэл мэдээллийн бодлогын гадна үлдэх учиргүй. Иймээс хэвлэл мэдээллийн редакцууд бүтээлээ хэвлэн нийтлээд түгээгээд орхих бус түүний доорх хэрэглэгчдийн сэтгэгдэл, санал бодолтой харилцаж, шаардлагатай бол тэдний ёс зүйгүй үйлдлийг таслан зогсоох, хүний эрх, жендерийн мэдрэмжгүй үг хэллэг, жендерийн хэвшмэл ойлголтыг засаж залруулах үүргийг давхар хүлээх нь зүйтэй юм. Цахим сайтуудын мониторингоос харахад, сайтын сэтгэгдэл хэсэгт эсвэл нийгмийн мэдээллийн хэрэгсэлд илэрхийлсэн хэрэглэгчийн сэтгэгдэл нь редакцын байр суурь биш бөгөөд хариуцлага хүлээхгүй тухайгаа илэрхийлжээ. Хэдийгээр иргэний үзэл бодол нь редакцын байр суурийг илэрхийлэхгүй боловч сэтгэгдлийг редакц хайхрахгүй өнгөрч болохгүй. Учир нь коммент буюу сэтгэгдэл

118 Мөн тэнд, 20

119 Жендерийн үндэсний хороо, Жендерийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй (2021), 14, https://resource4.sodonso-lution.org/mediacouncil/File/2021/10/27/oo3fo0f6bq6qzcccq/Genderiin_medremj_yos_zuitei_setguul_zui_udirdamj.pdf Сүүлд хандсан 2024.09.6

бичих талбар бол тухайн редакцын үйл ажиллагааны нэг хэсэг юм. Иймээс редакц хэрэглэгчтэйгээ сэтгэгдлээр нь дамжуулан тогтмол харьцах, хяналт мониторинг хийх, зохисгүй агуулга илэрвэл модератор хийх буюу тэмдэгтийг өөрчлөх, эсвэл устгах зэрэг дотоод өөрийн зохицуулалтаа хийх шаардлагатай. Одоогийн байдлаар Монгол контент ХХК-аас эрхлэн гаргадаг Yolo.mn, Maamuu.mn сайтууд редакцын бодлогодоо “олон нийтийн зарчим”-ыг тусгасныг эс тооцвол ийм практик туршлага, оролдлогууд бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудад хараахан бүрэлдээгүй байна. Тус редакцууд олон нийтийн зарчимдаа хэрэглэгчийн бусдыг доромжилсон, гутаасан, үзэн ядсан, ёс бус сэтгэгдлийг редакцын зүгээс устгах тухайгаа мэдэгджээ.¹²⁰ Үүнээс дүгнэхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудын ихэнх нь социал медиа ашиглан түгээсэн мэдээ, мэдээллийн доор бичигдсэн ёс бус, жендерийн мэдрэмжгүй, хэвшмэл ойлголтыг түгээсэн сэтгэгдэлд авах хариу арга хэмжээний бодлогыг хэрэгжүүлэхгүй байна.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд хэвлэл мэдээллийн байгууллагууд тулгарч буй асуудлуудаас үүдээд жендерийн мэдрэмжгүй агуулга түгээгдэж, хөвгүүдэд боловсрол эзэмшсэн эсэхээс үл хамааран эрэгтэй л бол улс төрч, ажил хэрэгч байдаг, хөвгүүд хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогч байх нь хэвийн бус үзэгдэл гэсэн мэдрэмжийг төрүүлж, асуудал тулгарахад бусдад мэдээлэхгүй нуух, дотроо хадгалах, сэтгэл зүйн дарамтад орох нөхцлийг бүрдүүлэх эрсдэлтэй байна.

МАКРОСИСТЕМ

Макросистемийн түвшинд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, нийгэм-эдийн засгийн ялгаатай байдал, байршил, жендерийн бодлого, мэргэжлийн эрэгтэй багшийн дутагдал, хөвгүүдийн онцлогт нийцээгүй сургалтын хөтөлбөр, арга зүй зэрэг нөлөөллүүдийг авч үзнэ.

1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт гэх ойлголт нь хүүхэд хэт их цагаар эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох, тэдний оролцож байгаа эдийн засгийн үйл ажиллагаа нь нийгмийн болон ёс суртахууны хувьд зохимжгүй гэж үзэн хориглосон, эсвэл хөдөлмөрийн насны доод хязгаараас бага настай хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл, тэдний эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх, сурч боловсроход саад учруулах нөхцөл байдлыг илэрхийлдэг.¹²¹ Энэ талаар Монгол Улсын хэмжээн дэх тоон үзүүлэлтийг авч үзвэл хүүхдийн хөдөлмөрийн түвшин хүйсийн хувьд хөвгүүд охидоос илүү байна (Хөвгүүдийнх 19.9%, охидынх 12.5%). Байршлын хувьд хөдөөд хот суурин газрынхаас илүү байна (Хөдөөд 30%, хотод 10.2%). Бүс нутгийн хувьд, Улаанбаатар

120 Жендерийн үндэсний хороо, Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендерийн мэдрэмжид хийсэн үнэлгээ (2020), 52

121 ҮСХ, Монгол Улсын хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (2023), 37, https://mlsp.gov.mn/uploads/files/Хүүхдийн%20хөдөлмөрийн%20судалгаа_2021-22.pdf Сүүлд хандсан 2024.09.6

хотод хамгийн бага (10.0%), Баруун бүсэд хамгийн өндөр (36.3%) байна.¹²² Энэ нь Монгол Улсын нүүдлийн мал аж ахуй эрхлэлт, ахуйн соёл болон дэд бүтцийн асуудалтай холбоотой.¹²³ Энэхүү тоон мэдээллээс харахад хөвгүүд охидоос илүү хөдөлмөр эрхэлж, үүнээс шалтгаалан сургууль завсардсан хүүхдүүд нь зөвхөн хөвгүүд байна.

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 91.4% нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, 3.7% нь зөвхөн цалин хөлс, орлого олох үйл ажиллагаа, 0.2% нь зөвхөн цалин хөлсгүй дадлагажих үйл ажиллагаа эрхэлсэн бол 4.7% нь эдгээр үйл ажиллагааг давхар эрхэлсэн байна.¹²⁴ Үүнээс хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн зорилго нь орлого олох зорилготойгоос илүү өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд туслах зорилготой гэж дүгнэхээр байна.

Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа тоон мэдээллийг дэлгэрүүлэн авч үзвэл, 40.9% нь мал аж ахуйн салбарт, 17.3% нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 14.1% боловсруулах үйлдвэрлэлийн, 9.6% нь газар тариалан, ойн аж ахуйн, 8.4% нь барилгын салбарт ажилласан байна.¹²⁵ Тэдний 51.8% нь суурь боловсрол эзэмших насны буюу 6-14 насны хүүхэд байгаагийн 2.3% нь сургуульд сурдаггүй, зөвхөн хөдөлмөр эрхэлж байна. Хүйсийн хувьд зөвхөн хөвгүүд байна.¹²⁶ Үүнээс цалин хөлс олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдээс мал аж ахуйн салбарт ажиллаж буй хөвгүүдийн сургууль завсардах эрсдэл хамгийн өндөр гэж харагдаж байна.

Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн хүүхдүүдийн 66.0% нь өрхийн хэрэглээндээ зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөсөн, 38.0% нь түлээ бэлтгэсэн, 35.8% нь өрхийн хэрэгцээндээ зориулан мал, тэжээвэр амьтан өсгөх, үржүүлэх үйл ажиллагаанд оролцсон байна. Эдгээр хүүхдүүдийн 62.6 хувь нь хөвгүүд, 37.4 хувь нь охид, байршлын хувьд 42.8 хувь нь хот, суурин газарт, 57.2 хувь нь хөдөө амьдарч байна.¹²⁷ Мөн долоо хоногт зарцуулах дундаж цагийн хувьд хөвгүүд охидоос илүү цаг зарцуулж байна. Түүнчлэн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож байгаа 6-14 насны хүүхдийн 96.6 хувь нь сургуульд сурдаг, 3.4 хувь нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Уг хандлага хүйсийн хувьд хадгалагдаж, харин байршлын хувьд хөдөөд 4.6 хувь, хот, суурин газарт 1.9 хувь нь сургуульд сурдаггүй хүүхэд байна.¹²⁸ Үүнээс харахад өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хөдөөгийн хүүхдүүдийн сургууль завсардах эрсдэл өндөр байна. Мөн нийт өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн хөвгүүдийн хувь болон ажилд зарцуулж буй цаг нь охидоос илүү байгаа нь хөвгүүдэд хичээл давтах цаг багасч, сурлагын амжилт муудах эрсдэл өндөр байгааг харуулна.

122 Мөн тэнд, 37

123 Мөн тэнд, 38

124 Мөн тэнд, 40

125 Мөн тэнд, 42

126 Мөн тэнд, 45

127 Мөн тэнд, 45

128 Мөн тэнд, 47

Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн өрхийн тэргүүлэгч нь эрэгтэй эсвэл эмэгтэй байгаа хувь хэмжээ төдийлэн ялгаатай биш байна (эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 14.1 хувь нь, эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 16.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байна). Ам бүлийн хувьд 7-8 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн хувь өндөр байгаа¹²⁹ ч мөн л төдийлэн их ялгаатай биш байна. Харин өрхийн тэргүүний боловсролын түвшин буурах тусам хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 10.2 хувиас 33.2 хувь болж өссөн байна.¹³⁰ Түүнчлэн өрхийн сарын дундаж орлогын хувьд, сард 1400.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхийн хүүхдүүдийн 9.1 хувь, 800.1-1400.0 мянга болон 140.0 мянга хүртэлх төгрөгийн орлоготой өрхийн хүүхдүүдийн 16.2-17.7 хувь, 140.1-600.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн хүүхдүүдийн 25.1-28.0 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.¹³¹ Үүнээс хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд өрхийг хэн тэргүүлэх болон ам бүлийн тоо хэд байх нь нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг хийх боломжгүй юм. Харин өрхийн тэргүүний боловсролын түвшин, өрхийн сарын дундаж орлогын түвшингээс хамаарч хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь өсөх эсвэл буурах хандлагатай байгааг дүгнэж болохоор байна. Гэхдээ үүнээс гадна чанарын судалгааны үр дүнгээс харахад өрхийн орлогын хэмжээнээс үл хамааран хөвгүүд өөрсдөө захиран зарцуулах мөнгө олохын тулд хөдөлмөр эрхэлж байгаа нь харагдаж байна.

Манай ангид ажил хийдэг 3 хөвгүүн байдаг. Гэхдээ өрхийн орлого амьжиргааны түвшинээс доогуур биш, харьцангуй боломжийн. Тэд өөрсдийн хэрэгцээгээ хангахын тулд ажил хийж байна. Ажил хийснээс шалтгаалаад өглөө эхний цаг дээр унтаж, сурлагын амжилт эрс буурч, хичээл хүлээн авах чадвар маш хангалтгүй болдог.

Багштай хийсэн ярилцлага

Иймд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс үүдэлтэй сурлагын амжилт муудах, сургууль завсардах эрсдэл өрхийн орлого доогуур, өрхийн тэргүүний боловсролын түвшин доогуур, хөдөө орон нутагт амьдардаг хөвгүүдэд илүү өндөр байна. Мөн амжиргааны түвшин дундаж өрхийн хөвгүүдийн хувьд нийгмийн жендэрийн үүргийн талаарх хэвшмэл ойлголттой холбоотой хөвгүүдэд эдийн засгийн сонирхол, хэрэгцээ өндөр байх магадлалтай. Үүнээс үүдсэн хөдөлмөр эрхлэлт байж болохыг үгүйсгэхгүй. Эцэг эхчүүд хөвгүүдийн эдийн засгийн хэрэгцээг үл хайхрах, нөгөөтэйгүүр ажил эрхлэхийг дэмжих хандлагатай байхыг үгүйсгэхгүй.

129 Мөн тэнд, 59

130 Мөн тэнд, 59

131 Мөн тэнд, 60

2. Нийгэм-эдийн засгийн ялгаатай байдал

Боловсролын шууд бус зардлууд болох хичээлийн хэрэглэл, дүрэмт хувцас, унаа, хоолны зардал нь амьжиргааны түвшин доогуур өрхийн хувьд санхүүгийн хүндрэлийг бий болгож байдаг. Сургуульд сурч байгаа хүүхдийнхээ шууд бус зардлыг төлж чадахгүй тохиолдолд хүүхэд үе тэнгийнхнээсээ ичих, багш нар “хичээлийн бэлтгэлгүй ирлээ” хэмээн буруутгах, шийтгэдэг нь сургуулиас завсардах шалтгааны нэг болдог байна.¹³² Мөн өмнөх хэсэгт чанарын судалгааны үр дүнд дурдсанчлан амьжиргааны түвшин доогуур байгаа өрхийн хөвгүүдийн хувьд эдийн засгийн ялгаатай байдлаас шалтгаалсан санхүүгийн хүндрэл, хөдөлмөр эрхэлж орлого олох шаардлага үүсч байгаа нь асуудал болж байна. Иймд эдийн засгийн ялгаатай байдал нь хөдөлмөр эрхлэх шаардлага үүсгэх, сурахад хэрэгтэй материаллаг дэмжлэг хангалтгүй байх гэсэн хоёр хэлбэрээр хөвгүүдийн боловсролын оролцоонд нөлөөлж байна.

3. Газар зүйн байршил

Сургууль, гэр хоорондын зайны нөлөөлөл Сургууль алслагдмал байршилтай байдаг нь боловсролд хамрагдахад тулгардаг нэгэн том бэрхшээл болдог байна. Үндэсний Статистикийн Хорооны 2020 оны мэдээнээс харахад Монгол Улсын нийт өрхийн 21.8 хувь нь төв суурин газраас алслагдмал хөдөөгийн багт нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарч байна. Зарим тохиолдолд сумынхаа төвөөс 100 км, 200 км-ийн зайд ч амьдардаг өрх байдаг. Иймд эдгээр өрхийн хүүхдүүд хичээлийн жилийн турш сургуулийн орчинд дотуур байранд амьдардаг нь Монгол орны нэг онцлог юм. Харин хот суурин газрын уугуул иргэд хамгийн ойр ЕБС-иас 1.1 км-ийн зайд амьдардаг. Хөдөө орон нутгаас шилжиж ирсэн иргэдийн хувьд хот суурин газрын зах хавиар амьдардаг тул хамгийн ойр ЕБС нь дунджаар 6.8 км-ийн зайтай байдаг.¹³³ Үүнээс дүгнэхэд хөдөө орон нутагт сургууль гэр хоорондын зай хол бөгөөд хөвгүүдийн хувьд дотуур байрны асуудлаас шалтгаалан хүндрэл үүсч байна. Мөн хөдөө орон нутгаас хотруу шилжин ирж байгаа айлуудын сургууль хүртэлх зай хол байгаагаас сурагчид хичээл таслах, хоцрох магадлал өндөртэй байна. Энэ нь ялангуяа хөвгүүдэд элбэг тохиолдож, сурлагын амжилт, хичээлийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг болох нь багш нартай хийсэн ярилцлагын үеэр нотлогдов.

СИТИ.МОН
СУДАЛГААНЫ САН

132 Боловсрол эвсэл, “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд нь тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан” (2020), “Амжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчийг сурах бололцоогоор хангах талаарх бодлого, түүний хэрэгжилт” (2021)

133 ЮНЕСКО, Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ (2019), 146, https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687_mon/PDF/373687mon.pdf.multi Сүүлд хандсан 2024.09.6

Гэр нь сургуулиас хол байдаг хөвгүүд эхний цагийн хичээл таслах, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдахгүй байх нь элбэг байдаг. Үүнийг дагаад сурлагын амжилт, идэвх мууддаг.

Багштай хийсэн ярилцлага

Дотуур байрны орчин Хөдөө орон нутгийн сурагчдын хувьд сургууль гэр хоорондын зай хол учир дотуур байранд амьдрах шаардлага үүсдэг. Тиймээс дотуур байран дахь асуудал сурагчдад нөлөө үзүүлэгч нэгэн хүчин зүйл болдог. Энэ талаар авч үзвэл дотуур байранд хүүхдийг дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, нэр хоч өгөх явдал нэлээд ажиглагддаг байна. Ялангуяа, бага ангийн хүүхдүүд бие биедээ нэр хоч өгөх, шоолох дунд ахлах ангийн хөвгүүд бие биенийгээ дээрэлхэх тохиолдол элбэг байдаг. Энэ тохиолдолд дотуур байрны багшид ханддаг боловч тэр бүр үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж чаддаггүй байна.¹³⁴ Дотуур байранд хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах талаар нэгдсэн зураглал байдаг эсэх, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг талаарх асуултад хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах зураглал тэр бүр байдаггүй талаар ярилцлагад оролцогчид нийтлэг хариулжээ. Ийм зураглал байгаа гэж зарим оролцогч хариулсан ч тодорхой хариулт хэлээгүй, хэрэгжүүлдэг эсэх нь бүрхэг байна. Харин зарим оролцогч нь зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авах зураглал гэж мэдэхгүй, тэр талаар ойлголцогч байсан.¹³⁵

Түүнчлэн тухайн асуудалтай холбоотойгоор дотуур байрны ажилтнуудын хүүхэд хамгааллын тухай ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын талаар тодруулж асуусан байна. Ярилцлагад хамрагдсан тогооч, жижүүр багш нарын хувьд 7 хоног, 3 эсвэл 2 хоногийн хугацаатайгаар “хүүхэд хамгаалал”, “сэтгэл зүй, харилцаа”, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад оролцдог байна. Гэвч тогооч нартай харьцуулахад жижүүр, багш нарын орон нутгийн түвшний сургалтад хамрагдах нь бага юм. Тэд зөвхөн сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн зохион байгуулсан нэг өдрийн сургалтад хамрагддаг.¹³⁶ Үүнээс дүгнэхэд дотуур байран дахь үе тэнгийнхний дээрэлхэлт, сөрөг харилцаа хөвгүүдийн дунд үүсэх нь элбэг байгаагаас гадна энэхүү зөрчлийн эсрэг авах хариу арга хэмжээ хангалтгүй байна. Энэ нь дотуур байрны багш, ажилчдын нийгмийн хамгааллын талаарх сургалт хангалтгүйтэй холбоотой байж болох юм. Ингэснээр дотуур байран дахь дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сөрөг харилцаа зэрэг нь хөвгүүдийн бие махбод, сэтгэлзүй, цаашлаад сурлагын амжилтанд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.

Дотуур байрны тааламжгүй орчинд хамаарах өөр нэгэн асуудал бол дотуур байрны биет орчны асуудал юм. Энэ талаар судалгаанд хамрагдсан сургуулийн

134 Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Дотуур байрны өнөөгийн байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаа (2024), 45, <https://sudalгаа.gov.mn/pdf/dotuur-bayrny-onoogiyn-baydal-khchin-chadlyg-todorkhoylokh-sudal-gaa-s5z> Сүүлд хандсан 2024.09.6

135 Мөн тэнд, 48

136 Мөн тэнд, 56-57

захирал, сургалтын менежерүүдийн олонх нь дотуур байрны менежментийг сайжруулснаар суралцагчдын сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд эерэг өөрчлөлт гарна гэж үзсэн байна. Судалгаанаас үзэхэд дотуур байрны нөхцөл, тохижилт зэрэг асуудалд сургуулийн удирдлага төдийгүй аймаг, орон нутгийн байгууллагууд жигд анхаарч байгаа ч энэ чиглэлээр цаашид үйл ажиллагааг тогтмолжуулах, холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийн ажил үүргийг тодорхой болгох шаардлагатай нь харагдсан байна.¹³⁷ Мөн чанарын судалгааны үр дүнд хөвгүүдийн дотуур байрны тохижилт охидынхоос илүү муу, тав тухгүй байдаг нь харагдсан.

Хөдөө орон нутгийн сургуулийн хөвгүүдийн дотуур байрны орчин нөхцөл маш хангалтгүй байдаг. Тэдний өрөөний тохижилт охидынхоос муу бөгөөд хичээл хийхэд хүндрэлтэй нөхцөл байдал ажиглагдсан.

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

Дээрхээс дүгнэхэд дотуур байран дахь үе тэнгийнхний дээрэлхэлт, сөрөг харилцаа, дотуур байрны тав тухгүй байдлаас үүдэлтэйгээр сэтгэлзүйн асуудал үүсэх, сурлагын амжилт муудах зэрэг үр дагавар нь хөвгүүдэд илүү үүсэх эрсдэл өндөр байна.

Орон нутгийн сургуулийн хангамжийн асуудал- Сургуулийн дэд бүтэц хангалтгүй, анги дүүргэлт ихтэй байх нь сурагчдын сурлагын амжилтанд нөлөө үзүүлдэг. Гэхдээ энэхүү асуудал нь тухайн улсын эдийн засаг, төсвийн хуваарилалттай холбоотой боловч орон нутгийн сургуулиудад менежмент муутайгаас үүдэлтэйгээр асуудал улам даамжирч байна. Энэ талаар авч үзвэл нутгийн сургуулиуд дэд бүтэцтэй холбоотой төрөл бүрийн хүндрэлтэй тулгардаг. Жишээлбэл, багш хурал, сургалтад хамрагдахад тээврийн зардал өндөр гардаг, төрийн үйлчилгээг хүртэхэд хязгаарлагдмал, дэд бүтэц сайтар хөгжөөгүй гэх мэт. Монгол Улсын хөдөөгийн сургуулиудад эдгээр сул талууд бүгд байдаг.

Мөн нэг багшид оногдох сурагчийн тоо хот суурины сургуулийнхтай харьцуулбал цөөн.¹³⁸ Бүлэг дүүргэлт хангалтгүйгээс зарим сургуулийн анги танхим хоосон, бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж, ашиглалтын зардалд төсвөөс үр ашиггүй хөрөнгө зарцуулдаг.¹³⁹ Зарим сумдын бага сургуулийн нийт хүчин чадлын талаас дээш хувьд нь бүлэг дүүргэлт хангалтгүй, хоосон байдалтай үргүй зардал гарган ажиллаж байхад тэдгээр сумдын ахлах сургуулиуд 2-6 дахин ачаалалтай байгаагаас үзвэл анхнаасаа сургуулийн насны хүн амын тоо, хэрэгцээ шаардлагад үндэслэж, сургуулийн хүчин чадал, ангиллыг оновчтой зохион байгуулаагүйг харуулж байна.¹⁴⁰

137 Мөн тэнд, 86

138 ЮНЕСКО, Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ (2019), 157

139 УАГ, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн (2021), 16

140 Мөн тэнд, 18



Архангай аймгийн Чулуут сумын 120 суудалтай бага сургуульд 21, 120 суудалтай ахлах сургуульд 675 буюу 6 дахин их хүүхэд хамрагдсан.

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нийт 135 суудалтай 2 бага сургуульд 44, 769 суудалтай ахлах сургуульд 1369 буюу 2 дахин их хүүхэд хамрагдсан.

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нийт 285 суудалтай 3 бага сургуульд 85, 760 суудалтай ахлах сургуульд 943 хүүхэд хамрагдсан.

Говь-Алтай аймгийн Тонхил сумын 60 суудалтай бага сургуульд 15, 320 суудалтай бүрэн дунд сургуульд 419 хүүхэд хамрагдсан байна.

Боловсролын үйлчилгээний үр ашигтай байдалд төрийн үүрэг бол хүн бүрийн сурч боловсрох эрхийг хангах гэдэг үүднээс үр ашгийг эрх тэгш байдалтай тэнцвэртэй байлгах хэрэгтэй. Тиймээс орон нутгийн нөхцөл байдалд тохирохгүй байгаа зарим норм, нормативыг эргэн харах шаардлагатай. Мөн орон нутгийн оршин суугчдаас чанартай сургууль гэдэгт ямар хүчин зүйлсийг ойлгодог талаар судалгаа авч сургуулийн чанарыг сайжруулах, элсэлтийг нэмэгдүүлэхийн тулд ямар хүчин зүйлс дээр анхаарах шаардлагатайг тодорхойлох нь зүйтэй юм.¹⁴¹

Дээрхээс дүгнэхэд хөдөө орон нутгийн сургуульд оногдож буй төсөв болон бусад хөрөнгө оруулалтыг үр ашиггүй зарцуулж, чанартай сургалт бий болгоход

141 ЮНЕСКО, Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ (2019), 158

шаардлагатай төлөвлөлтийг хийдэггүйгээс улбаалан сурагчдын сургуульд хамрагдалт хотын төвийнхтэй харьцуулахад бага байна гэж харагдаж байна. Мөн багшийн мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх нөөц боломж хязгаарлагдмал, хот руу ирэхэд гарах зардал өндөр¹⁴² байдгаас шалтгаалаад хөдөө орон нутгийн багшийн чанар хангалтгүй, тогтвортой ажиллах хүчин хомс байх магадлал өндөр байна.

Салбарын багш, ажилтны ажлын байрны эрэлт хэрэгцээ- Мэргэжлийн багшийн дутагдлаас үүдэлтэй сургалтын чанарын асуудал үүсдэг. Энэ нь ерөнхий боловсролын сургуулиуд боловсролын удирдлагын мэдээллийн систем болон салбарын статистик мэдээнд ажиллавал зохих багш, шаардлагатай багшийн тоог иж бүрэн, үнэн зөв тайлагнадаггүй, боловсролын газар болон БШУЯ-ны зүгээс мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангуулж ажиллаагүй, салбарын хэмжээний хүний нөөцийн нэгдсэн суурь мэдээлэлгүй байгаатай холбоотой байж болох юм.¹⁴³ Энэ талаар Үндэсний аудитын газраас хийгдсэн 2021 оны гүйцэтгэлийн тайланд дурдсан байна. Аудитын түүвэрт хамрагдсан сургуулиудад ажиллаж буй 244 багш мэргэжлийн бус, мэргэжлийн индекс зөрүүтэй, номын санч, нийгмийн ажилтан Бага дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Багш нь багшлах эрхтэй байна”, 21.3-т “Багш бус мэргэжлийн хүн заах арга зүйн сургалтад хамрагдсаны дараа багшлах эрх авна” гэсэн заалтыг хангаагүй байна. Тухайлбал:

Баянхонгор аймаг: Аймгийн 29 сургуулиас 25 сургуульд 1-4 багш буюу нийт 33 багш, 2 номын санч мэргэжлийн бус байна.

Баян-өлгий аймаг: Аудитад хамрагдсан 8 сургуулийн номын санчаар бага анги, англи хэлний багш, нягтлан бодогч, инженер мэргэжилтэй хүн ажилладаг.

Дорноговь аймаг: Хатанбулаг, Хөвсгөл суманд хими, физик, Алтаниширээ суманд физикийн хичээл заах багшгүйгээс хөтөлбөрийн дагуу хичээл ороогүй, 18 нийгмийн ажилтны 11 нь багш мэргэжилтэй, 8 сургуульд мэргэжлийн бус номын санч ажиллаж байна.

Говьсүмбэр аймаг: Аудитаар 4 сургуулийн номын санч, 2 сургуулийн нийгмийн ажилтан нь мэргэжлийн бус байна.

Хэнтий аймаг: Тус аймагт 2017-2019 онд дунджаар 471 багш ажиллаж байсан ба мэргэжлийн багшийн хангалт аймгийн түвшинд 75 хувьтай байна.

Ховд аймаг: ЕБС-д 24 номын санч ажиллаж байгаагаас 13 нь багш мэргэжилтэй, 4 бусад мэргэжлийн байна.

142 Унааны зардал, байрлах байр, хоол, бусад зардлууд

143 УАГ, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн (2021), 23

Сэлэнгэ аймаг: Баянгол сум болон Шаамар сумын Дулаанхаан тосгон, төрийн бус өмчийн Мандал сумын Билиг ДБ сургуулиуд мэргэжлийн нийгмийн ажилтангүй, Баянгол, Цагааннуур, Шаамар, Сайхан сумын 1-р, Мандал сумын 1, 3-р болон, Шаамар сумын Дулаанхаан тосгон, төрийн бус өмчийн Билиг ДБ зэрэг сургуулиуд мэргэжлийн номын санчгүй байна.

Орхон аймаг: 2016-2019 оны байдлаар дуу хөгжим, технологи, физик, орос хэлний багш жил бүр дутагдалтай байсан ба цаашидаа физик, хими, дуу хөгжмийн багшийн хүрэлцээ хангалтгүй болохоор байна. Мөн “иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг шинээр заахаар төлөвлөгөө, хөтөлбөрт тусгасан хэдий ч тухайн судлагдахуун заах багш бэлтгэгдээгүй, нийгмийн ухааны багш заахаар тусгасан байна.¹⁴⁴

Дээрх судалгааны үр дүнд дурдагдсан мэргэжлийн бус багш, ажилтан ажиллаж буй сургуулиуд бүгд хөдөө орон нутгийн сургуулиуд байна. Тиймээс багш, ажилтны эрэлтээс үүдэлтэй сургалтын чанар муу байх эрсдэл хөдөө орон нутагт илүү гэж дүгнэж болохоор байна.

Мөн салбарын яам ахлах ангийн сурагчдад өөрсдийн авьяас, сонирхол, ирээдүйн мэргэжлийн чиг баримжаандаа тулгуурлан хичээлээ сонгож судлах боломж олгох, дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцах залгамж холбоог хангах, ахлах сургуулийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж хэрэгжүүлж буй хэдий ч хөдөөгийн цөөн сурагчидтай сургуульд дээрх хэсэгт дурдсан багшийн хүрэлцээ, бүлэг бүрдэхгүй байх зэргээс шалтгаалан анагаах ухаан, биологи, газарзүй, технологийн чиглэлийн мэргэжлээр гүнзгийрүүлэн судлах боломж хязгаарлагдаж байна.¹⁴⁵ Иймд хөвгүүд өөрсдийн сонирхол, чадвар дээр үндэслэн гүнзгийрүүлэн судлах хичээлээ сонгох боломж хязгаарлагдсанаар хичээлийн оролцоо сулрах, гүйцэтгэл муудах үр дагаварт хүргэх эрсдэлтэй юм.

Сургалтын нөөц хэрэглэгдэхүүний хангамж, хүрэлцээ- Судалгаанаас харахад хичээлийн анги танхим, ширээ, сандал, тавилга хэрэгслээр хангагдсан байдлыг муу болон маш муу гэж үнэлсэн хувь орон нутгийн багш нарын дунд хамгийн өндөр байна. Мөн лаборатори хичээл, дадлага ажилд хэрэглэгдэх материал, түүхий эдээр хангагдсан байдлын үзүүлэлтэд орон нутгийн сургуулийн багш нарын 70 орчим хувь нь дундаас доогуур үнэлгээ өгсөн байна. Энэ нь баг, сумын төвийн сургуулиуд төв суурин газраас алслагдсан байдагтай холбоотой.¹⁴⁶ Үүнээс үзэхэд хөдөө орон нутагт сургалтын нөөц хэрэглэгдэхүүн хүрэлцээ, хангамж

144 Мөн тэнд, 24

145 Мөн тэнд, 38

146 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 98

муутай байгаа нь хөвгүүдийн суралцах онцлог, ялгаатай хэрэгцээ болох туршилт, дадлага ажилд суурилсан арга барилд нийцэхгүй байна. Ингэснээр хөвгүүдийн сурлагын амжилтад сөргөөр нөлөөлөх нэг үзүүлэлт болох юм.

4. Жендэрийн бодлого

Жендэрийн бодлоготой холбоотой үүсч буй асуудал нь улсын хэмжээнд ЕБ-ын түвшинд нэгдсэн жендэрийн бодлого хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгээс хийсэн “Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ судалгааны тайлан (2016)”-аас харахад сургуулийн удирдах ажилтнуудаас аймаг, дүүргийн боловсролын газраас жендэрийн талаар баримтлах бодлого, зөвлөмж өгдөг үү? гэж асуухад 100 хувь үгүй гэсэн хариултыг өгсөн бол аймаг, дүүргийн боловсролын газрын төлөөллөөс Боловсрол соёл, шинжлэх ухааны яамнаас ЕБС-ийн орчинд жендэрийн талаар баримтлах бодлого, чиглэл өгдөг үү? гэж асуухад мөн 100 хувь үгүй гэж хариулсан байна.¹⁴⁷ Түүнчлэн сурах бичгийн агуулга дахь жендэрийн хэвшмэл ойлголт нь хөвгүүдийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын амжилтад нөлөө үзүүлэгч хүчин зүйл болж байна.

“ЕБС-ийн сурах бичигт хүний эрхийн агуулга тусгагдсан байдалд дүн шинжилгээ хийхэд жендэрийн тэгш байдал, олон талт ялгаатай байдлын талаар сурах бичгийн агуулга хангалтгүй байна”, “Охид, эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй, хүйсийн, үүргийн хувьд тэнцвэртэй дүр дүрслэл үгүй, эрэгтэй эмэгтэй хүний үүрэг, ажил мэргэжил, шинж чанарын хувьд хэвшмэл, өрөөсгөл, тогтсон гадуурхлаар илэрхийлэгдсэн, хортой, шударга бус хүлээлтүүдийг аль аль хүйсэд тусгасан байна” зэрэг дүгнэлтүүдийг бусад судалгааны үр дүнд хийжээ.¹⁴⁸ Тухайлбал, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс хийж гүйцэтгэсэн ЕБС-ийн 6-12-р ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичгийн агуулгад хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээнээс харахад 6-7 ангийн Иргэний ёс зүйн боловсрол сурах бичигт текст болон зураглалын хувьд жендэрийн тэгш байдал хангалттай биш. Зурган дүрслэлийн 60 гаруй хувийг эрэгтэй дүр эзэлж байсан бол эмэгтэй дүр 30 орчим хувийг эзэлж байна. Текстийн хувьд ялгаагүй эрэгтэй дүр, эрэгтэй тайлбар дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна. Эрэгтэй хүн, эрэгтэй хүүхдийг ухаалаг, тууштай, хөдөлмөрч байдлаар дүрсэлсэн бол эмэгтэй хүн, охин хүүхдийг халамжлагч, уян зөөлөн сэтгэлтэй гэсэн жендэрийн хэвшмэл байдлаар дүрсэлжээ. Зурган дүрслэлүүдийн хувьд тодорхой жишээгээр эрэгтэй, эмэгтэй аль аль дүрийг хамтад нь оруулж дүрслэх оролдлого гарсан боловч хангалттай байж чадсангүй. 8-9 ангийн сурах бичиг дэх зургийн хүйсийн харьцаа 70/30 хувь. Эмэгтэй хүйсийг текстэн болон зурган дүрслэлээр илэрхийлсэн нь хангалтгүй. Текстэн мэдээлэлд эмэгтэй дүр гарч байгаа ч ээж, эмээ, эх хүн гэсэн дүрээр дүрслэгдсэн нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлж байна. Эх сурвалж болгон хэрэглэсэн эрдэмтэн, зохиолч, түүхэн хүний тоо 8-р ангийн сурах бичигт нийт 23, үүнээс эмэгтэй нь 2 (их сургуулийн багш, 1 нь гадаад хүн), 9-р ангийн сурах бичигт нийт 40, үүнээс эмэгтэй 1 (Катерин охин). Эрэгтэй дүрийг удирдагч,

147 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 119

148 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 98-99

манлайлагч байдлаар ихэнхдээ дүрсэлсэн бол эмэгтэй дүрүүдийг ээж, эмээ, эх хүн гэж дүрсэлсэн байна. Мөн өнгөний хувьд эрэгтэйг цэнхэр, эмэгтэйг ягаан өнгөөр ихэвчлэн дүрсэлсэн байна.¹⁴⁹ Үүний улмаас хөвгүүдэд эрэгтэй хүн боловсролоос үл хамааран удирдагч, манлайлагч байдаг гэсэн хэвшмэл ойлголт бий болох хоруу чанартай бөгөөд өөрсдийгөө ямар ч тохиолдолд охидоос илүү гэж үзэх хандлагатай болох эрсдэлтэй юм. Энэ нь хөвгүүдийн боловсрол эзэмшихэд хичээл зүтгэл гаргах, хариуцлагатай хандах сэдлийг унтраах магадлалтай байдаг. Харин 10-р ангийн сурах бичигт эмэгтэй хүнийг эдийн засгийн чадавхаа тооцоолох, ойр холын тооцоо төлөвлөгөөтэй байх тухай сургасан байна.¹⁵⁰ Энэ нь эмэгтэй хүний гэр бүлийн орлогод гүйцэтгэх үүрэг нь зөвхөн өрхийн орлогыг тооцоотой захиран зарцуулахаар хязгаарлагдах мэт ойлгогдохоор байна. Мөн үүнээс улбаалаад эрэгтэй хүн өрхийн орлогоо бүрдүүлэх ёстой мэт ойлголт, дүгнэлт бий болох магадлалтай юм. 11-р ангийн сурах бичигт “хөвгүүд өөр хоорондоо зодолдож байгаа”, “эрэгтэй дүр нохой зодох, охин дээрэлхэх, чавхаар шувуу харвах, бусдын эд зүйл сүйтгэх гэх мэт дүрслэлийг оруулсан нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэх¹⁵¹, хөвгүүдийн хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм. 12-р ангийн сурах бичигт мэргэжил сонголт, мэргэжлээ зөв сонгох агуулгын хүрээнд эмч, багш, цагдаа гэсэн мэргэжлүүдийн талаар 34-60 хуудас хүртэл дасгал ажил, тайлбар, зураг голлон оруулсан нь мэргэжлийн олон төрлүүд, шинээр нэмэгдэж буй мэргэжлийн нэр төрлүүд, устаж буй мэргэжлүүдийн талаар мэдэх боломжийг хязгаарласан. Дээрх мэргэжлүүдийг илэрхийлсэн зураг, дүрслэл нь эмч, багш- эмэгтэй, цагдаа- эрэгтэй гэсэн жендэрийн хэвшмэл байдлаар дүрслэгдсэн байна.¹⁵² Үүний улмаас хөвгүүдийн мэргэжил сонголтод жендэрийн хэмшмэл ойлголт нөлөөлөх, ялангуяа академик боловсролтой салшгүй холбоотой мэргэжлүүдийг сонгохгүй байх асуудал үүсч болох юм. Үүнтэй холбоотойгоор сурах бичиг боловсруулах процесс, сурах бичигт тавигдах жендэртэй холбоотой агуулгын шаардлагын талаар авч үзвэл Монгол Улсад боловсролын болоод сурах бичиг боловсруулахтай холбогдох харилцааг Боловсролын тухай хууль, БСШУЯ-наас 2019 онд гаргасан “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр” болон, “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS 2054:2008” стандарт”-аар зохицуулж байна. Эдгээр баримт бичигт сурах бичгийн агуулгад хүний эрх, жендэрийн тэгш эрхийн үзэл санаа тусгах талаар тодорхой зохицуулалт үгүй, харин Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 12.5-д “Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно” хэмээн заасан байна.¹⁵³ Гэсэн хэдий ч сурах бичиг боловсруулах процесст жендэрийн эрх тэгш байдлын үүднээс агуулгын хяналт хийх үе шат байхгүй нь чанарын судалгааны үр дүнд тодорхой болсон.

149 “БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, ЕБС-ийн 6-12-р ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичгийн агуулгад хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ (2023), 18-19

150 Мөн тэнд, 19

151 Мөн тэнд, 20

152 Мөн тэнд, 21

153 Мөн тэнд, 6

ЕБС-ийн сурах бичиг боловсруулахдаа ажлын хэсгийг жендэрийн сургалтанд хамруулдаг. Жендэрийн мэргэжилтнүүдээр агуулгын хяналт хийлгэх процесс байхгүй.

Төрийн төлөөлөлтэй хийсэн ярилцлага

Иймд улсын хэмжээнд сургуулийн орчинд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлдэггүй, сурах бичиг дэх агуулгад жендэрийн эрх тэгш байдлын үүднээс хяналт хэрэгжүүлдэггүйгээс улбаалж агуулга нь жендэрийн мэдрэмжгүй, хэвшмэл ойлголтыг бий болгохоор байна. Энэ нь хөвгүүдийн төсөөлөл, үнэлэмж, сурах хүсэл эрмэлзэлд нөлөө үзүүлэхээр байна.

5. Мэргэжлийн эрэгтэй багшийн дутагдал

Чанарын судалгааны үр дүнд хөвгүүд ихэвчлэн эрэгтэй багш нарын ордог биеийн тамир, нийгмийн ухаан, түүх гэх мэт хичээлүүддээ сонирхолтой болох нь тогтоогдсон. Учир нь хөвгүүд өөртэйгөө ижил хүйсийн багш нартай ойр дотно харилцаа бий болгоход хялбар бөгөөд тэдний боловсролын оролцооноос үлгэр жишээ авдаг байна. Гэвч БШУЯ-ны 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг авч үзвэл нийт улсын хэмжээнд эрэгтэй багшийн тоо 6652, эмэгтэй багшийн тоо 30341 байна.¹⁵⁴ Энэ нь эрэгтэй багш эмэгтэй багшаас 4.5 дахин бага гэдгийг илтгэх бөгөөд ЕБС-ийн багшийн тоо жендэрийн тэнцвэргүй байна. Тиймээс хөвгүүдэд үлгэр жишээ болох эрэгтэй багшийн тоо хангалтгүй байна.

Манай ангийн хөвгүүд биеийн тамир, түүх, нийгмийн ухааны хичээлдээ идэвх, оролцоо өндөр, гүйцэтгэл сайн байдаг. Манай сургуулийн хувьд тэдгээр хичээлийн

Иймд хөвгүүдэд үлгэр жишээ болох эрэгтэй багш хангалтгүйгээс хөвгүүдийн боловсролын оролцоо буурах магадлалтай байна.

6. Хөвгүүдийн онцлогт тохироогүй сургалтын хөтөлбөрийн бодлого

Хөвгүүдийн сурах онцлог олон зүйлд нэгэн зэрэг төвлөрөхөөс илүүтэй цөөхөн зүйлд төвлөрч суралцах байдаг гэдэг нь судалгаанд оролцогчдын ярилцлагаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл хөвгүүд хэдэн хэрэгтэй гэж үзсэн хичээл, гүнзгийрүүлж судлах хичээлдээ түлхүү анхаардаг, хэрэггүй хичээлээ тасалдаг, анхаарал хандуулдаггүй, олон төрлийн хичээлээс залхдаг, анхаарал суларч ирдэг онцлогтой болохыг доорх судалгааны бүх бүлгийн ярилцлагад дурджээ.

154 Боловсролын яам, Бага дунд боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээ, <https://www.meds.gov.mn/post/152276> Сүүлд хандсан 2024.09.6

Хөвгүүд зөвхөн нэг төрлийн хичээлдээ илүү бэлддэг. Охид өөрсдийгөө нухдаг, удаан суудаг.

Боловсролын хүрээлэн, хөтөлбөр, сурах бичиг хариуцсан эрдэм шинжилгээний ажилтнууд

Охид хичээлдээ сайн байдаг. Эмэгтэй хүүхэд хичээлдээ анхаарал тавих илүү, эрэгтэйчүүд хэнэггүй хандах тал байдаг. Эрэгтэй хүүхэд нэг хичээлд илүү сайн байдаг, Харин эмэгтэй хүүхэд бүх хичээлдээ ижил суралцдаг.

Бүлгийн ярилцлага, Хөвгүүд¹⁵⁵

Эрэгтэй хүүхэд олон хичээл ороод, олон өөр багштай харьцаад ирэхээр, өөрийн онцлогоос болоод уу ихэнх хичээлээ хаяж эхэлдэг. Тэгээд л заримдаа хөвгүүдийн сурлага дунд ангиас муудаж эхэлдэг. Тийм болохоор нэгэнт хичээлдээ муу учраас багш нар ч нэг их тулж ажиллахаа болиод арай ялгаатай хандаад байх шиг байдаг.

Бүлгийн хэлэлцүүлэг, Багануур дүүрэг, эцэг эхчүүд¹⁵⁶

Иймд бага ангиас дунд анги руу шилжих үеэс эхлэн шаардлагатай бус олон хичээлүүд нэмэгддэг нь хөвгүүдийн суралцах онцлог болох нэг зүйлдээ гүнзгийрэн төвлөрөх сонирхол, хэрэгцээнд тохирохгүй байснаар сурахаас залхах, хичээлээс хөндийрөх зэрэг үр дагаварт хүргэх магадлалтай байна.



155 Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016), 105

156 Мөн тэнд, 108

БҮЛЭГ 3: ХӨВГҮҮДИЙН БОЛОВСРОЛООС ХӨНДИЙРЧ БУЙ АСУУДАЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН САЙН ТУРШЛАГА

Энэ хэсэгт бусад улсуудад амжилттай хэрэгжүүлсэн, сайн жишиг болохуйц микро, мезо, макросистемийн түвшний бодлого, төсөл, хөтөлбөр, санаачлагуудын талаар авч үзнэ. Микросистемийн хүрээнд хөвгүүд, эцэг эхчүүд, үе тэнгийнхэнд чиглэсэн бодлогууд хамаарна. Мезосистемийн хүрээнд багш нарт чиглэсэн бодлогоос гадна сургуулиудын сурагчдад чиглэсэн бодлогууд багтана. Харин Макросистемийн хүрээнд улсын хэмжээний нэгдсэн бодлогын асуудлуудыг авч үзнэ.

МИКРОСИСТЕМ

- Австрали улсад хэрэгжүүлсэн The Breaking The Man Code хөтөлбөр нь хөвгүүдийн тусламж эрэлхийлэх зан үйлийг дэмжих, эрэгтэй хүний хор хөнөөлтэй хэм хэмжээнд нийцэх байдлыг бууруулах, нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, сэтгэлзүйн хямрал, амиа хорлох эрсдлийг бууруулах үндсэн зорилготой 2 цагийн воркшоп юм. Үүний хүрээнд нь “эр хүний код” гэгддэг эрэгтэйчүүдийн нийгмийн хүлээлт, түүний сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар нээлттэй ярилцдаг. Сургалтууд нь сурагчдыг өөрсдөдөө болон бусдад эрүүл, дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэхийн тулд эдгээр хэм хэмжээнд эргэлзэж, дахин тодорхойлоход түлхэц өгдөг.¹⁵⁷
- Premier League Reading Stars (PLRS) Англид хэрэгждэг хөтөлбөр бөгөөд хөлбөмбөгийн спортод сонирхолтой охид, хөвгүүдийг ном уншихад татан оролцуулж, тэдний бичгийн чадварыг дээшлүүлэх зорилготой. Үүний тулд ном, мэдээний нийтлэл, онлайн үйл ажиллагаа зэрэгт хөл бөмбөгтэй холбоотой агуулгыг ашигладаг. Хөтөлбөр нь 10 цагийн хичээлээр дамжин хэрэгждэг. Хичээл бүр нь ойлгох, дүгнэлт хийх, баримт ба үзэл бодол, онлайн текстийг үнэлэх зэрэг янз бүрийн ур чадварт анхаарлаа хандуулдаг

бөгөөд сурагчдын сонирхлыг татахын тулд янз бүрийн интерактив, хөгжилтэй сорилтуудыг багтаадаг. Хөтөлбөрт хамрагдсан сургуулиуд ном, багшийн гарын авлага, сурагчдын ном, хөл бөмбөгийн сэдэвт бичиг хэрэг зэрэг олон төрлийн эх сурвалжийг авдаг. Эдгээр материалууд нь анги дотроо болон гэртээ уншихад зориулагдсан. Энэхүү хөтөлбөр нь ном унших хөвгүүд эсвэл эрэгтэйчүүдэд зориулагдаагүй гэсэн хэвшмэл ойлголтыг халдаг учраас амжилттай хэрэгждэг байна.¹⁵⁸

- Герман улсад New Paths for Boys and Boys' Day-ийг зохион байгуулдаг. Хөвгүүдэд жендэрийн мэдрэмжтэй ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байртай холбоотой хэвшмэл ойлголтыг арилгах зорилготой. Эрэгтэйчүүдийн 40 гаруй хувь ажилладаг, тэр дундаа эрүүл мэнд, халамжийн салбар дахь ажил мэргэжлийг дэмждэг. Онол, практикийг солилцох бага хурал зохион байгуулдаг. 2008 оноос хойш 300,000 гаруй хөвгүүд Хөвгүүдийн өдрийн арга хэмжээнд оролцжээ. Үнэлгээгээр хөвгүүдийн 61 хувь нь тэдний оролцоо, тэдний ажил мэргэжлийн шийдвэр гаргахад тустай гэж үзсэн бөгөөд оролцогч компани, байгууллагуудын 89 хувь нь хөвгүүдийн сонирхол, оролцоо сайн байна гэж хариулжээ.¹⁵⁹
- Их Британи улс Stand Out Boys Project (SOBP) гэх хөвгүүдэд зориулсан төслийг 9 дэх жилдээ амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь сурахад саад болох шинж чанаруудыг харуулсан хөвгүүдэд чиглэж, сурлагын амжилтгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Жишээлбэл, харилцааны ур чадвар багатай, амархан уурладаг, багшаас заавар авах хүсэлгүй, амархан анхаарал сарнидаг, өөрийгөө хянах чадвар муутай гэх мэт зан чанаруудын заримыг нь харуулсан хүүхдүүдийг тодорхойлдог. Үүнд эцэг эх, багш нарыг татан оролцуулах бөгөөд хүүхдийн зан төлөв, суралцах чадварыг хөгжүүлэх стратеги (хоёуланд нь) санал болгодог. Ингэснээр хүүхдүүдийн зан төлөвт харьцангуй хурдан бөгөөд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, улмаар тэдсурах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгааг олж харсан.¹⁶⁰
- Швед улсад хэрэгжсэн las for mey, pappa (Read to me, Daddy) хөтөлбөр нь аавуудад зориулсан хөтөлбөр бөгөөд аавуудад хүүхдийнхээ ном унших дадлыг сайжруулах талаар зөвлөгөө өгдөг.¹⁶¹
- Колумбид тусгайлсан сургалтын хөтөлбөрийг үе тэнгийн бүлэг, эцэг эхийн семинартай хослуулсан Aulas en paz (анги дахь энх тайван байдал) хөтөлбөр нь хүчирхийлэл, дээрэлхэх явдлыг бууруулсан байна. Энэ нь нийгэм-сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэх замаар сурагчдын дунд энх тайвнаар зэрэгцэн орших, түрэмгийллээс урьдчилан сэргийлэх зорилготой боловсролын хөтөлбөр юм. Үүнд сурагчдын нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, хүчирхийлэлгүй харилцааг дэмжихэд чиглэсэн сургалтууд, үе тэнгийнхний уулзалтууд, боловсролын үйл явцад

158 Ibid, 84

159 Ibid, 94

160 Boys' Development Project, <https://www.boysdevelopmentproject.co.uk/programs>

161 UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022), 84

эцэг эхчүүдийг татан оролцуулж, гэр бүлийн амар тайван орчинг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой семинарууд багтсан. Хөтөлбөрийн үр дүнд оролцогч сурагчдын түрэмгий зан авир буурч, нийгмийн ур чадвар сайжирч байсан.¹⁶²

МЕЗОСИСТЕМ

- Швед улс багш нарт жендэрийн мэдлэг олгох сургалт явуулдаг. Мөн Австралийн Queensland муж улс тэгш хамруулан сургах онлайн сургалтуудыг санал болгодог. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн жендэрийн хэвшмэл ойлголтыг хэрхэн арилгах талаар зөвлөгөө өгдөг Gender Click in Preschool нэртэй товхимолыг мөн багш нарт тараадаг байна.
- Кувейт улсад хэрэгжүүлдэг хичээлээс гадуурх албан ёсны үйл ажиллагаа бол “Үнэт зүйлийг дэмжих төсөл” юм. Энэхүү төсөл нь яамны үйл ажиллагаа, боловсролын хөгжлийн газрын хяналтан дор хэрэгждэг. Сурагчдад шударга байх, бусдыг хүндлэх, тууштай байх зэрэг ёс суртахууны үнэт зүйлсийг төлөвшүүлэхийн зэрэгцээ залхуурал, хууран мэхлэлт, дээрэлхэх зэрэг зан үйлийг арилгах зорилготой юм. Яамнаас сургуулиудад үнэт зүйлс, зан төлөвийн хүснэгтийг багтаасан товхимол тараадаг. Эрхлэгч, багш нар эдгээр үнэт зүйлсийг хэрэгжилтэд өглөөний хурал, семинар, үзэсгэлэн, хэвлэл зэрэг олон арга замаар бэлтгэдэг. Хичээл бүрийн эхэнд багш нар сурагчдад үнэи зүйлийн талаар ярилцах цагтай байдаг. Эдгээр үнэт зүйлсээр сурагчдын дунд тэмцээн зохион байгуулж, ялагчдад шагнал гардуулдаг. Энэ төсөл нь сурагчдын сурлагын амжилтад сөргөөр нөлөөлж буй ёс зүй, зан төлөвийн зарим асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтойг захирал, багш нар онцолж байсан.¹⁶³
- Кувейт улсын Al-Jahra бүс нутгийн хөвгүүдийн сургуульд “Боловсролын цэцэрлэгт хүрээлэн” төсөл хэрэгжсэн. Энэ нь сургуулийн тавилгатай цэцэрлэгт хүрээлэн бөгөөд багш нар сурагчдад ургамал, цэцэг, усан оргилуурын дунд хичээл зааж, сурагчдад ундаа, зууш өгдөг. Энэхүү төсөл нь анги танхимын нэгэн хэвийн уур амьсгалыг өөрчлөх, хөвгүүдийн сургуулийн оролцоог сайжруулах, таатай орчинг бүрдүүлэх, тэдний сурах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, улмаар сурлагын амжилтыг сайжруулах зорилготой. Төслийн үр дүнд хөвгүүдийн сэтгэцийн эрүүл мэнд сайжирч, сургууль завсардалт буурч, сургалтын гүйцэтгэл сайжирсан зэрэг ихээхэн эерэг үр дүн гарсан байна.¹⁶⁴

162 Ibid, 81

163 UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Kuwait case study (2022), 47

164 Ibid, 48

МАКРОСИСТЕМ

ЭЗХХАБ (OECD)-аас бэлтгэсэн PISA 2022-оны тайланд үнэлгээнд оролцогч улс орнууд ямар боловсролын бодлого хэрэгжүүлэх нь үр дүнтэй талаар зөвлөжээ.¹⁶⁵ Үүнд бүх нийтэд чиглэсэн бодлого (universal policy), зорилтот бодлого (targeted policy) хамаарч байна. Энэ талаар доорх хэсэгт дэлгэрүүлэн авч үзлээ.

Бүх нийтэд чиглэсэн бодлого- Сурагчдын нийгэм, эдийн засгийн статус нь сурлагын амжилтад төдийлөн нөлөөлдөггүй боловсролын тогтолцоонд нийтлэг бодлого илүү тохиромжтой. Өөрөөр хэлбэл сурагчдын гүйцэтгэл болон нийгэм-эдийн засгийн статусын хоорондын хамаарал харьцангуй сул (эзлэх хувь нь ЭЗХХАБ-ын дунджаас доогуур) улсуудад тохиромжтой. Нийтлэг бодлого нь нийт тогтолцоонд ижил тэгш хэрэгжүүлсэн шинэчлэлээр дамжуулан бүх хүүхдийн боловсролын түвшинг дээшлүүлж, гүйцэтгэлийг сайжруулахад чиглэгддэг. Үүнд, жишээлбэл, иж бүрэн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, эсвэл багш нарын судлагдахууны мэдлэг, сурган хүмүүжүүлэх ур чадвар, янз бүрийн чадвартай сурагчдыг сургах арга зүйг сайжруулахын тулд тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, сургалт явуулах зэрэг хамаарна. Нийтлэг бодлогын хүрээнд бүх сургуулиудад чанартай сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, цахим нөөц, технологийг хүртээмжтэй байлгах нь үр дүнтэй сургалтыг дэмжихэд чухал ач холбогдолтой юм. Энэхүү бодлого PISA 2022 үнэлгээнд оролцсон 47 улсад үр дүнтэй хэрэгжих боломжтой. Үүнээс өндөр гүйцэтгэлтэй Хонконг (Хятад), Макао (Хятад) зэрэгт үр дүнтэй хэрэгжих магадлал өндөр байна. (Зураг 1)

Зорилтот бодлого- Үүний эсрэгээр зорилтот бодлого нь тодорхой сурагчдын бүлэгт чиглэсэн бодлого юм. PISA-ын бодлогын хүрээнд гурван төрлийн зорилтот бодлогыг авч үздэг: бага гүйцэтгэлтэй сурагчдад (“гүйцэтгэл- зорилтот”) эсвэл нийгэм-эдийн засгийн хувьд бэрхшээлтэй сурагчдад (“нийгэм-эдийн засаг-зорилтот”) эсвэл хоёуланд нь нөөц, хүчин чармайлтаа чиглэх бодлогууд юм.

Гүйцэтгэлийн зорилтот бодлого нь нийгэм-эдийн засгийн статусаас үл хамааран хамгийн бага гүйцэтгэлтэй сурагчдын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэгддэг. Бодлогын зорилго нь сурагчдын сурлагын амжилтад тулгуурлан бүх сурагчдад тэгш суралцах боломжийг олгох, тусгайлсан болон нэмэлт сургалтын нөөцөөр хангах юм. Гүйцэтгэлд чиглэсэн бодлого нь сурагчид, сургууль эсвэл хэд хэдэн сургуульд зориулан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц гүйцэтгэлийн зорилтуудыг тодорхойлохоос эхэлдэг. Эдгээр нь төрөл бүрийн хэлбэртэй байж болно. Жишээлбэл, нэмэлт сургалт өгөх эсвэл багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх гэх мэт. Сургууль доторх арга хэмжээ нь хамгийн нийтлэг хандлага бөгөөд зарим улсад сурагчдын хоцрогдол, хичээл таслалтыг бууруулах үр дүнтэй болохыг нотлох баримтууд харуулж байна. Үүний тулд эцэг эхийн оролцоо чухал. Бусад нөхцөл байдалд, сургалтын дэмжлэг, хичээл зүтгэлд суурилсан тэтгэлэгт

165 PISA 2022 Results (Volume I) The State of Learning and Equity in Education, 131-136, https://www.oecd-ilibrary.org/education/pisa-2022-results-volume-i_53f23881-en Last accessed 2024.09.6


хөтөлбөрүүд нь сурлагын амжилт муутай сурагчдыг хүсэл эрмэлзэлтэй болгоход үр дүнтэй байдаг. PISA 2022-д оролцсон 11 улсад нь гүйцэтгэлд чиглэсэн бодлого үр дүнтэй хэрэгжих болно. Эдгээрийн зарим улсад сургуулиуд дахь амжилт муутай сурагчдын төвлөрөл ЭЗХАХБ-ын орнуудын дунджаас өндөр байдаг бол бусад улсад сургуулиуд дахь амжилт муутай сурагчдын төвлөрөл нь ЭЗХАХБ-ын орнуудын дунджаас доогуур байдаг. Тиймээс энэхүү бодлогын хүрээнд сургуульд төвлөрөх эсвэл хувь сурагчид төвлөрөх нь тухайн улсын нөхцөл байдлаас шалтгаалах юм. (Зураг 1)

Нийгэм-эдийн засгийн зорилтот бодлого нь нийгэм-эдийн засгийн статус доогуур сурагчид болон сургуулиудад нэмэлт нөөц, дэмжлэг, туслалцаа үзүүлэх замаар боловсролын тэгш бус байдлыг арилгах зорилготой. Жишээлбэл, зарим улс оронд сургалтын цагийг нэмэгдүүлж, багш сурагчтай харилцах цагийг тухайн зорилтот бүлгийн сурагчдад ашигладаг. Эдгээр нь суралцах явцыг хурдасгадаг. Бусад бодлого нь илүү цогц бөгөөд сурагчдад үнэ төлбөргүй хоол, сурах бичиг өгөх, ядуу өрхүүдэд шууд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр анги танхимаас гадуур тэгш бус байдлыг арилгахад чиглэдэг. Нийгэм-эдийн засгийн зорилтот бодлого найман улсад үр дүнтэй байх магадлалтай. Эдгээр улсад онооны зөрүү их биш хэдий ч сурагчдын нийгэм, эдийн засгийн статус нь тэдний гүйцэтгэлтэй нягт холбоотой байдаг. Эдгээр найман улсын долоод нь тухайн бүлгийн сурагчдын төвлөрөн сурдаг сургуулийн тоо дунджаас өндөр байна. Тиймээс Эдгээр сургуулиудад чиглэсэн бодлого нь илүү үр нөлөө үзүүлэх магадлалтай. (Зураг 1)

Холимог зорилтот бодлогын зорилго нь хангалтгүй гүйцэтгэл, нийгэм-эдийн засгийн саад бэрхшээлийг арилгахад тохирсон сургалтын нөөцөөр хангах зорилтот бодлогоор дамжуулан сурагчдын гүйцэтгэлийн зөрүүг багасгахад оршино. Тухайлбал, энэ бүлгийн зарим улс орнууд багш нарт илүү сайн дэмжлэг үзүүлэх, мэргэжил дээшлүүлэх, нийгэм-эдийн засгийн статус доогуур бүс нутгийн сургуулиудад чадварлаг багш нарыг ажиллуулах зэргийг хэрэгжүүлж үр дүнд хүрэх боломжтой. Бага орлоготой хорооны сургуулиудад илүү их нөөц хуваарилах санхүүжилтийн бодлого хэрэгтэй. Мөн сургуульд өөр өөр сурах арга барилтай, нийгэм-эдийн засгийн янз бүрийн түвшний хүүхдүүд суралцдаг тул олон янз байдлыг дэмжсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь чухал юм. Нийгэм-эдийн засгийн саадтай эсвэл гүйцэтгэл муутай сурагчдын боловсролын ялгаатай хэрэгцээг хангаж чадсан сургуулиуд нь ихэвчлэн холимог сургалтын орчныг бий болгож, хэрэгцээтэй сурагчдад материаллаг болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Бусад стратегид багш нарын тусгай сургалт, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд, түүнчлэн сурагчдын гүйцэтгэлийн өөрчлөлт, бодлогын ерөнхий хэрэгжилтийг тасралтгүй хянах зэрэг багтана. PISA 2022-д оролцсон 10 улсад холимог бодлого үр дүнтэй хэрэгжих магадлалтай. (Зураг 1)

Зураг 1. PISA 2022 үнэлгээнд оролцогч улсуудад тохиромжтой боловсролын бодлого

Figure I.4.13. Strength and slope of the socio-economic gradient



Notes: Only countries and economies with available data are shown. The socio-economic status is measured by the PISA index of economic, social and cultural status. Source: OECD, PISA 2022 Database, Tables I.B1.2.1 and I.B1.4.3.

OECD PISA 2022- тайланд зөвлөсөн боловсролын бодлогоос гадна бусад улсуудад амжилттай хэрэгжүүлсэн макросистемийн түвшний бодлогыг доорх хэсэгт авч үзлээ.

- Аргентин улсад хэрэгждэг School Bridge Programme нь орон гэргүй, эмзэг бүлгийн охид, хөвгүүдийг боловсрол эзэмших боломжоор хангах зорилготой хөтөлбөр юм. Хөтөлбөр нь түргэвчилсэн сургалтын хөтөлбөрөөр боловсролын системд эргэн нэгтгэхэд анхаардаг. Хичээлийн хөтөлбөр нь богино хугацаанд олон хичээлүүдийг багтаасан, эрчимжүүлсэн байдаг. Жишээлбэл, сурагчид хоёроос тавдугаар ангийн сургалтын агуулгыг ойролцоогоор 40 сарын дотор авч болно. Сургалтын хөтөлбөрт математик, англи хэл, байгалийн ухаан зэрэг үндсэн хичээлүүд багтдаг.¹⁶⁶
- Rural Secondary School Pedagogical Support (RSPS)-ийг Перу улсын боловсролын яамнаас хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн зорилго нь багш, сурагчдыг дэмжихэд чиглэсэн янз бүрийн стратегиар дамжуулан хөдөөгийн ерөнхий боловсролын сургуулийн боловсролын чанарыг дээшлүүлэхэд чиглэдэг. Хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутгийн багш нарын сурган хүмүүжүүлэх ур чадварыг дээшлүүлэх тасралтгүй сургалтууд явагддаг. Хөдөө орон нутгийн сурагчдын хэрэгцээ, нөхцөл байдалд

тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцөөр хангадаг. Жишээлбэл, илүү туршлагатай багш нар бусад багш нарт зөвлөх мэнторшип хөтөлбөрөөр дамжуулан математик, харилцааны чиглэлд багш нар, удирдлагын багийн гүйцэтгэлийг нэмэгдүүлсэн. Сургуулийг гэр бүл, олон нийттэй холбосон. Мөн математик, харилцааны чиглэлд сургуулийг сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцөөр хангаж сурагчдыг хичээл, олон нийтийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцохыг уриалдаг.¹⁶⁷

- Их Британид хэрэгжиж буй “ядуу” гэж тодорхойлсон сурагчдад боловсролын санхүүжилтийг илүү хуваарилах бодлого нь сайн жишиг боловч сурагчдын хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлэх шаардлагатай тулгарч байсан.



ДҮГНЭЛТ

Монгол Улсад ерөнхий боловсролын түвшинд хамран сургалт харьцангуй өндөр байгаа хэдий ч бүрэн дунд боловсролд хөвгүүдийн сургуульд хамрагдалт охидоос доогуур, сурлагын амжилтаар хоцрогдож, боловсролын шат түвшнээр дээш ахихгүй байгаад микро, мезо, макросистемийн хүчин зүйлүүд нөлөөлж байна. Мөн тэдгээр хүчин зүйлүүдийн хэд хэдэн давхцал бий болж байгаа нь салбар дундын бодлого шаардлагатайг харуулж байна. Энэ талаар судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Микросистемийн түвшинд:

- Хувь хүнээс хамаарч буй хөвгүүдийн утасны зохисгүй хэрэглээ, спортыг хичээлээс илүү чухалчлах хандлага нь эцэг эхийн үл хайхрал, жендэрийн хэвшмэл ойлголтой холбогдож сурлагын амжилтад нөлөөлж байна.
- Эцэг эхийн жендэрийн хэвшмэл ойлголт нь хөвгүүдийн боловсролыг дэмжихгүй байх, тэдний боловсролын үнэлэмжид нөлөөлөх, охид хөвгүүдэд ялгаатай чадвар суулгаснаас хөвгүүдэд сул тал бий болох үр дагаварт хүргэж байна. Мөн хөвгүүдийн боловсролд идэвхтэй оролцохгүй байх, хөвгүүдтэй ойр дотно, эерэг хүмүүжлийн арга барилаар харилцахгүй байгаа явдал нь тэдний жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой. Түүнчлэн хөвгүүдийн хүмүүжил, боловсролын оролцоонд аавын үүрэг хангалтгүй байгаа нь салбар дундын анхаарах асуудал болж байна.
- Хөвгүүдэд үе тэнгийнхэн нөлөөлөл үзүүлэх хэдий ч дангаараа сурлагын амжилт, сургууль завсардахад нөлөөлөх тохиолдол нийтлэг бус үзэгдэл юм. Харин эцэг эх, сургуулийн орчин, хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжгүй байдал, эцэг эхийн үл хайхрал, сургуулийн сөрөг соёл, хөвгүүдэд тулгарч буй асуудалд авах хариу арга хэмжээ хангалтгүй байгаатай нэгдсэнээр нөлөөлөгч хүчин зүйл болно.

Мезосистемийн түвшинд:

- Монгол Улсын нөхцөл байдалд хөвгүүдийн боловсролын оролцоон дахь шашны нөлөөллийн шалтгаан нь шашны итгэл үнэмшил бус ядуурал байна. Тиймээс энэ нь боловсрол болон нийгмийн хамгааллын салбар дундын асуудал болж байна. Мөн уламжлалт соёлоос улбаатай сөрөг нөлөөлөл нь боловсрол болон соёлын салбарын зайлшгүй харгалзан үзэх асуудал юм.
- Сургууль хамран сургах тойргийн бүртгэл хийдэггүй, хөдөө орон нутагт нэгдсэн мэдээлэл байдаггүй нь хөдөөгийн малчин өрхийн хөвгүүдийн элсэлтэд илүү эрсдэл үүсгэж байна. Тиймээс хөдөө, орон нутгийн элсэлт, шилжилтийн бүртгэл мэдээллийн асуудлыг анхаарах зайлшгүй шаардлагатай байна.
- Сургуулийн орчны нөлөөлөл болох багшийн жендэрийн ойлголт, мэдрэмж, арга зүй, хүлээлт зэрэг нь хөвгүүдийн сурлагын амжилтад нөлөөлөгч томоохон хүчин зүйл болно. Гэхдээ энэ нь дангаараа шууд нөлөө үзүүлэхээс илүүтэй эцэг эхийн оролцоо бага, үл хайхралт, хичээлийн хэрэглэгдэхүүний нөөц, сурах орчны тав тух, багшийн ачаалал гэх мэт асуудлуудтай нэгдсэнээр нөлөө үзүүлэгч гол хүчин зүйл болох юм. Мөн сургуулийн орчин дахь хүчирхийлэл нь нийгмийн ажилтны чиг үүргээ хэрэгжүүлэх боломж, нөхцөл, эцэг эхийн оролцоо, үл хайхрамжтай нэгдсэнээр сөрөг нөлөө үзүүлж байна.
- Жендэрийн мэдрэмжгүй хэвлэл мэдээлэл нь нийгмийн сэтгэлгээнд ихээхэн нөлөө үзүүлж, дам байдлаар хөвгүүдийн боловсролын оролцоонд нөлөөлдөг тул боловсрол, хэвлэл мэдээллийн салбар дундын анхаарч үзэх асуудал болж байна.

Макросистемийн түвшинд:

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал нь хөвгүүдийн боловсролын оролцоонд нөлөөлөх чухал хүчин зүйл бөгөөд ядуурал, жендэрийн хэвшмэл ойлголт, албан бус хөдөлмөр эрхлэлтээс үүдэлтэй. Тиймээс энэхүү асуудал нь боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын анхаарч үзэх асуудал юм.
- Хөдөөгийн сургалтын чанар, нөөц хэрэглэгдэхүүн хангалтгүй гэх мэт хөдөө орон нутгийн сурагчдын олон сул тал нь орон нутгийн хөвгүүдийн хөдөлмөр эрхлэлт, жендэрийн хэмшмэл ойлголт, боловсролын үнэлэмж, төгсөөд орон нутагтаа мэргэжлээрээ ажиллах боломж зэрэгтэй давхцсанаар тэднийг боловсролоос хөндийрүүлж байна. Тиймээс энэхүү байршлаас үүдэлтэй асуудал нь боловсрол болон бусад салбарын анхаарал хандуулах, бодлого чиглэгдэх гол асуудал юм.

- Жендэрийн хэвшмэл ойлголт нь ихэнх нөлөөлөгч хүчин зүйлийн үндсэн шалтгаан болж байгаа тул боловсролын салбар дахь жендэрийн бодлого нь салбар дундын асуудал болж байна.
- Хөвгүүдийн боловсролд нөлөөлж буй боловсролын салбарын гол асуудал нь мэргэжлийн багш, ялангуяа мэргэжлийн эрэгтэй багшийн дутагдлаас гадна хөвгүүдийн онцлогт тохироогүй сургалтын хөтөлбөр, арга зүй байна. Иймд эдгээр асуудалд чиглэсэн бодлого зайлшгүй шаардлагатай.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Иймд Монгол Улсын хувьд шийдвэрлэх шаардлагатай асуудалд дараах саналыг дэвшүүлж байна.

Микро түвшинд:

- Эцэг эхчүүдэд зориулсан хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга барил, жендэрийн ойлголтын талаар сургалт зохион байгуулах.
- Хөвгүүдэд чиглэсэн жендэрийн хэвшмэл ойлголтыг халах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах.
- Хөвгүүдийн боловсрол эзэмших хүсэл, тэмүүллийг нэмэгдүүлэхэд туслах эрэгтэй мэргэжилтнүүдийн зөвлөгөө өгөх арга хэмжээ зохион байгуулах.

Мезо түвшинд:


- Сургуулийн орчинд сурагчдын утасны хэрэглээг багасгах бодлого боловсруулах.
- Сургуулиуд хамран сургах тойргийн бүртгэл хийх, түүнд аймаг, нийслэлийн боловсролын газар хяналт тавин ажиллах.
- Багш нарт жендэрийн талаар албан сургалт ордог болох.
- Сургуулийн орчин дахь хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургууль болгон дүрэм, журам, бодлогын баримт бичигтээ тусгах. Үүнд Боловсролын ерөнхий газраас хяналт тавин ажиллах.
- Сургуулиуд нийгмийн ажилтаныг хүүхэд хамгааллын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх боломжоор хангах.
- Сүм хийдэд шавилан сууж буй хөвгүүдийн сурч боловсрох эрхийн асуудалд хяналт, үнэлгээ хийх.
- Хурдан морь унаач хүүхдүүдэд зориулсан хичээлийн хоцрогдол арилгах нэмэлт сургалт, давтлагын арга хэмжээ зохион байгуулах.




- Дотуур байран дахь үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг авах арга хэмжээ дүрэм, журамд боловсруулах, багш, ажилчдад нийгмийн хамгааллын сургалт орох.
- Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирж буй хоцрогдолтой сурагчдад зориулан сургалт, давтлага орох арга хэмжээ зохион байгуулах.
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

Макро түвшинд:

- Нийгэм, эдийн засгийн статус доогуур эмзэг бүлгийн сурагчдад шалгуур үзүүлэлт тогтоон боловсролд хамрагдалтад шаардлагатай тэтгэмж олгох.
- Хөдөө орон нутгийн сургуульд оногдож буй төсөв болон бусад хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах, чанартай сургалт бий болгоход шаардлагатай төлөвлөлтийг хийх.
- Хөдөө, орон нутгийн багшийн мэргэжил, үр чадвараа дээшлүүлэх, сургалтад хамрагдахад гарч буй зардлыг төрөөс шийдвэрлэх.
- Багш дутагдлын асуудлыг шийдвэрлэхдээ, сургалтын чанарт нөлөөлөхөөргүй, үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх.
- Албан бус олимпиад, уралдааныг хязгаарлах, Боловсролын Яамнаас хяналт тавьж ажиллах.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжид охид, хөвгүүдийн ялгаатай суралцахуйн онцлогт тохирсон аргыг нэвтрүүлэх.
- Хөвгүүдийн дотоод чадвар, сонирхолд нийцсэн боловсролын орчин, хүлээлтийг бий болгох.
- БШУЯ-аас ЕБС-ийн орчинд жендэрийн нэгдсэн бодлого боловсруулж, сургуулиудад удирдамж, зөвлөмж хүргүүлэх.
- ЕБС-ийн сурах бичиг боловсруулахад жендэрийн үүднээс агуулгын хяналт хийдэг болох.
- Багшийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох.
- Мэргэжлийн эрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх тал дээр бодлого боловсруулах, тогтвортой оролдлого хийх.
- Улсын нэгдсэн бодлого тодорхойлоход шаардлагатай хүйсээр ангилсан статистик мэдээллүүдийг боловсруулах, бодлого боловсруулахад ашиглах.

ЗУРАГ. МОНГОЛ УЛСАД ХӨВГҮҮД БОЛОВСРОЛООС ХӨНДИЙРӨХӨД
НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС



-  Макросистемийн нөлөөлөл
-  Мезосистемийн нөлөөлөл
-  Микросистемийн нөлөөлөл

ОИ.МН
СУДАЛГААНЫ САН

Ном зүй

Гадаад хэлээр:

- Commonwealth of Learning, Boys' Underperformance in Education: Revisiting the issue in the Commonwealth (2017)
- Judith Mungoo, Gender and achievement in Botswana's basic education: Exploring boys' underachievement, African Educational Research Journal Vol. 5(2), pp. 99-108, April 2017
- OECD (2023), PISA 2022 Results (Volume I): The State of Learning and Equity in Education, PISA, OECD Publishing, Paris,
- Ullah, Raza, and Hazir Ullah. 2021. "Teachers' Perspectives on Boys' Underperformance in Education in Khyber Pakhtunkhwa, Pakistan". Journal of Elementary Education 14 (1)
- UNESCO, Fact Sheet no. 56. New Methodology Shows that 258 Million Children, Adolescents and Youth Are Out of School (2019)
- UNESCO, Leave No Child Behind: A Case Study of Fiji (2022)
- UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education Lesotho case study (2022)
- UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: United Arab Emirates case study (2022)
- UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Kuwait case study (2022)
- UNESCO, Leave no child behind: boys' disengagement from education: Peru case study (2022)
- UNESCO, Leave no child behind: Global report on boys' disengagement from education (2022)
- UNGEI, Changing Patterns in Boys' Education Discussion Summary (2016)
- USAID, Boys' underachievement in education: a review of the literature with a focus on reading in the early years (2016)

Монгол хэлээр:


- Боловсрол эвсэл, “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд нь тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан” (2020)
- Боловсрол эвсэл, “Амжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчийг сурах бололцоогоор хангах талаарх бодлого, түүний хэрэгжилт” (2021)
- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Дотуур байрны өнөөгийн байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаа (2024)
- “БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, ЕБС-ийн 6-12-р ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичгийн агуулгад хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ (2023)
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа (2019)
- Жендэрийн үндэсний хороо, Монголын хэвлэл мэдээллийн агуулга, үйл ажиллагаан дахь жендэрийн мэдрэмжтний байдал, тэгш байдлын шалгуур: Гарааны нөхцөл байдлын үнэлгээ (2021)
- Жендэрийн үндэсний хороо, Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендэрийн мэдрэмжид хийсэн үнэлгээ (2020)
- Жендэрийн үндэсний хороо, Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй (2021)
- Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ (2016)
- НҮБ-ын Хүүхдийн сан, Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх
- Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгааны тайлан (2020)
- ХЭҮК, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал (2024)
- ХЭҮК, Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа (2022)
- ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл
- ҮАГ, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн (2021)
- ҮСХ, Монгол Улсын хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (2023)
- ЮНЕСКО, Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ (2019)

Хавсралт 1. PISA 2022 үнэлгээний үр дүн

Унших чадвараар бүх улсын хөвгүүд охидоос доогуур гүйцэтгэлтэй байна. Харин математик, шинжлэх ухааны хичээлийн хувьд улс болгон өөр гүйцэтгэлтэй бөгөөд доорх хүснэгтэд ангилав.


Математикийн хичээлээр хөвгүүд охидоос илүү гүйцэтгэлтэй улсууд	Математикийн хичээлээр охид хөвгүүдээс илүү гүйцэтгэлтэй улсууд	Математикийн хичээлээр охид хөвгүүд ижил гүйцэтгэлтэй улсууд
Словак	Албаниа	Монтенегро
Малта	Жордан	Казахстан
Саудын араб	Филиппин	Косово
Швед	Жамайка	
Исланд	Бруней Даруссалам	
Панама	Малайз	
Молдав	Катар	
Румын	Арабын нэгдсэн эмират улс	
Солонгос	Индонез	
Литва	Хойд македон	
Польш	Тайланд	
Турк	Болгар	
Грек	Монгол	
Узбекистан	Гүрж	
Эстон	Финланд	
Эл салвадор	Бүгд найрамдах доминикан улс	
Хорват	Камбож	
Чех	Морокко	
Белги	Словени	
Бразил	Норвеги	
Япон	Кипр	
Колумб	Палестин	
Лавти	Баку (Азарбейжан)	

Франц		
Испани		
Вьетнам		
Шинэ зеланд		
Португал		
Недерланд		
Швецари		
Уругвай		
Серби		
Аргентин		
Израйл		
Австрали		
Герман		
Парагвай		
Денмарк		
Мексик		
Сингапур		
Канад		
Гуатемала		
Ирланд		
Америк		
Их британи		
Унгар		
Косто рика		
Перу		
Чили		
Австри		
Итали		
Тайвань		
Хонг Конг		
Украины бүсүүд (27-оос 18)		
Макао		



Шинжлэх ухааны хичээлээр хөвгүүд охидоос илүү гүйцэтгэлтэй улсууд	Шинжлэх ухааны хичээлээр охид хөвгүүдээс илүү гүйцэтгэлтэй улсууд	Шинжлэх ухааны хичээлээр охид хөвгүүд ижил гүйцэтгэлтэй улсууд
Панама	Албаниа	Белги
Эл салвадор	Жордан	Швецари
Бразил	Филиппин	Израйл
Япон	Жамайка	Герман

Колумб	Бруней Даруссалам	Хонг Конг
Латви	Малайз	
Испани	Катар	
Вьетнам	Арабын нэгдсэн эмират улс	
Недерланд	Индонез	
Уругвай	Хойд македон	
Аргентин	Тайланд	
Австрали	Болгар	
Парагвай	Монгол	
Денмарк	Гүрж	
Мексик	Финланд	
Сингапур	Бүгд найрамдах доминикан улс	
Канад	Камбож	
Гуатемала	Морокко	
Ирланд	Словени	
Америк	Норвеги	
Их британи	Монтенегро	
Унгар	Казахстан	
Косто рика	Словак	
Перу	Малта	
Чили	Саудын араб	
Австри	Швед	
Итали	Исланд	
Тайвань	Молдав	
Макао	Румын	
	Солонгос	
	Литва	
	Польш	
	Турк	
	Грек	
	Узбекистан	
	Эстон	
	Хорват	
	Чех	
	Франц	
	Шинэ зеланд	
	Португал	
	Серби	
	Косово	
	Украины бүсүүд (27-оос 18)	





“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН